

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 78
1.	<i>Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Эрүүл монгол хүний эрхийн баталгааг хангах талаар Эрүүл мэндийн сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх</i>	6 – 41
2.	<i>Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан</i>	41 – 78

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
11 дүгээр сарын 04-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 22 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Ш.Бямбасүрэн, Б.Түвшин, Д.Энхтуяа;
Чөлөөтэй: Н.Алтаншагай, Ц.Баатархүү, Д.Батлут, М.Ганхүлэг,
М.Нарантуяа-Нара;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан.*

Нэг.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Эрүүл монгол хүний эрхийн баталгааг хангах талаар Эрүүл мэндийн сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга Б.Цэцэгсайхан, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн дарга Б.Туяа, Санхүү, эдийн засгийн бодлогын газрын Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч Ш.Энхтуяа, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Д.Жаргалсайхан, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Л.Баттөр, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Г.Ууганцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Б.Цогзолбаяр, референт Б.Энхмаа, Үнэлгээ, мониторингийн газрын дарга Б.Алтантуяа, зөвлөх Б.Отгонсүрэн, референт Ц.Элбэгзаяа нар байлцав.

Асуулгын хариуг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн танилцуулав.

Асуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, А.Ариунзаяа, А.Ганбаатар, Д.Рэгдэл, М.Энхцэцэг, Д.Бум-Очир, О.Саранчулуун, Д.Ганмаа, С.Эрдэнэболд, Б.Хэрлэн, Б.Бейсен нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн хариулж, тайлбар хийв.

Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Эрүүл монгол хүний эрхийн баталгааг хангах талаар Эрүүл мэндийн сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэв.

Уг асуудлыг 16 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, мөн газрын Үнэлгээ, мониторингийн хэлтсийн дарга Б.Баярсүх, мөн хэлтсийн референт Д.Даваасамбуу, ахлах шинжээч Ш.Бумаажав, Боловсролын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга П.Төгсбаяр, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа, Боловсролын зээлийн сангийн ажлын албаны дарга О.Сийлэгмаа, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Бадамжав, Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч Ч.Баярмаа, Дээд мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газрын шинжээч Я.Номинцэцэг, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Ц.Нямсүрэн, Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Н.Буянтогтох, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, мөн яамны Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Ренчиндорж, Гэр бүлийн бодлогын газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн дарга А.Хишигбаяр, мөн газрын Гэр бүлийн хууль тогтоомж хариуцсан ахлах шинжээч М.Цогтбаатар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналтын газрын дарга Ч.Энх-Амгалан, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Туяа, мөн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга С.Эрдэнэтуяа, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Янжмаа, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын ахлах шинжээч Ш.Энхтуяа, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч С.Энхжин, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах, мөн газрын Эдийн засаг, судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Б.Цогзолбаяр, референт Б.Энхмаа,

Үнэлгээ, мониторингийн газрын дарга Б.Алтантуяа, зөвлөх Б.Отгонсүрэн, референт Ц.Элбэгзаяа нар байлцав.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан, А.Ариунзаяа, Д.Рэгдэл, Ж.Галбадрах, Б.Найдалаа, М.Энхцэцэг нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Найдалаа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 38 минут үргэлжилж, 29 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 69.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 22 минут

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Найдалаа: Сайн байцгаана уу? Өдрийн мэнд хүргэе.

Өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдааныг эхэлье.

2025 оны 11 сарын 04-ний хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдаанд ирсэн гишүүд А.Ариунзаяа гишүүн, Д.Бум-Очир гишүүн, Д.Ганмаа гишүүн, М.Сарнай гишүүн, С.Эрдэнэбат гишүүн, Б.Бейсен гишүүн, Ж.Галбадрах гишүүн, С.Зулпхар гишүүн, Д.Рэгдэл гишүүн, Л.Энхнасан гишүүн, Хөххүүгийн Болормаа гишүүн, А.Ганбаатар гишүүн, Т.Мөнхсайхан гишүүн, О.Саранчулуун гишүүн, М.Энхцэцэг гишүүн гээд нийт 29 гишүүнээс 16 гишүүн буюу 55.2 хувьтайгаар хуралдааны ирц бүрдсэн байна.

Өнөөдрийн хурлыг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Хэлэлцэх асуудал. Хоёр асуудал байгаа.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Эрүүл монгол хүний эрхийн баталгааг хангах талаар Эрүүл мэндийн сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх.

Хоёрдугаарт, Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос Эрүүл монгол хүний эрхийн баталгааг хангах талаар Эрүүл мэндийн сайдад хандсан асуулгын хариуг Улсын Их Хурлын гишүүн Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн танилцуулна.

Ж.Чинбүрэн сайдын микрофоныг нээе. Микрофон 4.

Танилцуулга эхлэхээс өмнө дэгийн бас нэг мэдээлэл байна. Дэгийн тухай хуульд Байнгын хорооны хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 3 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух гэсэн байгаа.

Тэгэхээр маш богино хугацаатай. Ж.Чинбүрэн сайд 3-хан минутад багтааж танилцуулах нь. Тэгээд Та бүхэнд танилцуулга хүрсэн байгаа болохоор ямар ч асуудалгүй гэж бодож байна.

Асуулт ч гэсэндээ 3 минут. Тодруулга байхгүй юм байна шүү. Гишүүд ээ.

Тэгэхээр 3 минутдаа багтааж асуух юм байна шүү. Санал, үг байхгүй. Тийм. Асуулт 3 минутад тодруулгагүй. С.Эрдэнэболд гишүүн асуулга тавьсан учраас үг хэлэх. Хамгийн сүүлд нь ганцхан гишүүн л үг хэлнэ.

Ингээд хуралдаа оръё.

**Нэг.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос
Эрүүл монгол хүний эрхийн баталгааг хангах талаар
Эрүүл мэндийн сайдад хандсан
асуулгын хариуг хэлэлцэх**

Ж.Чинбүрэн сайдыг урьж байна. Микрофон 4. Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Хүний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь хувь хүний цаг бус үхэлд хүргэж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйгээс ангид байлгах, нэр төртэй амьдрах нөхцөлөөр хангах ойлголтыг хамарсан өргөн хүрээний улс төр, нийгэм, эдийн засгийн асуудал юм.

Эдгээр эрхийн хэрэгжилтийг хангахын тулд хүн бүрд чанартай эрүүл мэндийн үйлчилгээг хэрэгцээтэй үед нь хаана амьдарч байгаагаас нь үл хамааран санхүүгийн хүндрэлгүйгээр хүрэх боломжийг бүрдүүлэх бодлогыг эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж ажиллаж байна.

Энэ хүрээнд эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн аргыг нэвтрүүлж, 2021 оноос нэг худалдан авагчийн тогтолцоо шилжсэн.

Ингэснээр тусламж, үйлчилгээний зардлыг зүйл ангиар санхүүжүүлдэг үр ашиг багатай тогтолцоог бүрэн халж, үзүүлсэн тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, чанарыг харгалзан гүйцэтгэлээр санхүүжүүлэх стратегийн худалдан авалтын тогтол зунд шилжсэн.

Үүний үр дүнд даатгуулагчдын эрүүл мэндийн холбоотой санхүүгийн хүндрэлээс хамгаалах чиглэлээр томоохон ахиц гарсан. Тухайлбал, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний зардлыг жилд 2 сая төгрөгөөр хязгаарладаг байсан бол үүнийг халж, 2024 онд Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр нэг хүн дээд тал нь 203 сая төгрөгийн тусламж, үйлчилгээ авсан байна.

Даатгалаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн нэр төрөл, хөнгөлөлттэй хувь хэмжээг нэмэгдүүлсний үр дүнд эмийн үнийн хөнгөлтийн зардал сүүлийн 5 жилд 3.3 дахин өссөн байна.

Түүнчлэн зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн иргэд эмчилгээний зардлын 5 хувийг буцаан олгодог байсныг хүүхэд 50 хүртэлх хувь, насанд хүрэгчдэд 20 хүртэл хувь болгон санхүүгийн дэмжлэгийг хувь хэмжээг 4-өөс 10 дахин нэмэгдүүлсэн.

Гэвч гүйцэтгэлээр санхүүжүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудад болон Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр жил тутам өсөн нэмэгдэж байгаа нь манай салбар санхүүгийн удирдлага, сахилга бат сул байгаатай холбоотой.

Иймд төсвийн сахилга батыг сайжруулах, төрийн өмчийн эмнэлгүүдийн орон тоо, үр ашгийн зардлыг бууруулахад нэн түрүүнд анхаарч байна.

Цаашид эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх, Эрүүл мэндийн даатгалын сангаас зөвхөн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг бүрэн хариуцаж, шаардлагагүй тусламж, үйлчилгээг хумих, урьдчилан сэргийлэх боломжтой зарим өвчтөний иргэний төлөх төлбөрийн хэмжээг зохистой түвшинд тогтоох зэргээр санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх бодлогыг тодорхойлон ажиллаж байна.

Төрөөс эрүүл мэндийн талаар хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ үр дүнгээ өгч, 20 жилийн өмнөхтэй харьцуулахад монгол хүн -

- ▶ 6.5 жилээр урт насалж,
- ▶ эхийн эндэгдлийн түвшин 4 дахин,
- ▶ хүүхдийн эндэгдлийн түвшин 2 дахин буурч,

дэлхийн дунджаас доогуур түвшинд хүрсэн байна.

Мөн халдварт бус өвчний шинэ тохиолдол нэмэгдэж байгаа хэдий ч нас

баралт, тухайлбал зүрх судасны өвчний шалтгаант нас баралт 38 хувиар буурсан нь өвчнийг эрт илрүүлэх, хяналтыг сайжруулсны үр дүн юм.

- ➔ Гэсэн хэдий ч эрүүл мэндийн тулгамдсан асуудал цөөнгүй байна. Манай улс эмийн тасалдалттай сүрьеэгийн өвчлөлөөр өндөртэй 30 улсын нэг хэвээр байна.
- ➔ Монгол Улс хорт хавдрын шалтгаантай нас баралтаар дэлхийд тэргүүлж, шинээр бүртгэгдсэн хорт хавдрын бараг гуравны хоёр нь хожуу шатанд оношлогдож байна.

Түүнчлэн халдварт бус өвчин, осол, гэмтэл гаралт жилээс жилд нэмэгдэж, хүн амын өвчлөл, нас баралт тэргүүлэх шалтгаан болсоор байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас жил бүр тооцдог Тогтвортой хөгжлийн зорилгын гүйцэтгэлийн индексээр Монгол Улс дахь эрүүл мэндийн зорилтын хэрэгжилтийг дунд зэрэг гэж үнэлсэн ба цаашид бид эмнэлгийн тусламж, үйлчилгээг шүтсэн хандлагаа өөрчилж, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ, бодлогыг... /минут дуусав/

Б.Найдалаа: Ж.Чинбүрэн сайд баярлалаа.

Одоо Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Ж.Чинбүрэн Эрүүл мэндийн сайд, Б.Цэцэгсайхан Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга, Б.Туяа Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн хэлтсийн дарга, Л.Мөнхцэцэг Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газар, Ш.Энхтуяа Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын ахлах шинжээч, Д.Жаргалсайхан Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, М.Нармандах Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Л.Баттөр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал, Г.Ууганцэцэг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал.

Баярлалаа. Асуулт асуух гишүүд нэрсээ өгье. С.Эрдэнэболд гишүүнээр тасаллаа.

Одоо дэгийг би дахиад сануулъя. 3 минутад асуултаа асууна. Хариулт нь бас 3 минут. Тэгээд нэмэлт тодруулга байхгүй шүү. Энэ дээр анхаараад 3 минутдаа багтаагаад асуултаа асуугаарай.

С.Эрдэнэбат гишүүний микрофоныг нээе.

С.Эрдэнэбат: Асуулгатай холбоотойгоор эрүүл мэндийн салбар манай иргэдийн суурь салбар учраас маш чухал асуудал байна.

Ялангуяа энэ цаг мөчид эрүүл мэндийн салбарын асуудал нэлээдгүй хуримтлагдсан байна. Гүйцэтгэлийн санхүүжилт нэлээн сорилтуудтай тулсан байж байна.

- ▷ **Нэгдүгээрт**, гүйцэтгэлийн санхүүжилт манай улсад тохирч байна уу, тохирохгүй байна уу гэдэг тал дээр тодорхой хариулна уу?
- ▷ **Хоёрдугаарт**, эрүүл мэндийн салбараас хэчнээн хүн сүүлийн жилүүдэд төрөөс хувийн салбар руу шилжив? Сувилагчийн хувьд гадагшаа, дотогшоо явав? Хүний нөөцийн хомсдол хэрэг зэрэг байна вэ?
- ▷ **Гуравдугаарт**, эрүүл мэндийн салбарыг төсөвт одоогийн байдлаар 15 орчим хувиар цалин нэмнэ гэж оруулж ирсэн байсан.

Гүйцэтгэлийн санхүүжилт. Түрүүн сайдын ярьж байгаа. Тэр дотор нь байгаа хулгай, сахилга батгүй байдал гэдэг юм уу, ийм зүйлээ цэгцэлснээрээ дахиад цалин хөлс, орлого нэмэх боломж бололцоо гарах уу?

- ▷ **Дөрөвдүгээрт**, хамтын төлбөрийн асуудлыг түрүүн ярих шиг болсон. Хүүхэд, ахмадууд хамгийн их тусламж, үйлчилгээг авч байна. Бараг нийт санхүүжилтийн чинь 70 хувийг аваад байх шиг байна.

Үүнийг төр дааж байгаа гэдэг нэрийдлийн доор хамгийн багаар буюу 2 орчим хувиар өгч байгаа. Тэгэхээр цаашдаа үүнийг нэмэгдүүлэх. Шаардлагатай бол ахмад болон хүүхдүүдийн эрүүл мэндийг төрөөс хариуцна.

Дээрээс нь төрийн хариуцах ёстой хуулиар заасан маш олон тусламж, үйлчилгээнүүд байдаг. Үүнийг манай төр 100 хувь дааж чадаж байна уу, чадахгүй байна уу? Эсвэл даатгалын сандаа даатгаад хаяад байна уу гэдэг ийм асуултыг хэлмээр байна.

Түүний дараа манай эрүүл мэндийн салбарын эмнэлгүүд маань санхүүгийн удирдлуудыг хэр зэрэг хийж байгаа вэ? Би зарим эмнэлгүүд, ажилчид хэлэхээр маш их өртэй байна гээд байна. Энэ жил ерөөсөө өрийг нь барагдуулах санхүүжилт байхгүй. Өрөө өгөхгүйгээр нэг жилдээ явчихъя гэсэн санааг бас сайд хэлэх шиг болсон. Үүнийг ер нь яах вэ? Өртэй байгаа газрууд маань эм тариагаа нийлүүлэхгүй байдал руу тулаад ирвэл ямар гарц гаргалгаа байна.

Тэгээд ойрын гурав, дөрвөн жилдээ эрүүл мэндийн салбарт тусламж, үйлчилгээ, чанар, шаардлагагүй байгаа хэвтэлт гэдэг юм уу, үзлэг гэдэг юм уу бүгдийг үнэгүй байна, бүгдийг шийднэ гэдэг зүйл чинь мухардал руу чирээд байна.

Тийм учраас бидний гүйцэтгэлийн санхүүжилтийг 4 жилийн өмнө 500-аад тэрбум төгрөгийг үлдэгдэлтэй байсан. Бүгдийг нь үрж дуусаж байвал маш сайн ажил хийж байна гэсэн үг гэдэг дүгнэлт доор аваачиж одоо тэр гүйцэлийг.

Одоо нөөц хөрөнгө хэдэн төгрөг байна вэ? Энэ өвлийг яаж давах вэ? Ирэх жил буюу түүний дараа жил магадгүй арифметик прогрессоор наад үзлэгийн тоо, тохиолдлын тоо чинь өсөөд явах, одоогийн гүйцэтгэлээр санхүүжүүлэх боломжгүй гэдэг ийм дүгнэлтийг хэлээд байгаа учраас ямар чиглэлүүдийн гарах гарц юу байна вэ гэдэг тал дээр хариулж өгөхийг хүсэж байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Хариулт Ж. Чинбүрэн сайд. 3 минут.

Ж.Чинбүрэн: С.Эрдэнэбат гишүүн нэлээн олон асуулт асуулаа.

Тийм учраас бүгдийг нь амжиж хариулах эсэхээ мэдэхгүй байна. Ямар ч байсан хичээе.

Ер нь эрүүл мэндийн салбар ковид цар тахлын үеэр асар их ачаалал үүрсэн. Үүнтэй холбоотой эрүүл мэндийн байгууллагуудад ажиллах эмч, сувилагчийн тоо нэлээд өргөн тэлсэн. Төсөв ч сайн нэмэгдсэн. Тэгээд гүйцэтгэлийн санхүүжилттэй. Ер нь салбартаа улс даяараа эрүүл мэндийн салбарын цалин, санхүүжилт маш сайн нэмэгдэж чадсан. Үүнтэй холбоотой тэлэлт ихэссэн.

➔ Төсөвтэй холбоотой удирдах ажилтнууд 9 хувийг л цомхотгосон байгаа. Тэгэхээр 9 хувь гэж ойлгож болно.

➔ Дээрээс нь орон нутагт ажиллах нэмэгдлийг өнгөрсөн хугацаанд аймагт 20, суманд 40 хувь болгосноор ажилчдын ажиллах урам зоригийг бага ч гэсэн нэмэх боломж бүрдсэн сайн зүйл болсон байгаа.

Эрүүл мэндийн даатгалын санг санхүүгийн цэгцлэлт хийх ажлууд нэлээн цаг хугацаа шаардаж байгаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээд дууссан. Тогтоолын төслөө бид боловсруулаад маргааш Засгийн хурлаар оруулах гэж байна.

Энэ дотор ерөөсөө бид хязгааргүй хэрэгцээг хязгаартай мөнгөөр хийх боломжгүй учраас 2026 оноос яг хүний эрүүл мэндэд эрсдэл болж байгаа өвчтөнүүдээ яаж даах вэ гэдэг асуудлаа нэлээн дэлгэрэнгүй ярьж, хийж даатгалын тогтолцоо маань өөрөө биеэ даасан бүтэцтэй. Эрүүл мэндийн яам нэг болохоор худалдан авагч ч юм шиг, нэг болохоор худалдагч ч юм шиг ийм тогтолцооноосоо салж, даатгал нь илүү корпоратив байдал руугаа оръё гэдэг дээр тогтоолын төсөл боловсруулагдаад явж байна.

Санг зузаатгах хэрэгтэй байгаа. Санг зузаатгахгүйгээр бид энэ их олон эрэлт хэрэгцээг нийлүүлж чадна гэдэг худлаа. Тийм ээ.

Тэгэхээр санг зузаатгахын тулд бид л төрөөс шимтгэлийг нь дааж байгаа.

Сая Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл хуралдаад ер нь энэ санхүүгийн нөхцөл байдал, хүнд байдалд оруулж байгаа зүйлийг гарахад ямар ямар зүйлийг анхаарах ёстой вэ гэдгийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргад хүртэл бичиг явуулсан байгаа.

Тэр дотор гол нь шимтгэлийг төрөөс дааж байгаа юугаа ажил эрхэлж байгаа улсуудтайгаа ижил болгоё. Энэ дээр анхаараач ээ. Төрөөс тусламж, үйлчилгээг нь даагаад тэр тусламж, үйлчилгээг 100 хувь даадаг байя. 200 тэрбумаар дутаадаг биш байя. Бодитоор даадаг байя гээд хэд хэдэн шаардлагууд явуулсан байгаа. Та бүхэнд танилцуулагдах байх.

Мөн дараагийн чухал зүйл бол бид ерөөсөө л даатгалын сангийн зузаатгал дотор төрөөс дааж байгаа, иргэдийн шимтгэлийн өмнөөс нь төлж байгаа энэ тогтолцоогоо илүү тогтвортой болгоё.

Харин ажил хийж, хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн даатгалын хураамжийг нэмэгдүүлэхгүйгээр ингэж явах нь зүйтэй гэсэн л зорилготой ажиллаж.

Б.Найдалаа: Баярлалаа. А.Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Ж.Чинбүрэн сайд аа, эмч нар өөрсдөө ярьж байна. Эмч хүн хүн битгий өвдөөсэй гэж уг нь боддог бол харин одоо өвдөөсэй гэж бодох хүртэл төрийн бодлого явжээ гэж.

Яагаад гэхээр хүн өвдөх юм бол эрүүл мэндийн үйлчилгээ авна. Тэр хэрээрээ Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтээ авна. Түүгээрээ цалин, урамшууллаа олгоно. Илүү байвал түүнийгээ хуваарилаад бас урамшуулал авах боломжтой болж байна гэж.

Тэгэхээр энэ бол өөрөө маш буруу тогтолцоо. Үйлчлүүлэгч бага байгаа эрүүл мэндийн байгууллагууд хүмүүсийг жишээлбэл хөдөө сумд манай эмнэлэгт хэвтээч ээ гэж гуйх хүртэл үйл явдал болж байгааг бид нуугаад юу гэх вэ.

Гол зангилаа юу юм бэ гэхээр төр өөрийнхөө төрийн албан хаагчдынхаа цалин хөлс, урамшууллыг төсвөөс хариуцах ёстой гэдэг асуудлыг хэлээд байгаа.

Цалин хөлс, урамшууллыг сангийн санхүүжилтээр явуулахаар нэгдүгээрт сан хоосорлоо шүү дээ. Хэн ч ойлгомжтой цалин хөлсөө авахын тулд хуурамч бичилтүүд хүртэл хийж байгаа гэдгийг яам өөрөө мэдэж байгаа. Тийм ээ. Нийт

нэхэмжлэлийн 5 орчим хувь нь бараг хуурамч бичилт байна гэдгийг хүртэл хэлж байсан.

Хүн л юм чинь цалин хөлсөө авахын тулд ийм асуудлуудыг гаргаад байгаа байхгүй юу. Шимтгэл төлөх ч нөгөө талдаа яаж байна вэ гэхээр яг өнөөдөр эрүүл мэндийн үйлчилгээгээ авч чадахгүй байна. Шимтгэл төлж байгаа мөртөөсөө эрүүл мэндийн үйлчилгээгээ авч чадахгүй байгаа. Яагаад гэхээр сан хоосон байгаа учраас.

Тэгэхээр энэ дээрээ та хэд маань монгол хүний сэтгэхүй, өнөөгийн нөхцөл байдал, яг та хэдийн бусад улс оронд хэрэгжээд байгаа нэг худалдан авалт, үйлчилгээ ч юм уу бүрэн дүүрэн явахад хүндрэлтэй байна. Нэг алхам ухаръя. Төсвөөс төрийн албан хаагчдынхаа цалин хөлс, урамшууллыг хариуцдаг байя гэдэг энэ алхмаа хийхгүй юм уу?

Эмч, эмнэлгийн байгууллагын ажилтны цалин хөлс, урамшууллыг даатгалын санд үүрүүлээд байгаа нь буруу шүү дээ. Үүнийгээ хүлээн зөвшөөрөөч. Яагаад үүнийгээ хүлээн зөвшөөрөхгүй эргүүлээд л ийм нөхцөл байдалд эмч нарыгаа ч тэр, иргэдээ ч тэр түлхээд байгаа юм бэ гэдэг ийм л асуултыг асууя даа. Та тэгээд маш сайн мэдэж байгаа. Танд хүндрэлтэй байгааг чинь би ойлгож байна. Засгийн газрын нэгдмэл бодлого гэж ойлгож байна. Гэхдээ асуудал хаана байгаа вэ гэдгийгээ зоригтой дуугардаг байгаач ээ гэж л хүсээд байна.

Б.Найдалаа: Ж.Чинбүрэн сайд хариулна.

Ж.Чинбүрэн: Би өөрөө эмч хүн. Ямар ч эмч хүн өвдөөд над дээр хүрээд ирээсэй гэж би боддог гэж бодохгүй байгаа.

Бид бас Гипократ¹-ын /Hórkos Hippokratous/ тангараг өргөдөг. Эмч байхдаа яаж энэ өвчнийг нь харин бууруулах вэ, яаж цөөлөх вэ гэж бодож.

Тийм учраас эмч хүн чагнуураа бариад эмч хийдэг, үзэг бариад нийгмийн зүтгэлтэн байдаг.

Тийм учраас манай Монгол Улсад эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа мянга мянган эмч нар тэгж бодож байгаа зүйл байхгүй байх аа.

Зүгээр гүйцэтгэлийн санхүүжилт, гүйцэтгэл их байх тусам санхүүжилт их байна гэж бодож байгаа бол үүнийг хянадаг тогтолцоогоо бид амжилттай хийх ёстой юм. Хяналтын тогтолцоо дутуу байгаа нь Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийг зүгээр сул тавьсан нэг том алдаа гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа.

¹ Эрүүл мэндийн ёс зүйг боловсруулж, өвчтөнд хандах зарчмыг тодорхойлсон.

Тийм учраас чанартай тусламж, үйлчилгээг эмчилснийх нь төлөө санхүүжилт өгөх болохоос гүйцэтгэсэн үйлдэл болгонд санхүүжилт өгнө гэвэл яг таны хэлж байгаа ийм уралдаан болоод байгаа юм. Энэ алдаагаа засах нь зөв. Энэ дээр санал нэг байна.

Даатгалын энэ тогтолцоог бид зохиосон тогтолцоо биш ээ. Энэ бол дэлхий даяараа өндөр хөгжилтэй явж байгаа, амжилттай явж байгаа дэлхийн топ, хүн амынх нь дундаж наслалт 80-аас илүү гарсан улсуудын хэрэгжүүлж байгаа тогтолцоо.

Зүгээр бидэнд харин алдсан алдаа бол бид гүйцэтгэлийн “нэхэмжлэх” болгон, сар бүр 2 саяас их ирж байгаа “нэхэмжлэх” болгоныг хянадаг тогтолцоо нь ердөө 2-оос 3-хан хувийг нь л хянаж байна. Тэр нь өөрөө том алдаа болж байгаа гэдэгт санал нэг байгаа.

Бид чинь эрүүл мэндийн ажилчдын цалинг ТҮ_[Төрийн Үйлчилгээ], ТМ_[Тусгай Мэргэжил] гэдэг ангилалд 9 шатлалтай санхүүжилт өгөөд яваад байгаа. Энэ бол А.Ариунзаяа гишүүний хэлээд байгаа ер нь нэгэнт төрийн албан хаагч гэж үзээд л байгаа юм бол цалинг нь тусад нь төсөвт нь оруулъя гэдэг санаа. Яагаад болохгүй гэж. Би үүнийг буруу ч гэж дотроо боддоггүй.

Тийм учраас Их Хурлын гишүүд, ялангуяа мэргэжлийн Байнгын хороо Та бүхэн энэ асуудлыг хэлэлцээд ярилцаад тэгээд эрүүл мэндийн үйлчилгээний ажилчдын цалинг нь тусдаа гаргах юм бол одоо энэ гүйцэтгэлээр орж ирж байгаа санхүүжилт ёстой под хийгээд л явна. Тийм ээ. Под хийгээд л явна. Ёстой янзын л болно.

Зүгээр тэр боломж нь харин хэр байх юм. Энэ чинь бас хуулийн зохицуулалт орох байх.

Тийм учраас Байнгын хорооны эрхэм гишүүд Та бүхэн хоорондоо хэлэлцэж ярилцаж энэ асуудлыг нэг талд нь гарах талд нь бодолцоорой гэж хүсье. Энэ бол ганцхан Эрүүл мэндийн яам дангаараа шийдэх асуудал биш ээ гэж бодож байна.

Б.Найдалаа: Баярлалаа. А.Ганбаатар гишүүн.

А.Ганбаатар: Ж.Чинбүрэн сайдаас нэг асуулт асууя.

Өмнөх сайд байсан Ардын намын эрх барих Засгийн газарт ажиллаж байсан Т.Мөнхсайхан сайдтай та эрүүл мэндийн бодлого, хэрэгжилт, хөрөнгө оруулалтын асуудал, магадгүй даатгал гээд маш олон асуудал дээр эрс тэс байр суурьтай байсан.

Тухайн үедээ би гайхаж байсан юм. Монгол Улсын эрүүл мэндийн бодлого, эрх баригч Засгийн газрын гишүүд нь, том зүтгэлтнүүд нь ийм хоёр өөр байр

суурьтай байдаг нь ямар сонин юм бэ гээд. Тухайлбал, монгол хүний эрүүл амьдрах хувь заяа салаа замын үзүүрт байгаа юм шиг санагдаж байсан байхгүй юу.

Тэгэхээр өмнө нь шүүмжилж байсан сайдынхаа бодлогыг та -

- ямар ямар зарчмын асуудал дээр яаж өөрчилж байна вэ?
- Ямар хугацаанд өөрчилсөн бэ?
- Өөрчлөлт гарсан салбар чиглэлүүд байна уу?

Магадгүй жилийн дараа ч юм уу, өнөөдөр 11 сарын 04. Дараа жилийн 11 сарын 04-нд магадгүй фэйсбүүк сануулаад би танаас дахиад асууж магадгүй. Засгийн газар хэрвээ насалбал.

Тэгэхээр та нэг ийм хэмжсэн нэгжтэй, яг өмнөх Засгийн газрын эрүүл мэндийн бодлогыг шүүмжилж байсныхаа юу юуг нь яаж өөрчилсөн талаар Та бодитой үр дүн гарсан талаар, эсвэл хугацаа нь арай болоогүй байна гэдэг юм уу. Энэ талаар нэг тодорхой хариулт өгөөч ээ. Баярлалаа.

Б.Найдалаа: Ж.Чинбүрэн сайд хариулна.

Ж.Чинбүрэн: А.Ганбаатар гишүүнд хариултныхаа өмнө нэг зүйл хэлье.

Ер нь аливаа үзэл бодол, зарчмын зөрүүтэй саналууд байна. Энэ бол хэнд ч байдаг зүйл. Ялангуяа ижил мэргэжилтэй улсуудад хөгжлийн бодлогоо, гарцаа, гаргалгаагаа янз янзаар тайлбарладаг байх.

Тийм учраас энэ бол зөвхөн үзэл санааны хэрэгжүүлэх арга замын л зөрчилдөөн болохоос хувь хүнтэй холбоотой ямар нэг асуудал байхгүй гэдгийг хэлье.

▷ **Нэгд.** “Эрт илрүүлэг илүү оновчтой байх ёстой” гэдгийг би байнга ярьдаг.

Өчигдөр би Ардчилсан намын бүлгийн хурал дээр үүнийг олон удаа хэлсэн.

Ер нь “эрт илрүүлэг” гэдэг маань оновчтой, бага зардлаар өвчнийг эрт үед нь оношлох аргаа хэрэглээд, тэгээд илрүүлсэн улсуудаа эмчлээд, тэр нь эдгэрдэг байх ёстой. Энэ тогтолцоог хийх ёстой гэдгээ хэлээд эрт илрүүлгийн тогтолцоог өөрчлөөд, зогсоогоод “эрүүл мэндийн үзлэг” биш, “эрт илрүүлэг” байх ёстой шүү гэдгээр өөрчилж байгаа.

Тэр дотроо “хорт хавдар”, тэгээд “даралт ихсэх өвчин”, “чихрийн шижин” чиглэлд бид эрт илрүүлэг илүү оновчтой хийж, нөгөө амь нас эрсдэх өвчнүүдийг илрүүлэх нь чухал юм гэдэг дээр.

▷ **Хоёрт. “Даатгал”.** Сая яриад байгаа нөгөө хяналтын тогтолцоог илүү оновчтой болгоё. Даатгалыг илүү бие даалгая.

Эрүүл мэндийн яам худалдан авагч гээд л, эсвэл худалдаж аваад байгаа ч юм шиг тогтолцооноосоо бид салаад илүү корпоратив байдалтай, биеэ даасан, жинхэнэ эрсдэлийг даадаг сан байлгах гэдэг асуудал дээр зөрчилтэй байсан. Саналаа хэлж байсан. Одоо үүнийгээ хэрэгжүүлэх гээд сая Засгийн газраас тогтоолын төслүүдээ хүртэл бэлдээд байж байна.

▷ **Гуравт. “Эмийн чанарын асуудал”.** Түр хороог хүртэл ахалж явсан. Үүнтэй холбоотой бид эмийн хяналтаа дээрээс нь жижиглэнгээр эмийн сангуудад зарж байгаа эмийн худалдааг хүртэл оновчтой болгох тухай нэлээдгүй ярьдаг байсан.

Өнөөдөр бид эмийн хяналтыг eBarimt-5.0 систем дээр та гар утсаараа ороод eBarimt руугаа ороод дуртай эмээ хайхад таны эргэн тойрон ойр хавьд ямар аптек ямар үнээр зарж байгаа вэ гэдэг гараад ирнэ. Энэ бол эмийн үнийг өсөлтийг хязгаарлаж байгаа том бодлого шүү. Та үүнийг бүр зориуд орж үзээрэй.

Тэгэхээр ямар ямар эмийн зөрүүтэй эмүүд байдаг юм байна, яаж би авч болох юм байна гэдгээ одоо шууд харах нь байна шүү дээ. Тийм ээ. eBarimt-5.0 шүү.

Дээрээс нь цахим системээр ороод үзэж болж байгаа.

➔ Тэгэхээр бид эмийн чанарын асуудлыг ярьж байсан. Чанарын лавлагаа шатлалын том лаборатори. Үүнийг Т.Мөнхсайхан сайд байхдаа өөрөө эхлүүлсэн ажил байгаа. Үүнийг нь үргэлжлүүлээд явж байна.

Чанарыг шалгадаг лабораторио чадавхжуулах асуудал. Нэлээдгүй ажил явж байгаа. Энэ ажил хийгдээд явж байна.

Мөн дараагийн чухал зүйл бол эмийн үнийг боломжоор нь буулгаж, улам чанарыг нь сайжруулах тогтолцоо. Тэр ч утгаараа хууль батлуулсан. Хуулийн хэрэгжилтийг биелүүлэх ажил явж байна.

Мөн Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хууль батлагдсан. Урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах... /минут дуусав/

Б.Найдалаа: Дараагийн асуух гишүүн Д.Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Баярлалаа.

Тэгэхээр манай С.Эрдэнэболд гишүүн их чухал асуулга тавьсан байна. Ер нь бид бүхний амьдрал, бид бүхний боловсролын эх суурь яах аргагүй эрүүл монгол хүн дээр л цуглаж явдаг.

Тэгээд эрүүл монгол хүний асуудал зөвхөн Эрүүл мэндийн яамны ч асуудал биш шүү дээ. Энэ бол. Ер нь бүх хүний л асуудал.

Ялангуяа хүн бүр өөрийнхөө эрүүл мэндэд анхаарал тавиад явбал эмнэлгийн ачаалал эрс багасахаар барахгүй эрүүл мэндтэй холбоотой олон үзүүлэлт улсын хэмжээнд сайжрах нь маш ойлгомжтой байгаа юм.

Зүгээр яах вэ сүүлийн 10 гаруй жилийн байдлаас харахад манай улсын нийгэм, эдийн засгийн салбарууд дотроос нэлээн гайгүй явж байгаа салбар бол эрүүл мэндийн салбар гэж би харж байгаа. Үзүүлэлтүүдийг нь аваад үзэхэд.

Жишээлбэл,

- Нярайн эндэгдэл ер нь жилээс жилд тогтмол буураад яваад байна.
- Дундаж наслалт үнэхээр сүүлийн 10 гаруй жил нэмэгдэж байгаа. Бүр бодитойгоор нэмэгдээд байдаг.

Гурав дахь гол үзүүлэлт бол шилдэг тэргүүний технологи дамжуулалт эрүүл мэндийн салбарт хамгийн сайн хийгдэж байгаа. Энд эрхтэн шилжүүлэх асуудал байна. Эрүүл мэндийн мэс ажилбарын шинэ технологиуд ер нь нэлээн сайн нэвтрээд яваад байдаг.

Салбар ерөнхийдөө дэмжээд явбал их боломжийн болсон байна гэдгийг бид ковидын он жилүүдэд харсан. Ковидын үеийн 10 мянган өвчтөнд ногдох нас баралтын тоогоороо Монгол Улс дэлхийн дунджаас 3 дахин бага байсан. Хийж чадсан.

Янз бүрийн хэл ам байдаг ч гэсэн үүнийг эрүүл мэндийн салбар хийж чадсан юм.

Тэгээд энэ асуулгатай холбогдуулаад надад хоёр асуулт байгаа юм.

- **Нэгдүгээрт**, Эрүүл мэндийн даатгалын шинэтгэл. Ер нь манай гишүүд хүн болгон бараг энэ асуудлаар төвлөрч байгаа. Ямар шинэтгэл хийх гэж байна вэ?

Энэ чинь хувийн даатгал гээд л дэлхийд бүр хэвшээд тогтсон тогтолцоо байгаад байдаг. Манайд болохоор Эрүүл мэндийн даатгал, эмнэлгүүд хоёр нь Эрүүл мэндийнхээ сайдын баруун зүүн хоёр карманд явдаг. Өөрөөр хэлбэл сайд маань зүүн карманаасаа мөнгөө аваад баруун кармандаа байгаа эмнэлэгтээ өгчхөөд эмнэлэг нь өвчтөнд үйлчилгээгээ үзүүлдэг. Нэг ийм л гаж тогтолцоо

байгаа юм. Үүнийг салгах талаар ямар үзэл бодол, ямар эрх зүйн боломж байдаг юм бэ гэсэн нэг асуулт байна.

- **Хоёрдугаарт**, Эмийн чанарын асуудал. Манайхан чинь боломжтой нэг нь гаднаас эм захиж уугаад байдаг болж байна шүү дээ.

Тийм учраас эмийн чанарыг сайжруулах талаар... /минут дуусав/

Б.Найдалаа: Асуулт ойлгомжтой. Ж.Чинбүрэн сайд хариулна.

Ж.Чинбүрэн: Эрүүл мэндийн даатгалын шимтгэл ерөөсөө л манай эмнэлгийн тусламжийн гол амин сүнс нь.

Эрүүл мэндийн салбар бол -

- ▶ нийгмийн эрүүл мэндийн тусламж,
- ▶ нөгөөх нь эмнэлгийн тусламж.

Түрүүн А.Ариунзаяа гишүүний хэлдгээр нийгмийн эрүүл мэндийн тусламжаа бид сайжруулж байж гөгөө өвдөхгүй байх хүмүүсээ нэмэгдүүлэх, өвчин зовлонгүй зөв амьдрах ухааныг сурах ёстой.

Харин эмнэлгийн тусламж өвдсөн хойно нь бид эмчилгээ, тусламжаа үзүүлнэ.

Үүний амин сүнс нь Эрүүл мэндийн даатгал учраас санхүүгийн сахилга бат асар чухал байна.

Сар бүр 2.1-ээс 2.3 сая нэхэмжлэх ирж байгаа. Үүнийхээ ердөө 2-оос 3 хувийг нь л хянаж байна шүү дээ. Бид ядаж үүнийхээ 30 хувийг хянадаг байя. Үүнийг хянадаг болохын тулд цахимжуулах ёстой. Хиймэл оюун ухаан, шинэ технологиудыг ашиглаж хүний нөөц нь хүрэхгүй юм чинь бодитой цахим системд оруулах нь нэг номерын том шинэчлэл байх ёстой.

Хоёрт. Д.Рэгдэл гуай таны хэлдгээр хоёр кармандаа даатгалын сангаа байлгах нь буруу.

Тийм учраас бие даалгаж, ер нь Эрүүл мэндийн яамны харьяа биш байлгах энэ тогтолцоог хийхээр бид ажиллаж байгаа. Энэ саналуудаа ч гаргаж байгаа.

Хяналтын тогтолцоо. Зарим улсуудад манайх шиг систем явж байгаа хэрнээ хянадаг тогтолцоо нь тусдаа биеэ даасан бүтэц байдаг. Одоо жишээлбэл, Бүгд Найрамдах Солонгос Улсыг аваад үзье. Солонгос Улсын даатгалын байгууллага нь нэхэмжлэлийн дагуу санхүүжилтээ өгөх, түүнийг нь өгөхийн

зөвшөөрөл олгодог хяналтын бүхэл бүтэн биеэ даасан агентлаг байж байх жишээтэй. Энэ агентлаг чанартай тусламж үзүүлсэн үү, үгүй юу гэдгийг нь хянаад олгодог ийм систем ажиллах ёстой юм. Тэгэхээр үүнийгээ бид илүү хийе.

Дээрээс нь актуар² /ACTUARIAL CALCULATION/ тооцооллуудыг бид энэ төлөвлөлтдөө оруулдаг байх ёстой.

Байгаа мөнгө маань хязгаартай. Хязгаартай мөнгөө юунд оновчтой зарцуулах вэ гэдгээ актуар тооцооллоор хийдэг, гаргадаг. Ирэх жилийнхээ тооцооллыг хийгээд тэгээд эмнэлгийн байгууллагууддаа ийм өвчтөнүүдийг эмчилбэл ийм санхүүжилт өгнө гэдгээ илэн далангүй хэлдэг. Тэгээд санхүүгийн сахилга батгүй баахан нэхэмжлэх хийгээд л баахан өрөнд оруулаад, тэгээд сүүлд -

- эм ханган нийлүүлэх байгууллага,
- эмнэлэг,
- даатгал

гэсэн гуравласан сүлжээ үүсгэдэг тогтолцоог байхгүй болгоё. Илүү бодитой болгоё гээд байгаа юм.

Эмийн чанарын хувьд. Тийм ээ. Бид эмийн чанарын асуудлаар өнгөрсөн парламент нэлээдгүй ажилласан. Бүр түр хороо байгуулаад эмийн үнийн өсөлт, чанаргүй эм яагаад үнэтэй байгаа талаар нэлээдгүй олон тайлан мэдээллүүд хийсэн.

Үүнтэй холбоотой бид Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль шинэчлэн найруулаад баталсан.

Одоо энэ хууль хэрэгжээд явж байгаа. Хэрэгжилтдээ бид хийж гүйцээгүй, амжаагүй зүйлүүд байгаа учраас энэ бүгдийг хянадаг тогтолцоонуудаа оруулж өгч байна. Монопол тогтолцооны эсрэг заалтууд орсон. Үүний хэрэгжилтийг бид хэрэгжүүлээд эхлээд явж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа М.Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Маш чухал асуудлыг хөндсөн С.Эрдэнэболд гишүүндээ баярлалаа. Танилцуулга хийсэн Ж.Чинбүрэн сайддаа баярлалаа.

² Ирээдүйн санхүүгийн үүрэг, эрдлийг урьдчилан тооцоолох математик, статистикийн арга. Эрүүл мэндийн даатгал, тэтгэвэр, нийгмийн халамжийн системд хүн амын насжилт, өвчлөл, даатгал төлөлт, үйлчилгээний зардал зэрэг үзүүлэлтүүдийг тооцдог.

Эрт илрүүлэгтэй холбоотой нэлээд хэдэн асуултууд байна л даа. Эрт илрүүлгийг 2025 оны 8 сарын байдлаар 1.7 сая хүн буюу хүн амын 50.9 хувь хамрагдсан гэж байна л даа.

Тэгэхээр энэ хөтөлбөр анх 2022 онд эхэлснээс хойш хамрагдсан хүний тоо юу? Эсвэл зөвхөн 2025 оны тоо юм уу?

- 50.9 хувь хамрагдсан гэхээр үлдсэн 49.1 хувь нь хэзээ хамрагдах вэ?
- Эсвэл төсөв мөнгө хүргэхгүй байна уу?
- Эсвэл ирэх онуудад хамрагдах уу?

Эрт илрүүлэгт 2022 онд 16.3 тэрбум зарцуулж байсан бол 2025 онд 40 тэрбум буюу төсөв нь 2.5 дахин өссөн байна.

- Энэ ямар учиртай өсөлт вэ?
- Эрт илрүүлгийн чанар сайжирсан уу?
- Эсвэл хамрагдсан хүний тоо өссөн юм уу?

Мөн их хэмжээний зардлаар бага тооны өвчнийг илрүүлж байна гэж бичсэн байна л даа.

Тэгэхээр энэ яг ямар учиртай дүгнэлт вэ?

- Эрт илрүүлгийг хувийн эмнэлгүүд хийгээд байна уу?
- Эсвэл зөвхөн улсын эмнэлгүүд эрт илрүүлгийг хийж байна уу?
- Чанар хэр байна вэ?

Эрт илрүүлгийн хөтөлбөр ер нь хэрэгжээд 4 жил болсон юм байна л даа. 2022 оноос авхуулаад.

Тэгэхээр энэ хөтөлбөр ер нь хэр үр дүнтэй болж байна гэж Та бүхэн үзэж байгаа юм бэ? Тэгээд энэ хөтөлбөрөө эцсийн зорилго нь юу юм бэ? Энэ хөтөлбөр үр дүнтэй болж байгаа эсэхийг Та бүхэн ямар хэмжүүрээр хэмжиж байгаа юм бэ?

2026 оны төсөв дээр эрт илрүүлэг дээр ямар хэмжээний төсөв мөнгө тусгагдсан байгаа вэ гэсэн асуултуудыг асууя даа.

Б.Найдалаа: Асуултад Ж.Чинбүрэн сайд хариулна.

Ж.Чинбүрэн: М.Энхцэцэг гишүүн ээ, их чухал асуулт асуулаа. Та.

Эрт илрүүлэг өдийг хүртэл 1.7 сая хүн үзлэгт оруулсан гэсэн үг. Үүнийг би өөрөө Их Хурлын гишүүн байхдаа санаачилж анх 60.0 тэрбум төгрөг тавиад тэгээд зарцуулалт нь таны саяын хэлдгээр 19.3 тэрбум төгрөг зарцуулсан байсан.

Өнгөрсөн буюу энэ жил бид 40.0 тэрбум төгрөг зарцуулахаар тавиад сая энэ эрт илрүүлэг, үзлэг үргэлжлээд явж байгаа.

Би түрүүн хэлсэн. Энэ оновчгүй. Эрт илрүүлэг өөрөө оновчтой байх ёстой. Би зүгээр ганцхан жишээ танд хэлье. Жишээлбэл, ходоодны хорт хавдрыг эрт илрүүлэх гэж шээс, цусны шинжилгээ, баасны шинжилгээ үзэх ямар ч шаардлага байхгүй байхгүй юу.

Тэгэхээр нөгөө “гуя дагаж хүзүү” гэгчээр ийм дэмий үрэлгэн тогтолцоог буруу гэдгийг би шүүмжлээд байгаа.

Харин ганцхан дуран хийх ёстой. Дурангаар ганцхан ходоодоо ч оношлохгүй. Нөгөөдөх нь улаан хоолойгоор дамжиж явах учраас 2 ч өвчнийг эрт илрүүлчхэж байгаа байхгүй юу.

Тэгээд эрт илрүүлэх юм бол харин хагалгаа хийхгүйгээр дурангийнх нь аргаар нь салстыг нь хуулж аваад эрт үедээ оношлогдсон хүн маргааш нь гэртээ, зарим эмнэлгүүд нь тэр өдөрт нь гэрт нь гаргаад тэгээд 7 хоногийн дараа гэхэд ажлаа хийгээд л явж байгаа.

Эрт үедээ оношлогдсон бол хорт хавдар нь эдгэрэх магадлал нь 98 хувьтай. Энэ л үр дүн байхгүй юу.

Бид өнөөдөр хорт хавдрын эрт илрүүлгийг нэмэгдүүлэх хөтөлбөр хийе ээ гэхээр “эрүүл мэндийн үзлэг” хийгээд байгаа нь аягүй буруу байгаа байхгүй юу. Баахан насны ангиллаар.

Тэгээд би гишүүн байхдаа ч хэлдэг байсан. Энэ буруу.

- Баахан шинжилгээ хийдэг.
- Баахан эрүүл мэндийн үзлэг хийдэг.

Биш ээ. Бид хүний амь нас авах гэж байгаа, хүний үхлээс сэргийлж болох зүйлдээ зарцуулсан төгрөг болгон нь өөрөө өгөөжтэй бай.

Та зөв зүйл асууж байна. Үгүй ээ, ямар үр дүнд хүрэх юм. Хорт хавдрын өвчний эрт илрүүлэг дотор хамгийн сайн явж байгаа хөтөлбөр нь “**умайн хүзүүний хорт хавдар**”.

Өнөөдөр манай эмэгтэйчүүд илүү их тийм хариуцлагатай, эрт илрүүлэгтээ хамрагддаг. Тэгсэн хэрнээ энэ ердөө 50 хувьд арай чүү гэж хүрч байгаа. Хамрагдаж байгаа хувь нь. Тэгээд эрт оношлогдсон улсуудын хувь нь хамгийн их байдаг. 40 хэдэн хувьтай.

Нийт хорт хавдрын бид ядаж 40 хувиас багыг нь хожуу оношлох юмсан, 60-ыг нь эрт оношлох юмсан. Бэлэн бидэнд сайн туршлагууд байж байна. Жишээлбэл, Бүгд Найрамдах Солонгос Улс ходоодны хорт хавдрын өвчлөлөөр хамгийн их шүү дээ. Тэгсэн хэрнээ нас баралт нь хамгийн бага байгаа байхгүй юу.

Нөгөө Монгол Улс чинь өвчлөлөөрөө дараа нь ордог. Нас баралтаараа түрүүлээд явдаг.

Аль болохоор төр болон хувийн хэвшлээр хийлгэх ёстой юм. Би нэг ярьсан зүйл дээрээ л жишээ болгоод ярья. Жишээлбэл, ходоодны эрт илрүүлгийн оношилгоо 60 мянган төгрөг байхад ариутгалын бодис нь 40 мянган төгрөг. Тэгээд эмч, сувилагч, техникч гээд элэгдэл хорогдлоо тооцохоор энэ бол хаана нь ч хүрэхгүй.

Тэгээд битгий хийгээсэй гэсэн хүн тавьчихаж байгаа байхгүй юу.

Үгүй ээ. Зоригтойгоор 160 мянга болгоё л доо. Хувийн хэвшлийнхэн нь хий л дээ. Гэр орноос нь дуудаад та 40 нас хүрсэн байна. Хийлгэх цаг чинь болсон байна гээд хийе л дээ.

Б.Найдалаа: Баярлалаа. Б.Хэрлэн гишүүнийг асуулт асуух гишүүнд нэмээрэй.

Дараагийн гишүүн Д.Бум-Очир.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлсэн нэгэн шалтгаан юу вэ гэхээр нийтэд нь эрүүл мэндийн зардалд хувь хүний төлөх төлбөрийн эзлэх хувь өндөр болоод байсан.

Ингээд 2021 оноос “гүйцэтгэлийн санхүүжилт” нэвтрүүлснээр ямар зорилго тавьсан бэ гэхээр “хувь хүний төлөх төлбөрийн эзлэх хувь хэмжээг бууруулъя” гэсэн зорилго тавьсан юм байна гэж ойлгоод байгаа юм.

- ▶ 2020 онд 43.7 хувь байж. Хувь хүмүүсээс гарч байгаа нь.
- ▶ 2022 онд 38.9 байж. Буурсан гэж үзэж байгаа юм байна. 4.8-аар.

2023, 2024 оны тоо нь байхгүй байна. Энэ үргэлжлүүлээд буурч байгаа юу?

2020 онтой харьцуулахад 2022 онд гүйцэтгэлийн санхүүжилт нэвтрүүлснээр 4.8 хувиар л буурсан байгаа юм.

Энэ яг хангалттай бууралт уу гэж асуумаар байгаа юм.

Яагаад вэ гэхээр Эрүүл мэндийн даатгалын сангаас –

- 2020 онд 426 тэрбумыг зарцуулж байсан байна.
- 2022 онд 1 их наяд 480 сая.
- 2025 онд 2 их наяд 242 сая гээд 3.5 дахин нэмэгдсэн байгаа.

Энэ нэмэгдсэнтэй харьцуулахад иргэдээс гарч байгаа зардал бууралт нь тийм хангалттай олон хувьтай биш байгаа юм шиг л харагдаад байна л даа. Энэ тоон дээр нэг тайлбар өгөөч ээ гэж хүсэх гэсэн юм.

Бас нэг зүйл юу вэ гэхээр “эмнэлэгт хэвтэлтийн түвшин” дэлхийн дунджаас 4 дахин өндөр байна гэж байгаа.

Манайхны “эрүүл мэндийн соёл” гээд хэлэхэд буруудахгүй байх. Энэ нь олон улсын жишгээс их өөр байгаад байх шиг байгаа юм. Жишээ нь, бид бүгдээрээ мэдэж байгаа. Жилдээ жаахан нас ахиад ирвэл. Нас ахиад гэдгийг одоо яаж тодорхойлох юм. Мэдэхгүй байна. Миний үеийнхэн ч байх юм уу. Нэг эмнэлэгт хэвтэе гээд. Тэгээд очихоор Эрүүл мэндийн даатгалын сангаас гаргах заалттай өвчлөлт нь байхгүй бол эмчтэйгээ ч юм уу яриад өөр нэг. За энэ өвчин гээд бичүүлээд. Өөрөөр хэлбэл тухайн хүний өвчлөлийн түүх чинь тэс өөр юм ороод явна гэсэн үг шүү дээ. Тэгсэн мөртөө хэвтээд өөр юм эмчлүүлээд.

Тэгээд санаа нь бол хавар болж байна, намар болж байна, нэг ядарч байна. Нэг хэвтээд эмчлүүлэх нь зүйтэй юм уу гээд. Ийм байдлаар асуудалд хандаад байгаа нь эмнэлэгт хэвтэлтийн түвшин өндөр байгаатай хамаатай юу? Нэгдүгээрт.

Ер нь бид эрүүл мэндийн талаарх сэтгэлгээ, соёл юмаа нэлээд өөрчилмөөр юм шиг. Шууд антибиотик аваад л уудаг гэх мэтчилэн. Манайд жоохон буруу тогтсон хэвшсэн зүйлс нэлээд өндөр байгаа. Эд нартай яаж бид тэмцэх ёстой юм бэ гэдгийг асуумаар байна.

Б.Найдалаа: Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Д.Бум-Очир гишүүн та яг л одоо нөгөө гүйцэтгэлийн санхүүжилтийн гол зорилго биелсэн үү гээд гол тоог л асуулаа.

Ерөөсөө л бид нарын гол зорьж байгаа зүйл иргэнээс карманаас нь гарч байгаа эрүүл мэндийн тусламжийн төлөө гаргаж байгаа мөнгө, санхүүжилтийг бага л байлгахыг зорьж байгаа.

Энэ хэмжээнд хүрэхийн тулд ер нь 25 хувьд хүрэх том зорилго тавиад байгаа юм. Урт хугацаандаа бол. Яг санхүүжилтийн тогтолцоог шинээр хийх үед 45-аас 46 хувь нь карманаасаа гарч байсан.

Та бүхэн санаж байгаа бол ердөө жилдээ 2 сая төгрөгөөс илүү санхүүжилт өгдөггүй. Дээрээс нь улиралд 140-өөд мянган төгрөгөөр шинжилгээ хийлгэдэг. Бусад бүх зардал нь нэг бол өөрөө.

Би ч гэсэн өөрөө эмнэлэгт ажиллаж байсан. Сарын эцэст төсөв нь хүрэхгүй. Одоо ар гэрт нь захиарай гээд.

Энэ санхүүжилтийн өөрчлөлт хийгээд нэлээн урамтай сайн явсан. Ялангуяа ковид цар тахлын үед нэлээн ач тусаа өгсөн. Эмнэлгийн салбарт ажилласан тэр олон, 14 хоногоор өвчтөнүүдтэйгээ цуг хоригдох. Эмчилж байсан. Бараг хоригдохтой адилхан эмчилж байсан эмч, сувилагч, эмнэлгийн ажилчид гээд л 14 хоног цуг ажиллаад л. Тэгээд өөрснөө халдвар авсан, үгүй. Гэр орондоо очиж чадахгүй байхад энэ нь өгөөжөө өгч байсан.

Харамсалтай нь үргэлжлээд явахдаа хяналтын тогтолцоогоо алдаад гүйцэтгээд бай, гүйцэтгээд бай, уралдаад байгаарай гэдэг. Түрүүн гишүүний хэлсэнчлэн энэ нөхцөл байдлаа хянаж чадахгүй болоод энэ нь өөрөө тогтолцоог буцаагаад алдаатай болгосон.

Та бүхэн хараарай. Эрүүл мэндийн даатгалын сангийн тэлэлтийг ямар их тэлсэн байгаа билээ. Тийм ээ. Өнөөдөр бараг нэг иргэн жилдээ 220 гаруй сая төгрөгийн тусламжийг авч чадаж байна шүү дээ. 100 саяас дээш тусламж авч чадсан иргэдийн тоо гэхэд чинь бараг 100 гаруй л хүмүүс байж л байна. Тийм ээ. Эрхтэн шилжүүлэн суулгахаас авхуулаад л.

Тэгэхээр бид засахгүй болохоо больсон. Тэгэхдээ буруу биш. Буцаад үүнийгээ засна.

Мөн карманаас гарч байгаа санхүүжилтийг буулгадаг нэг том тогтолцоо нэвтрүүлсэн нь бид хөнгөлөлттэй эмийн эмийн тогтолцоог бий болгосон.

Ердөө 38.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй эмтэй байсан 2021 оныг бодвол өнөөдөр бид 130, 140 гарсан яваа байхгүй юу. Энэ нь өөрөө эмнэлэгт хэвтэх гэж, зөвхөн даралтын эмээ авах гээд эмнэлэгт хэвтдэг биш. Харин архаг өвчтэй улсууд өрхийн эмчдээ, сумын эмчдээ хянуулаад, эмээ тогтмол аваад, эм авсныхаа төлөө санхүүгийн хямралд орохгүй байх тогтолцоог хийж өгсөн том тогтолцоо.

Үүнийгээ бид улам сайжруулах хэрэгтэй байгаа. Энэ зөв.

Орны хувьд үнэхээр бид. Хуучин тогтолцоо маань ор түшиглэсэн ор санхүүжүүлдэг байсан. Үүнээсээ салсан юм шүү дээ уг нь. Тэгтэл буцаад энэ орыг сайжруулж чадахгүй байна.

Тэгэхдээ өнөөдөр бид нэг сайхан мэдээ. Их Хурлын гишүүд та бүгдийн дэмжиж өгснөөр бид орны чанарыг сайжруулах төсөл нийтдээ 220.0 сая доллароор Азийн хөгжлийн банктai өнөөдөр Сангийн яам гэрээ хийлээ.

Үүгээр дамжуулж эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн жинхэнэ хүний амь нас авардаг эмнэлгийн оруудыг сайжруулах, аймаг бүрт хөрөнгө оруулалт хийх энэ төсөл маань батлагдлаа. 225 сая доллароор аймаг бүрт бид эрчимт эмчилгээг сайжруулах төсөл маань явж байгаа юм.

Б.Найдалаа: Баярлалаа. О.Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу?

Иргэдийн эрүүл мэндтэй холбоотой санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилт гэдэг дээр 2023 онд өөрчлөлт оруулж, зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчний эмчилгээний зардлын дэмжлэг оруулсан байна. 5 хувь байсныг нэмсэн юм байна.

Энэ дээр би арай жоохон тодруулъя. “Эрх зүйн орчныг бүрдүүлсэн” гэж байгаа.

Тэгэхээр “эрх зүйн орчныг бүрдүүлсэн” гэдэг дотор үнийн дүн нэмэгдсэн байна. Гэхдээ төрөл нэмэгдсэн үү? Яагаад гэхээр сайдын Эрүүл мэндийн яамны

▷ **Нэгд,** гадаадад зайлшгүй эмчлэх өвчний жагсаалтын төрөл, онош нэмэгдсэн үү?

▷ **Хоёрт нь,** эмчилгээний жагсаалт нэмэгдсэн үү?

Яагаад гэхээр сүүлийн үед тархины хавдар ч юм уу, Монголд эмчлэгдэхэд хэцүү байгаа өвчтөнүүд дээр олон улсад жишээлбэл Протон эмчилгээ³ /Proton Therapy/ гээд шинэ юм гараад ирлээ. Дэлхий дээр шинэ технологи. Хүүхдүүдэд эрсдэл багатай гээд.

Тэгэхээр манай буцаан олгох жагсаалтад байдаггүй. Гэхдээ тэр бол аягүй эдийн засгийн үр ашигтай юм байна л даа.

Тэгэхээр энэ шинэ зүйл дээр чинь өвчний төрөл нэмэгдсэн үү? Тэгээд эмчилгээний төрөл хоёр нэмэгдсэн үү? Ер нь нэмэгдэх үү гэдгийг би тодруулж асуумаар байгаа.

³ Протон эмчилгээ нь протон (эерэг цэнэгтэй цөмийн бөөм) ашиглан хавдрын эсийг устгадаг өндөр нарийвчлалтай туяа эмчилгээний арга.

▷ **Гуравт нь**, үүнтэй холбоотойгоор гадаад руу яг энэ чиглэлээр эмчилгээ хөөцөлдөөд, хандив босгоод явж байгаа монгол иргэдэд Гадаад хэргийн яамнаас, Монголын төлөөлөгч, консулын газруудаас ядаж тэр зөв эмнэлгийг нь олоод өгдөг, холбодог үйлчилгээ ер нь байна уу? Энэ дээр та нар ямар арга хэмжээ төлөвлөж байгаа юм бэ гэдгийг асуумаар байгаа юм.

Яагаад гэвэл зарим хүмүүс луйвардуулж байгаа байхгүй юу. Луйвардуулж байна шүү дээ. Тийм ээ. Зөв эмнэлгээ олж чадахгүй, онош нь буруу, эмч нь буруугаас болоод ийм асуудал гараад байгааг нэлээн тодорхой ярихгүй бол энэ нь асуултын маань Үндсэн хуулийн 1, 2, 6 дээр энэ хүмүүсийн хувьд асуудалтай байгаа.

Нөгөө талд даатгалын асуудал дээр өөрийнхөө архи, тамхины буруу хэрэглээнээсээ болоод эрүүлжүүлэхийн үйлчилгээ авч байгаа, эмнэлгийн үйлчилгээ авч байгаа хүмүүсийн төлбөр Эрүүл мэндийн даатгалын сангаас гардаг уу? Эсвэл өөрийнхөө гэм буруугүйгээс болоод агаарын бохирдлоос болоод амьсгалын замын цочмог өвчнөөр хүндэрч байгаа хүүхдүүдийн эрүүл мэндийн асуудал байгаа.

Хүн амын нэг нь нас, нэг нь амьдралын дадалтай холбоотой өвдсөн. Нөгөөд нь өөрийн буруугаас бишээр өвдсөн ийм хоёр хүн ам байгаа.

Тэгэхээр бид Эрүүл мэндийн даатгалын хамтын төлбөрийн асуудлыг ер нь ярих уу? Цаашдаа. Энэ дээр энэ дарааллыг ер нь хэзээ хэлэлцэх вэ гэдэг дээр сайдын бодол болон яамны зүгээс төлөвлөж байгаа ажил байвал сонсох хүсэлтэй байна.

Б.Найдалаа: Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Тусгай сантай холбоотой хууль эрх зүйн өөрчлөлтийг хийж амжсан.

8 дахь удаагийн парламентын сонгуулиар бүрдсэн парламент 2024 онд “тусгай сан”, дээр нь “гадаадад эмчлүүлэх”.

- Монголд эмчилж чадахгүй гээд нэгэнт зарласан хүмүүсийн эмчилгээний зардлыг
 - насанд хүрэгчдийг 5-аас 20 хувь болгосон.
 - хүүхдүүдийг 5-аас 50 хувь болгосон.

Энэ дээр харин төрөл, эмчилгээний аргуудтай уялдсан тоо, бүрэлдэхүүнийг нэмсэн үү гэвэл яг одоогоор нэмсэн зүйл байхгүй.

Гэхдээ Эрүүл мэндийн яамнаас барьж байгаа бодлого бол бид Үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн ажилтны зөвлөл байгаад тэгээд түүгээрээ дамжуулаад нэгэнт Монголд эмчилж чадахгүй тохиолдлуудаа санхүүжилтийг нь зөвшөөрдөг, олгодог болгоё гэдэг ажил хийгдэж байгаа.

Жишээлэх юм бол бид өнөөдөр элэг сольж чаддаг болсон гээд л яриад байгаа. Тэгтэл маш төвөгтэй байрлалтай, цусны бүлэг тохироогүй хүмүүсийг сольж чадахгүй л байгаа шүү дээ. Тэгээд л гадаад явж байгаа.

Тийм учраас эмчилгээний арга болгон өөр. Хүрц болгон, эмчилгээний тактик болгон өөр байдаг учраас нэгэнт чадахгүй гэж байгаа бол. Тухайлах юм бол “протон эмчилгээ”. Протон эмчилгээ бол туяа эмчилгээний сүүлийн том эмчилгээний арга. Ялангуяа залгиур хоолойны хэсгийн байрлалын хавдар, гүнд байрлаж байгаа тархины хавдар зэрэгт илүү нөлөө сайтай байдаг.

Үүнээс өөрөөр эмчилж болохгүй гэсэн байх юм бол явуулдаг байх тогтолцоог тэр зөвлөлийн шийдвэрийг гаргадаг байхаар хийж байгаа шүү.

Тэгэхээр бид тэр өвчинг ингэхээр энэ нь өөрөө хэтэрхий боймлосон, тэлж болдоггүй ийм зүйл болдог.

Эрүүл мэндийн яамнаас сүүлийн үед баримталж байгаа бас нэг бодлого бол гадаадад эмчлэх асуудал дээр дилерүүд, зуучилдаг байгууллагуудын үнэ тарифтай холбоотой. Тэгээд л явдаг байдлыг зогсоохоор хөгжлийн төв дээр тусгайлан гадаад эмчлүүлэх өвчтөнүүдийн асуудлыг хариуцсан департамент байгуулсан нь.

Одоо үүнийг бууруулах зорилготой хийж байгаа. 2026 онд бид Бүгд Найрамдах Солонгос Улсад бүр төлөөлөгчийн газраа ажиллуулж, тэр зуучлагч байхгүйгээр урьдчилаад заавал мөнгө хийхгүйгээр эмчилдэг байх боломжийг олгох ажлууд хийгдээд нэлээн үр дүнтэй явсан. Одоо тэнд ажиллуулах боломж бүрдэж байгаа.

Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой архи. Хордлого гүнзгийрсэн үед бид эмчилнэ шүү дээ. Жишээлбэл, бөөрний дутагдал болсон, элэгний дутагдал болсон, олон хоногийн архидалтаасаа болоод шарлалт үүссэн, олон эрхтний дутагдалд орсон байгаа бол бид эмчлэхээс өөр яах вэ.

Харин зүгээр эрүүлжүүлэх үйл ажиллагаанд даатгалаас санхүүжүүлэх нь буруу.

Мэдээж хордсон байдалд бүрэн даах ёстой шүү дээ. Тийм ээ. Агаарын бохирдолтой, утаатай холбоотой. Мэдээж зарим тохиолдолд иргэд гэрийнхээ утаа мэдрэгчийг унтраасан харамсалтай тохиодолууд байна. Гэлээ гэсэн ч бид үүнийг заавал даатгалаас санхүүжүүлж эмчилж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Д.Ганмаа гишүүн асуулт асууна.

Д.Ганмаа: Асуулт асуухаас өмнө нэг зүйлийг хэлье.

Эрүүл мэндийн салбарт 2021 оноос хойш хэрэгжүүлсэн санхүүжилтийн реформ бол эрүүл мэндийн салбарт 1994 онд даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн реформоос хойш хийгдсэн маш том шинэчлэлүүдийн нэг байсан.

Тэгэхдээ энэ нь хэрэгжүүлсэн санхүүжилтийн шинэчлэл нь үнэндээ гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн реформ биш юм. Энэ бол улс төрчдийн өгсөн нэр юм шиг байгаа юм.

Харин энэ бол эрүүл мэндийн бүх нийтийн хамралтад хүрэх зорилгоор нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж, стратегийн худалдан авалтыг хэрэгжүүлэх реформ байсан.

Яг үнэндээ хэрэгжүүлээд энэ 4 жил болж байгаа. Эцсийн бүлэгтээ энэ шинэчлэлийн ололт амжилт гэхээсээ –

- сан дампуурсан,
- өвчтөнүүд нь эмнэлгээ авахаа байсан,
- төрийн эмнэлгүүд нь өрийн сүлжээнд орсон,
- хувийн эмнэлгүүдийг нь ялгаварлаж байна,
- эмч, эмнэлгийн ажилчид цалингаа нэмэгдэхгүй байна.

Ингэснээрээ иргэдэд квот тогтоогоод эрсдэл тогтоож байна гэсэн эдгээр асуудлууд ар араасаа дагалдаад гарч ирж байгаа. Бид бэлээхэн гарч ирээд яриад байгаа, хүмүүсээс мэдэж байгаа. Тийм үү.

Тэгвэл стратегийн худалдан авалтыг хэрэгжүүлэхийг яг юун дээр нь оносон, юун дээр нь алдсан юм? Ямар зүйлийг дутуу хийсэн юм гэх мэт асуудлыг судалж үзсэн стратегийн худалдан авалтыг хэрэгжүүлсэн байдалд дүн шинжилгээ хийдэг шинжлэх ухааны хэд хэдэн аргууд байгаа. Үнэлгээний хүрээнүүд байдаг.

Эдгээр хүрээнүүдээс яг альныг нь дүгнэлтийг нь гаргаж үзсэн бэ? Та нар. Үзсэн бол.

Бас С.Эрдэнэболд гишүүний асуулгад “эмнэлгийн тусламж, үйлчилгээг авах эрхтэй” гэсэн, “эрхийн хэрэгжилт хангалттай бус байна” гэсэн тийм асуудал тавьсан байна. Та нэгдэж байна уу? Нэгдэж байгаа ямартаа нэгдээд, ямартаа нэгдэхгүй байна.

- Ер нь эрүүл мэндийн эцсийн тогтолцооны чинь зорилго нь яг юу юм?
- Одоо бид нарын хэрэгжүүлж байгаа санхүүгийн модель нь юу юм?

Манай дээр ажиллаж байгаа модель юм уу, ажиллахгүй модель юм уу?

Энэ дээр таны шинэчлэл, өөрчлөлт, янзалъя гээд байгаа чинь яг юуг нь хэлээд байгаа вэ?

Би тэгээд танаас гурав дахь удаагаа асууж байна.

- Цалингийнхаа голчийг тооцоолж гаргасан уу? Эмч, эмнэлгийн ажилчдын.
- Эцсийн тоонуудаа гаргаж чадсан уу?
- 25 дахь 75 дахь презентайл нь хэд вэ?
- Үйлдвэрчний эвлэлтэй цалингийн талаар хэлэлцэхдээ та ямар ямар version-тэй орсон бэ?

Тийм тооцоолол, харуулах excel sheet гэж юм байна уу?

Ер нь та энэ салбарт хоёр дахь удаагаа хийж байна. Одоо сайд дээрээ байна. Ямар ямар зарчмын зөрүүтэй санал энэ төсөв дээр оруулж ирж байсан бэ? Тэрийгээ яаж шийдүүлсэн юм? Гүйцэтгэлийн санхүүжилт гэж нэрлээд байгаа дээрээ та ямар өөрчлөлтүүдийг хийсэн. Тэгээд яаж явж байсан юм? Хэрэгжүүлэлт дээр нь.

Эдгээр асуулт дээр хариулт авъя. Яагаад гэхээр сүүлд яаман дээрээс ч гэсэн орж ирсэн дээр өөрчлөлт буюу ерөөсөө цалин нэмэгдэх дээр эхлээд огт орж ирэхгүй байж байгаад дараа нь хэд хэдэн тоог... /минут дуусав/

Б.Найдалаа: Хариултыг Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Таны дүгнэлт зөв шүү.

Ер нь бид энэ шинэчлэл хийсэн. Энэ бол ерөөсөө л бид үр дүнд тулгуурласан санхүүжилтийн тогтолцоо, дээрээс нь эмнэлгийн тусламж, үйлчилгээг нэг ч хүнийг орхигдуулахгүй байх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн л санхүүжилтийн тогтолцоог бид хийгээд байгаа шүү дээ.

Сая ярьсан тэр ор санхүүжүүлдэг байдал тогтолцооноосоо салж байгаагийн л гол зорилго энэ байсан.

Би ч бас энэ хуульд “стратегийн худалдан авалт” гэж үг оруулж зарчмын зөрүүтэй санал гаргаж оруулж байсан юм.

Стратегийн худалдан авалтын гол зорилго бол бид хаана илүү санхүүжилтээ тогтвортой өгөх юм, аль эмнэлгийн тусламж дутагдаж байгаа газар нь санхүүжилтийг нэмэгдүүлэх юм бэ, ямар технологиудыг бид дэвшүүлэх юм, яаж

үр дүнтэй, өгөөжтэй байлгах юм, яаж ил тод байлгах юм, цахимжуулах юм гэдэг олон зүйлүүдийг хийхийг зорьсон.

Яах вэ, одоо тэгээд алдаж онож байж л амжилтад хүрнэ л дээ.

Тийм учраас Та ч гэсэн ажлын хэсэг ахалж байгаагийн хувьд сайн энэ дээр дэмжиж туслаарай.

Бид энэ стратегийн худалдан авалтаа улам сайжруулах, тэр дотроо аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тогтолцоог илүү сайжруулах энэ чиглэлд бид бодлого явуулахгүй бол болохгүй болчихоод байна.

Лавлагаа шатлалын том эмнэлгүүд санхүүжилт хангалттай болчихож. Анхан шатын тусламж, үйлчилгээгээ бид 2022 онд хоёр дахин нэмсэн нь арай гэж нэг амь аврах төдийтэй байна. Дахиад нэмэх хэрэгтэй байна.

Дээрээс нь өвчтөн илгээдэг тогтолцоогоо бид байхгүй болгоод заавал шууд лавлагаа шатлал дээр хаана ч хамаагүй очихоор тэгээд л очер дараалал, үйлчлүүлэгчийн ачааллыг нэмэгдүүлээд байгаа явдлууд байгаад байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг жигд хуваарилах. Тэр дотроо бид хамгийн чухал зүйл бол ерөөсөө 2026 онд бид стратегийн худалдан авалтынхаа гол цөмийг анхан шатны тусламж, үйлчилгээгээ л дахиад дэмжинэ. Анхан шатны тусламж, үйлчилгээн дээр жинхэнэ ёстой хаалга баригчийн үүргийг нь биелүүлж нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламжийг гүйцэд хангалттай байлгахын төлөө ажиллана.

Эрүүл мэндийн салбарын үйлдвэрчний эвлэлийнхэнтэйгээ уулзаж ярьж байгаа. Тийм. Цалингаа бид ямар ч байсан төсвийн тандалтаа төсвийн урсгал зардлаас 10 хувийг хасаад 181 байснаа одоо 201 тэрбум болгоод, үндсэн цалинг 15 хувиар нэмэх гаргалгаа гаргаж танилцуулж ярьж байгаа.

Нөгөө талаасаа Эрүүл мэндийн даатгалын тогтолцоон дээрээ илүү сахилга баттай байх юм бол бид дахиад ч 10-аас 15 хувийг шагнал урамшуулал байдлаар нэмэх боломжууд харагдаж байгаа.

Тэгээд Их Хурлын гишүүд Та бүхэнд төсөв очсон байгаа. Та бүгдийн гар дээр төсөв байгаа. Эрүүл мэндийн салбарын ажилчдын цалинг нэмэх асуудал Та бүгдийн мэдэлд очсон. Ялангуяа мэргэжлийн Байнгын хорооны хувьд энэ дээр оновчтой саналууд гаргаж, үүнээс илүү нэмэгдүүлэх байх гэж итгэж найдаж харж сууж байна.

Б.Найдалаа: Баярлалаа. С.Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Түрүүн академич Д.Рэгдэл гуайн хэлсэн эрүүл мэндийн асуудал бол салбарын асуудал. Нэг яам дангаараа бодлогыг нь бүтэн

тодорхойлоод үр дүнд хүргэх ажил биш гэж хэлж байгаа. Үүнтэй санал нэгдэж байгаа.

Яагаад энэ асуулгыг явуулсан бэ гэхээр бид хүний эрхийн асуудал гэхээр зөвхөн хууль шүүхийн байгууллагын асуудал гэдэг хүрээнд л бодоод байдаг. Нэг эрүүдэн шүүхийн ч гэдэг юм уу, тэр хүрээнд л бодоод байдаг. Гэтэл энэ хүний эрхийн асуудал гэдэг чинь хүний хөгжлийн суурь асуудал. Тэр хүний эрхийн талаасаа авч үзэх юм бол Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо гэдэг чинь Монгол Улсын аюулгүй байдлын суурь асуудалтай бид нүүр тулж байгаа гэсэн үг.

Зөвхөн бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, Монгол Улсын халдашгүй дархан байдал гэдгийг бид ойлгохдоо хүнээсээ эхлэх ёстой. Тэр ч утгаараа ноднин 11 сарын 28-нд Улсын Их Хурал хүн төвтэй бодлогын шалгуур үзүүлэлтүүдийг гаргасан.

Тэгэхээр хүний заяамал эрхийн асуудал гэдэг маань Үндсэн хуулийн бичиглэлээс харахад Монгол Улсын иргэний амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал болж байгаа юм.

Тэгэхээр яг энэ асуудлын –

- хөрөнгө оруулалтын асуудал,
- төсвийн асуудал,
- төсвийн хүрээний асуудал,
- төсвийн төсөөллийн асуудал

гээд энэ бүх зүйлүүд хэмжигдэх нэгжтэй, хүрэх үр дүнтэй, хугацаатай зүйлс байх ёстой.

Энэ жил хэрэгжиж байгаа төсөв 2.7 хувь байсан. Эрүүл мэндийн төсөв улсын төсөвтэй харьцах нь. Олон улсын дундаж жишгээр энэ бол 7 хувьтай байгаа. Тэгж байж эрүүл мэндийн хатуу дэд бүтэц, зөөлөн дэд бүтцийн асуудал шийдэгдэж байж дараагийн асуудлыг бид ярих ёстой. Тэгэхгүй бол хэдэн 100 сая доллар хил давж алга болдог. Жирийн иргэдийн халааснаас хамаг амьдралын эх үүсвэр нь байхгүй болоод тэгээд эдгэсэн эдгээгүйн завсар нэг ийм стресстэй ард түмэн бий болсон.

Тэгэхээр энэ утгаараа гурван асуулт.

▷ **Нэгдүгээрт**, жишээ татахад сая Төв аймгийн Баян суман дээр очиход эрүүл мэндийн барилгын зураг төсөл, ирэх оны төсөвт оруулах гэж байна. Одоо барьж өгөөч ээ гэдэг асуудал байгаа юм.

→ Монгол Улсын нийт 330 суманд хэдэд нь яг энэ хатуу дэд бүтцийн

асуудал тулгамдаж байгаа вэ?

- Үүнийг бүхэлд нь хөрөнгө оруулалт хийхэд улсын хэмжээнд ямар хэмжээний зардал хэрэгтэй байгаа вэ?
- Түүнээс хэчнээн хувь нь 2026 оны төсөвт орж байгаа вэ?

Өөрөөр хэлбэл хатуу дэд бүтэцтэй холбоотой төсвийг асуумаар байгаа юм.
Нэг.

- ▷ **Хоёрдугаарт**, эрүүл мэндийн ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааны асуудал, орон нутагт ажиллах тэр хөшүүргийн асуудал гээд энэ зөөлөн дэд бүтэц дээр ямар хэмжээний төсөв ирэх жилийн төсөвт сууж байгаа вэ?

Ер нь энэ асуудлыг цогцоор нь бүхэлд нь шийдэхийн тулд хэчнээн хэмжээний хөрөнгө оруулалтын тухай яригдаж байгаа вэ гэсэн хоёр асуултад Та хариулчих. Дараад нь тэгээд үгээ хэлье.

Б.Найдалаа: Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн гол чухал заалт бол ерөөсөө л бид эмнэлгийн тусламжаа хангалттай ард иргэддээ хүргэх, тэр дотроо яаралтай тусламжтай холбоотой асуудлыг нэлээн зөв шийдэж чадсан.

Жишээлэх юм бол төр даах тусламж, үйлчилгээ дотор **“Та даатгалтай, үгүйгээс үл хамааран хэрвээ яаралтай тусламж, үйлчилгээ авах шаардлагатай болсон бол бүх эмнэлэгт харьяалал харгалзахгүйгээр үзүүлэх боломжтой болсон.”** явдал. Энэ бол бас нэг том дэвшил байсан гэдгийг хэлье.

Тантай санал нэг байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ эрүүл мэндийн салбарт зарцуулах хувийг нэмэгдүүлэх нь туйлын зорилго.

Тэр ч утгаараа бид

- ▶ 3 жилийн хөтөлбөр,
- ▶ 5 жилийн Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөгөө ярьж байгаа.

Энэ дотор эдгээр зүйлүүд нэлээдгүй сууж, тэгээд хэмжих үзүүлэлттэйгээр орж байгаа гэдгийг хэлье.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, технологи сайжирсан. Би салбараараа бахархдаг. Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх гэж Монгол хүн эх орондоо хамгийн орчин цагийн технологиор эмчлүүлдэг байх тогтолцоог хийх гэж зорьж тэмцэж явж байгаа эрүүл мэндийн салбарынхнаар бахархаж байна.

Олон ч зүйлүүдийг хийж чадсан. Бид илүү ч хийх олон орон зай байгаа. Үүнийг дэмждэг бид сантай болсон. Эрүүл мэндийг дэмжих сангаараа дамжуулаад шинэ технологиудыг дэмжиж нутагшуулахад, Монголдоо хийдэг болоход бид их зорилготой ажиллаж байгаа. Гэлээ гэхдээ эдийн засгийн хувьд бид дандаа өгөөжтэй байхыг тооцох ёстой. Зүгээр л бүх технологийг авчирна гээд л хамаг мөнгөө үрэлгэн байдлаар зардаг биш оновчтой авчирдаг, хийдэг, нэгэнт цөөхөн тохиолддог хүчин байх юм бол харин гадаадад яваад ирэхэд нь зардлыг 100 хувь даадаг ийм тогтолцоо руу орохыг зорьж байна.

330 сумын хатуу болон зөөлөн дэд бүтцийн тухай Та ярилаа. Зөөлөн дэд бүтцээс нь ярья.

Ер нь хүний нөөцийн хувьд дэмжлэг нэлээн сайжирсан. Өнөөдөр сумын Эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эмнэлгийн ажилчид 40 хувийн нэмэгдэл авч байгаа. Суманд ажилласны төлөө. 5 жил тутам нэмэгдэл цалин 13 дахь сарын цалингаа авдаг болсон. Тийм ээ. Энэ том өргөн уудам нутагт эмнэлгийн тусламж байлгах гэсэн том зорилгын л нэг үйл ажиллагаа шүү.

330 сумын хувьд бүгдээрээ ямар ч байсан үйл ажиллагаа хийх дээвэртэй, үйл ажиллагаа явуулах орон талбайтай, тоног төхөөрөмжтэй, мөн төдийгүй бид мобайл технологи хүртэл оруулаад ажиллаж байгаа.

Тэр дотроо түрүүний хэлдэг Азийн хөгжлийн банктэй холбоотой асуудлаар бид сумаас аймаг руу иргэнийг тээвэрлэх тогтолцоогоо сайжруулах, ambulance буюу явдаг эмнэлэг, түргэнээ веб камераар хянадаг, интернэттэй, тээвэрлэлтийн явцдаа зөв эмчилгээ хийгээд аваачдаг байхаар 150 гаруй явуулын машин энэ тэр оруулаад ажиллаж байгаа. Тэгээд боловсон хүчнийг сургаж байгаа. Энэ чухал.

Харин нүхэн жорлонг багасгах асуудал бол зарим сумын эмнэлгүүд дээр нүхэн жорлон байсаар байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Дараагийн гишүүнээс өмнө Байнгын хороо зэрэг хуралдаад байгаа болохоор Б.Бейсен гишүүн нэг асуулт асуух гишүүнд нэмье. Одоо Б.Хэрлэн гишүүн асуулт асууна.

Б.Хэрлэн: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Надад гурван асуулт байна. Энд тараасан материал дээрээс харахад эрүүл мэндийн нийт зардалд хувь хүний төлөх төлбөрийн эзлэх хэмжээ 2008 оноос хойш тасралтгүй өсөж байгаа.

2020 оны байдлаар эмчилгээ үйлчилгээний зардлын 43.7 хувь нь хувь хүний карманаас гарч байгаа гэсэн байна.

Тэгэхээр 2024 онд энэ тоо нэмэгдсэн үү, буурсан уу гэдгийг би тодруулж асуумаар байна.

4 жилийн хугацаанд энэ тоо яасан бэ гэж.

2026 оны төсвийн баримт бичиг дотор ирсэн нэг санаа байсан. Тэр нь юу гэхээр иргэний карманаас гарах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсны төлөө төлөх төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх замаар, тэгээд яг онцгой чухал, хойшлуулшгүй эмчилгээ, үйлчилгээг иргэдэд үзүүлэх замаар эрүүл мэндийн байгууллагын санхүүжилт, өөрчлөлтийг оруулна гэсэн нэг ийм зорилт ороод ирсэн байсан. Өөрөөр хэлэх юм бол Эрүүл мэндийн яамнаас цаашдаа иргэдийн карманаас гарах төлбөрийн хэмжээг нэмэх бодлого баримтлаад байгаа юм уу, бууруулах бодлого баримтлаад байгаа юм уу гэдгийг би тодруулж асуумаар байна.

Хэрвээ нэмэх бодлого баримталж байгаа бол одоо тэгээд л хэн нэг нь өвдлөө гэхэд чинь тэр гэр бүл тэр чигээрээ л энд хэлмэгдээд явдаг л даа. Нэрвэгддэг. Тэгэхээр энэ асуудлыг ер нь цаашдаа яах гэж байгаа гэж?

Хоёр дахь асуулт нь, 2020 онд улсын төсвөөс болон Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилттэйгээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг 18.3 сая тохиолдолд үзүүлж байсан юм байна.

Энэ тоо 2024 онд 43.7 хувиар нэмэгдээд, 26.3 сая болсон байгаа юм. 2024 оны тоогоор. Өөрөөр хэлэх юм бол 3.5 сая хүн амтай гэхэд бараг ерөөсөө толгой дараалан жилдээ 7-гоос 8 удаа эмнэлэгт очдог юм шиг ийм тоо гарч байна л даа.

- Энэ дээр дүн шинжилгээ хийсэн үү?
- Ер нь өвчлөл нь нэмэгдээд хүмүүс байнга эмнэлэгт очоод байгаа юм уу?
- Эсвэл ерөөсөө эмчилгээний чанар нь сайн биш болохоор өвчин нь эдгэрэхгүй болохоор ингээд л эмнэлгээс салахгүй байгаад байгаа юм уу?

Үгүй бол энэ санхүүжилт чинь цаанаа асуудалтай байгаад байгаа учраас одоо ингээд хуурамч юу гэдэг юм, стор нээдэг ч юм уу, эсвэл яадаг юм, хуурамч онош тавьдаг ч юм уу тийм байдлаар санхүүжилт авах асуудал, алдаа гараад байгаа юм уу?

Тэгэхээр танай ер нь эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоогоо илүү ил тод, шударга, нээлттэй болгох тухай дээр Та салбарын сайдын хувьд яг ямар бодлого авч хэрэгжүүлэх гэж байгаа юм? Энэ хоёрыг л асууя.

Б.Найдалаа: Хариулт Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Б.Хэрлэн гишүүний асуултад хариулъя.

Ер нь карманаас гарч байгаа санхүүжилтийг бууруулах л том зорилготой юм. Нэг хэсэг овоо буурч байснаа, нөгөө 45 хувиас чинь овоо буураад 40 хувь руу орж ирээд, тэгснээ буцаад өнөөдрийн байдлаар бүр цадигаа алдлаа шүү дээ. Одоо бүр эмчлэх эм юм байхгүй, та гаднаас тэрийгээ авчир, үүнийгээ авчир гээд захиж байна гэдэг маань өөрөө буцаагаад нөгөө карманаас гарч байгаа зардлыг бүр замбараагүй болгож байгаа юм.

Тэгэхээр бид үндсэн зорилгоосоо ухарсан байна гэсэн үг. Үүнийгээ бид бууруулах том зорилго тавьж байгаа.

Тэгээд бууруулахын тулд Та чухал зүйл анзаарсан байна. Нэхэмжлэгийн тоо. Жилд гарч байгаа нэхэмжлэгийн тоо. Тийм ээ. Нэхэмжлэгийн тоо чинь бүр 18-аас 20 хэдэн сая, 24, 25 сая руу орж байна шүү дээ.

Тэгэхээр энэ нэхэмжлэг өөрөө ингэж ихсэж байгаа гэдэг нь бид хяналт тавьж чадахгүй байгаа л гэдгийн нэг том илрэл. Нөгөө гүйцэтгээд байвал санхүүжүүлээд байя гэдгийн бас нэг илрэл энэ мөн.

Хоёрт, эрт илрүүлэг гээд эмнэлгийн үзлэг хийсэнтэй холбоотой 1.7 сая иргэнд эрүүл мэндийн үзлэг хийсэн. Үүнтэй холбоотой олон олон өвчлөлүүд илэрсэн. Энэ ч бас бүр ч муу байсан зүйл гэхгүй. Тийм ээ. Жишээлбэл, өсвөр насны хүүхдүүдэд ходоодны үрэвсэх өвчин их байна шүү дээ.

Өнөөдөр бид хеликобактери буюу хоол хүнсний аюулгүй байдалтай холбоотой эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнс, бүтээгдэхүүн, үүнтэй холбоотой хеликобактерийн халдвар. Үүнээс улбаалаад ходоодны хорт хавдрын өвчлөл ямар их байгаа билээ.

Энэ болгон бас энэ эрт илрүүлэг хийгээд олон олон өвчнийг илрүүлсэнтэй холбоотой гэхэд буруудахгүй. Олон хүчин зүйл байгаа. Ганцхан зүйлээс болоод энэ ингэсэн гэж хэлж чадахгүй.

Нөгөө талаасаа бид эмнэлгийн тусламж, үйлчилгээн дээр чанарын асуудал бид ярьж байгаа. Тухайлах юм бол эмнэлэг доторх эмнэлгийн дотоод халдвар. Олон эмд дасалтай, олон антибиотикт тэсвэртэй бактериудын халдварууд бас их байна. Эдгээрүүд хүртэл энэ эмнэлэгт буцаж хэвтэх, дахин эмчлүүлэх асуудлыг хүртэл нэмэгдүүлж байгаа.

Тэгээд үүнийгээ бид бүртгэж чадахгүй. Тийм ээ. Бүртгэлээ хийхгүй. Энэ байсан юм. Хуучин цагт их зөв зөв системүүд ажиллаж байсан.

Тэгвэл одоо энэ чанараа хянадаг тогтолцоогоо хүртэл бид алджээ. Тэгээд эмнэлгүүд нь болохоор аль болохоор богино хоногт хэвтүүлээд гарах хүсэлтэй болсон. Тэгээд тэр нь гүйцэд эдгээгүй байж байгаад шарх нь задгай халдвар авдаг

ч гэдэг юм уу, бүрэн эдгээгүйгээс болоод буцаад хэвтэх ч гэдэг юм уу гээд л маш олон хүчин зүйл байна.

Тэгэхээр би тантай санал нэг байгаа. Ер нь бид үүнийг засахын тулд Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог сайжруулъя гэдэг хөтөлбөрөөр яриад байгаа нь тэр.

Одоо энэ хөтөлбөрийг бид Засгийн газар батлуулаад хэрэгжүүлэх ажил маань эхэлнэ. Маргааш Засгийн газраар саяын хяналт шинжилгээ хийсэн даатгалын тайлан орно. Үүнтэй холбоотой Засгийн газраас тогтоолууд гарна. Үүрэг чиглэлүүд өгөгдөнө.

Тэгээд эрүүл мэндийн салбарт болж байгаа ч зүйл байна, засах залруулах зүйл ч байгаа. Тэгээд үүнтэй нүүр тулаад ажиллахаас өөр арга байхгүй.

Б.Найдалаа: Дэгээрээ тодруулах юм байхгүй. Дараагийн гишүүн Б.Бейсен гишүүн.

Б.Бейсен: С.Эрдэнэболд гишүүн зөв асуудал тавьжээ. Би эмч хүний хувьд энэ эрүүл мэндийн салбарын хүн, нөгөө талаар эрүүл мэнд даатгалын сангийн байдал дээр нь санаа зовж явдаг л даа.

Үнэхээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар гүйцэтгэлд зориулсан санхүүжилтийн тогтолцоо алдагдаад байна.

Яагаад гэвэл аймгуудын нэгдсэн эмнэлгүүд дүүргийнхээ, хотын клиникийн бүгд өртэй. Авлагатай, өглөгтэй.

Тийм учраас үүнийг шийдэхийн тулд хувийн эмнэлгүүдийн санхүүжилтийг 100 хувь зогсоож байж энэ улсын эмнэлгүүдээ босгож ирэхгүй бол ер нь босохгүй гэж бодож байна би. Гөгөө талаар Эрүүл мэндийн даатгалын нэхэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүд байна шүү дээ.

- Хурц,
- Архаг,
- Төлөвлөгөөт гээд хуваасан.

Энэ бас нөлөөлж байгаа.

Хурц өвчин гарвал тэгээд санхүүжилт авна. Тэгэхгүй авахгүй гэсэн үг байхгүй юу. Жинхэнэ бодит байдал дээрээ зүрх судасны, амьсгалын зам, элэг бөөр жилд 2-оос 3 удаа хэвтдэг. Тийм улсууд эмнэлэг хэвтээд санхүүжилт нь орж ирэх ёстой байхгүй юу.

Гэтэл нэг хурц өвчин гарахгүй бол хэвтэж чадахгүй нь байна шүү дээ. Дэлхийд байхгүй юу гаргасан. Халдварт өвчин гарвал халдвартын больницад санхүүжилт нэмэгдээд. Гарахгүй бол тэгээд байхгүй болох юм шиг байна шүү дээ, ер нь.

Тэгэхээр үүнийгээ шийдэх нь зөв байх гэж бодож байна. Энэ талаар баримталж байгаа бодлого байна уу? Танд. Үүнийгээ янзлахгүй бол ерөөсөө цаашаа явахгүй нь.

Нөгөө талаар эмнэлгүүдийн бүтэц, орон тоог тухайн эмнэлгийн орны тоонд багтаасан бүтэц, орон тоог шинэчлэхгүй бол. Би байнга яриад байгаа. 2017 оны бүтэц, орон тоо гээд. Үүнийг шинэчлэхгүй бол илүү орон тоо, гүйцэтгэлтийн санхүүжилттэй холбоотой бүтэц, орон тоог өөрсдөө мэднэ гээд орон тоог нэмээд хаясан. Одоо 50 ортой дотрын тасаг гэхэд 9 эмч ажиллаж байна шүү дээ. 10-аад эмч. Нэг хүн 5-хан хүн үзэх нь байна шүү дээ.

Тийм учраас Анагаахын зохион байгуулалтын тэнхим, Эрүүл мэндийн яамны хүний нөөц, Эрүүл мэндийн яам, Сангийн яамтайгаа нийлж байгаад Хөдөлмөр, хамгааллын яамтай хамтарч байгаад бүтэц, орон тоог шинэчлэхгүй бол энэ цаашаа явахгүй. Гарын салаагаар тэгээд бүх төсөв урсаад явж байна.

Нөгөө талаар эмийн асуудлыг яаж шийдье гэж байна. Эмийн үнийн өсөлт ерөөсөө дэндлээ. Нөгөө талаар 24 цагийн аптек гээд байдаг. Шөнө бүгд хаадаг. Шөнө аптек олдохгүй шүү. Үүнийг ямар шалгуур үзүүлэлтээр тэр 24 цагийн аптек гээд эрх олгодог юм. Энэ талаар асууя. Дараа нь тодруулъя.

Б.Найдалаа: Тодруулах юм Б.Бейсен гишүүн ээ, байхгүй шүү. Дэгээрээ.

Хариултыг Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Хувийн эмнэлгүүд эрүүл мэндийн салбарын ачааллыг жигд үүрч өгч байгаа бол бид ачааллыг төр ч байна уу, хувийн хэвшил ч байна уу үл хамааран санхүүжилтийг нь өгөөд тусламж, үйлчилгээ авна. Ялангуяа манай хувийн хэвшлийнхэн **гемодиализ**⁴ (hemodialysis)-ын тусламж, үйлчилгээн дээр маш чухал рольтой оролцож байгаа.

Бид өнгөрсөн 4, 5 жил үнийн дүнг нь өсгөөгүй тарифаар ийм үйлчилгээ үзүүлж байгаа учраас бид баярлалаа гэж хэлэх ёстой.

⁴ Гемодиализын тусламж, үйлчилгээ гэдэг нь бөөрний архаг дутагдалтай (ESRD), хүнд зэргийн бөөрний дутагдалтай өвчтөнүүдэд хийдэг хиймэл бөөрний эмчилгээ.

Тэгэхээр төр бүгдийг хийе ээ гээд байгаа зүйл биш. Харин гагцхүү хүн амд суурилж эмнэлгийн тусламжаа хуваарилдаг байх нь өөрөө чухал. Тэгэхгүй тэгээд нэг газар 5, 6 хувийн эмнэлгүүд хоорондоо санхүүгээ булаацалдаад, тэгээд төрийн нэгдсэн эмнэлгүүдтэйгээ булаацалдаад, тэгээд санхүүжилтээ гүйцэд авч чадахгүй, урсгал зардлаа дийлэхгүй, цалингаа тавьж чадахгүй.

Таны хэлж байгаа үнэн. Бүтэц, орон тоо замбараагүй тэлсэн. Одоо үүнийгээ хумьж чадахгүй болсон.

Тийм учраас бид Эрүүл мэндийн тусламжийн тухай хууль буюу 2017 онд гарсан энэ хуулиа хэрэгжүүлж төлөөлөн удирдах зөвлөлтэй, бие даасан байлгах, эмнэлгүүдийг бие даалгах тогтолцоо руугаа шилжихгүй бол энд төр оролцдог байх нь өөрөө их буруу байгаа байхгүй юу.

Тийм учраас Эрүүл мэндийн яамнаас бид барьж байгаа бодлого аль болохоор энэ төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулж, ажилчдаас нь дундаас нь өөрсдөө эмнэлгийн удирдлагаа сонгох, тэгээд тэр хийж байгаа бүтээсэн ажил үйлсдээ тааруулан санхүүжилтээ авдаг байх тогтолцоог хийх нь маш чухал юм.

Эмийн үнийн тухай Та ярилаа. Тийм. Та бид хоёр эмийн үнийн өсөлт, шалтгааны түр хороонд цуг ажиллаж байсан. Өнөөдөр eBarimt-5.0 платформоо Та хараарай. Яг “reel time” шүү. Яг бодит цаг хугацаанд хайж байгаа эмийг бичээд харахад ойр хавьцаа хаана ямар аптект таны хайж байгаа эм хэдэн төгрөгөөр зарж байгаа нь гараад ирнэ.

Тийм учраас eBarimt-5.0-ийг Та татаж “appdate” хийж суулгаад, тэгээд хайвал шууд гараад ирнэ.

Дээрээс нь website-аар байж байгаа. Ижил төстэй нэр төрөл ижил эмүүд нь хаана ямар үнэтэй байгааг хараад. Энэ бол ерөөсөө л үнийг ил болгож байгаа, үнийн өсөлтийг хязгаарлаж байгаа том алхам гэж би харж байгаа.

Тийм учраас шөнө эм хайх шаардлагатай болох юм бол ялангуяа өнөөдөр үүнийг сонсож байгаа иргэдэд би зориуд хэлмээр байгаа. eBarimt-аараа дамжаад Та хайж байгаа эмийг шууд хаана очих вэ гэдгийг нь хүртэл заагаад өгнө шүү дээ. Тэр аптект яаж очих вэ гэдэг замыг нь заагаад өгнө.

- Хэдэн төгрөгөөр зарж байгаа вэ,
- холбоо барих утас нь байгаа,
- эмийн зааврууд нь байгаа,
- хориглох заалтууд нь, яаж хэрэглэх, яаж уух бүх заалтууд нь орсон байгаа.

Тэгэхээр энэ платформыг мэргэжлийн Байнгын хорооны гишүүд минь Та бүхэн олон нийтэд түгээхэд тус болоорой гэж хүсье.

Б.Найдалаа: Баярлалаа. Гишүүд асуулт тавьж, хариулт авч дууслаа.

Одоо дэгийн дагуу асуулга тавьсан гишүүн 5 минутаас идээгүйгээр үг хэлэх эрхтэй байгаа. С.Эрдэнэболд гишүүн үг хэлэх үү? С.Эрдэнэболд гишүүний микрофоныг нээе.

С.Эрдэнэболд: Юуны өмнө Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо Б.Найдалаа парга болон Байнгын хорооны Улсын Их Хурлын гишүүд Та бүхэнд талархал илэрхийлмээр байна. Яагаад гэвэл энэ маш чухал сэдэв бид авч үзэж байгаа юм.

2024 оны 7 сарын 09-ний өдөр байгуулагдсан Засгийн газар нийтдээ 578 зүйл, заалттай мөрийн хөтөлбөрийг дэвшүүлсэн.

Тэр 578 зүйл, заалттай мөрийн хөтөлбөр нь 11 хэмжих нэгжээр 4 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийг ахиулна гэдэг зорилго тавьсан. Тэр 11-ийн хамгийн эхэнд нь хүний хөгжлийн индексийг 2 оронтой тоо руу оруулна гэдэг зорилгыг тавьсан.

Одоо 197 улсаас Монгол Улс хүний хөгжлийн индексээрээ 104 дүгээр бай байранд явж байгаа.

Тэгэхээр үндсэндээ энэ Засгийн газар өмнөх Засгийн газрынхаа бодлогын зорилтыг өвлөн авсан учраас 2028 он гэхэд Монголын хүний нөөцийн индекс 100-аас дотогшоогоо буюу 99 юм уу, 98 руу орж ирнэ ээ гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Хүний хөгжлийн индексийн 3 тулгуур байдаг.

- Нэг дэх нь, эрүүл мэндийн тулгуур.
- Хоёр дахь нь, боловсролын тулгуур.
- Гурав дахь нь, орон байртай холбоотой наад захын хэрэгцээний тулгуур байгаа.

Тэгэхээр энэ эрүүл мэндийн тулгуур үзүүлэлт маань Монгол Улсын Засгийн газрын зорилтын номер нэг болсон байгаа.

Энэ утгаараа энэ сэдвийг буюу энэ асуудлуудыг бид маш нарийн шинжилж, ямар нэгэн төсвийн хэмнэлт, ямар нэгэн хоригийн ар дээр хасалт, таналт хийхдээ асар болгоомжтой, амьдралтай, ул суурьтай судалж байж шийдвэр гаргах ёстой гэж үзэж байгаа.

Энэ том хавтсыг үзүүлье. Хамгийн сүүлд Дархан-Уул аймгийн иргэн н.Халтар гэдэг 76 настай хүн 57 настай Э гэдэг охиныхоо хорт хавдрыг Хятад Улсад эмчлүүлэхэд шаардлагатай хандив хүссэн захиа байгаа.

Энд нийтдээ 100 гаран захиа байна. Хамгийн доод тал нь 7, 8 настай хүүхэд байгаа. Хүний эрхийн дэд хороо ахалж байгаа учраас яг энэ өвчин зовлон туслаа, хандив өгөөч ээ, энэ асуудлыг яаж шийдэх вэ гэсэн Монгол Улсын иргэдийн хүсэлт ирж байгаа.

Мэдээж олон саналууд ирж байгаа. Хүний эрхийн Үндэсний Комисс шилжүүлэх газар нь шилжүүлдэг зүйлүүд байгаа.

Тэгээд яг үүнийг уншихаар, үүнийг хэлэхэд яг үнэндээ маш хэцүү. Төрийн ордны баруун хаалган дээр тэргэнцэртэй иргэн миний мэдэх 2 жил сууж байна. Бас ойр дотнын хүн нь эмчилгээний зардал байхгүй гээд хүн хүний царай харсан байдалтай л сууж байгаа.

Тэгэхээр энэ нь юу гэсэн үг вэ гэхээр бид нэг талдаа асар том бодлого ярьдаг, зорилт дэвшүүлдэг ч гэсэн өнөөдөр амьдрал дээр яг ийм тулсан асуудлууд асар их байгаа юм.

Тийм учраас бид ер нь Ж.Чинбүрэн сайд гэхээсээ илүүтэйгээр Монголын Эрүүл мэндийн яам, Засгийн газрын гүйцэтгэх засаглалын энэ салбарт бид тусалъя гэж байгаа. Их Хуралд тусалъя гэж байгаа.

Өөрөөр хэлбэл яаж үе шаттайгаар эрүүл мэндийн салбарын төсвүүдийг нэмэх юм, түүнийх нь шилэн тунгалаг, ил тод байдал, зарцуулалт нь ямар байх юм. Тэнд няцаагдашгүй үндэслэл бүхий төсвүүд нь юу байх юм. Тэр нь яагаад чухал юм. Яагаад Монгол Улсын иргэн хүний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэдэг нь шууд утгаараа ямар холбоотой юм гэдэг дээр бид Улсын Их Хурал хууль санаачлах, батлах, баталсан хуульдаа хяналт тавих эрхийнхээ хүрээнд өнөөдөр энэ асуулгыг тавьж байгаа юм.

Байнгын хороо үүнийг сонор сэрэмжтэй хүлээж авч хэлэлцүүлж байгаад баяртай байна.

2025 оны 8 сарын 26-ны өдөр Ж.Чинбүрэн сайдад 2 хуудас бүхий асуулга явуулсан. 9 сарын 29-ний өдөр буюу 27 хоногийн дараа надад нийтдээ 15 хуудас, 5 бүлэгтэй хариулт ирүүлсэн юм.

Тэгэхээр юу гэж хэлэх гэж байна гэхээр яг мэргэжлийнхэн буюу эмч гишүүн Улсын Их Хурлын 126 дотор 4 байгаа.

- Б.Бейсен гишүүн байна.
- Ц.Туваан гишүүн байна.
- Т.Мөнхсайхан гишүүн байна.
- Ж.Чинбүрэн сайд байж байгаа.

Дээрээс нь. Уучлаарай, Д.Ганмаа гишүүн байж байгаа. Хүлцэл өчье.

Тэгэхээр та нарыг ярихаар бид ямар ч байсан эд нар маань ингээд болж байгаа байх, мэргэжлийн зүйлүүдээ ярьж байгаа байх гээд найддаг.

Гэтэл энэ чинь зөвхөн эмч мэргэжилтэй гишүүдийн асуудал гэхээсээ илүүтэйгээр Монгол Улсын хууль тогтоогч гишүүн болгоны Үндсэн хуулийн өмнө тангараг өргөсөн субъект болгоны хариуцах, мэдэх ёстой ойлголт болоод байгаа юм.

Тийм учраас төсөв гэнгүүт маш олон асуудлууд яригдаж байгаа. Тэгэхээр энэ дотроо жишээлбэл, ноднин жил Ерөнхийлөгчийн хориг гээд төсвийг алдагдалгүй батлангуут хөрөнгө оруулалтын зардлуудыг бүгдийг нь 20 хувь тэгшитгээд хасангуут ард нь ямар асуудал үүсэж байна гэхээр эмнэлгийн зайлшгүй зардлууд танагдсан. Зарим нь тоногдсон. Ингээд яаж байна гэхээр бээлий, маскаа хүртэл эмч нар өөрсдөө авч байна гэдэг асуудал үүсээд байгаа юм.

Энэ утгаараа нэг гарц байгаа нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Монгол Улсын төсөв нийцэж байгаа эсэхийг нийцүүлж хянах үүрэг нь аудитад байдаг хэрнээ хийж чадахгүй байгаа. Шалгуур үзүүлэлт байхгүй байгаа.

Тэгэхээр энэ дээр Эрүүл мэндийн яамнаас санал, дүгнэлт боловсруулж өгмөөр байна. Ингэж чадах юм бол бид нарт нэг гарц байна.

Манай Харвард төгссөн Д.Ганмаа гишүүн эмч мэргэжилтэй. Энэ чиглэлээрээ олон туршлагатай. Сая одоо... /минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, асуулга тавьсан гишүүн үгээ хэллээ.

Түрүүн асуулт асуух дээр би гишүүдийн зарим дутуу юмыг нь нэмээд асууя гэж бодож байгаад яах вэ, дэгээрээ дараагийн үг хэлэнд орсон болохоор одоо дэгээ зөрчөөд эргээд асууж болохгүй.

Зүгээр иймэрхүү асуултууд Ж.Чинбүрэн сайд байгаа юм. С.Эрдэнэболд гишүүний өнөөдрийн асуулга бол маш чухал байна. Яагаад гэвэл бид дан өдөр тутмын төсөвтэй холбоотой, урсгал ажилтай холбоотой асуудлыг Байнгын хороон дээр, Их Хурлаар хэлэлцдэг.

Тэгсэн хэрнээ монгол хүний эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах хүний эрхтэй холбож ерөнхийлж ярьж ярьж байгаагүй санагдаад байгаа юм.

Тэгэхээр Үндсэн хуульд заасан байгаа. “Эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхтэй” гэдгийг бид ямар шалгуураар, яаж үнэлж байх вэ. Ер нь үүнийгээ авч

байна уу, үгүй юу гэдэг дээр дүгнэлт хийх ёстой юм байна. Цаашдаа тэгээд Байнгын хороон дээр бид ярилцаад энэ тал руу нь холбох ёстой юм байна.

Хүртээмжийг жишээлбэл сайн, муу гэж хэлж байгаа. Яг юугаар үнэлж байгаа юм. Үүнийг манай зарим гишүүн сая Д.Ганбаа гишүүн дурдаад байсан. Яг яаж үнэлж байгаа юм бэ. Тодорхой асуумаар байгаа юм. Гэхдээ одоо дэгийн дагуу асуулт хариулт авахгүй болохоор Та бодож байгаад дараа ярилцъя. Магадгүй бид өөр хурал дээр юм уу, бичгээр авъя.

Бас гүйцэтгэлийн үнэлгээ гээд байгаа. Яг хууль дээр байхгүй томъёолол, эсвэл “стратегийн худалдан авалт” гэдгийг гуйвуулаад ч юм уу, тодорхой хэмжээгээр ийм буруу ойлголтоор буруу хэрэгжүүлээд байгаа гэсэн санал олон гишүүдээс ирсэн байгаа. Үүнийг хэдүүлээ яримаар юм билээ. Иймэрхүү асуултууд байсан. Дараа тэгэхдээ хариултыг авна.

Зүгээр саяын хэлэлцүүлгээс гишүүдийн асууж байгаа асуулт, бид нарын ярилцаж байгаа зүйлийг харахаар хэдэн зүйл байна.

Нэгдүгээрт, хамгийн чухал зүйл, олон давтагдаж байгаа цөм асуудал нь Эрүүл мэндийн даатгалын шинэчлэлийн асуудал байна. Өөрөөр хэлбэл өмнөх шинэчлэлийг эхлүүлсэн. Гэхдээ дараагийн шатанд гаргах асуудал. Тэр нь юу вэ гэхээр Эрүүл мэндийн даатгалын санг бие даалгах.

Уг нь энэ чигтээ явж байгаа боловч –

- ▶ Эрүүл мэндийн сайд нь өөрөө ахлаад,
- ▶ сайд нь өөрөө худалдан аваад,
- ▶ сайд нь өөрөө үйлчилгээ үзүүлээд,
- ▶ сайд нь өөрөө төлбөрөө төлөөд,
- ▶ сайд нь өөрөө нэхэмжлэхээ явуулдаг ийм болоод байгаа.

Тэгээд үүнийг Ж.Чинбүрэн сайд өөрөө сайн мэдэж байна. Үүнийгээ өөрчилье гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Тэгээд энэ дээр гишүүд бид Байнгын хороон дээр их ярьж байгаа. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хоёрдугаар үе шатын асуудал буюу Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд дорвитойхон бодитойхон шиг агуулгын хувьд саяын хэлж байгаа өөрчлөлтүүдийг хийх нэлээн том ажиллагаа. Үүнийг Байнгын хороон дээр ярьж байгаад бид өөрчилнө.

Дараа нь тэр эмийн аюулгүй байдал. Эмийн аюулгүй байдалтай холбоотой гишүүд их асууж байна. Чанарын асуудал. Энэ дээр бид Байнгын хороон дээр ярьж байгаад цаашдаа мэдээлэл авч байгаад дараагийн шатны эрх зүйн орчныг нь сайжруулах, бодлогыг тодруулах ямар асуудал байна бас ярилцана.

Бас нэг яригдаад өнгөрсөн зүйл Ж.Чинбүрэн сайд хэлж байна лээ. Энэ Байнгын хорооноос эмч, эмнэлгийн ажлын цалин хамаарна гэсэн маягтай.

Гэхдээ яах вэ бид энэ дээр ярилцсан. Гол асуудал ялангуяа 2026 оны Төсвийн байнгын хороон дээр ажлын хэсгийн гарт байгаа. Тэнд Байнгын хорооноос бид саналаа өгсөн. Тэндээс шийдэгдэнэ.

Зүгээр цаашдаа зөвхөн энэ оны асуудал биш, одоогийн асуудал биш цаашдын эмч, эмнэлгийн ажилтнуудын цалинг бодитой, шударгаар нэмээд. Нэг удаа нэмэх биш, байнга нэмэгдэж явдаг, хөдөлмөрийн шударга үнэлгээ яг түрүүний хэлдэг Эрүүл мэндийн даатгалын сангийн шинэчлэлтэй, түүний хуультай шууд холбоотой. Энэ дээр бид ажиллах болно.

Ингээд эцэст нь асуулга тавьсан С.Эрдэнэболд гишүүн болон цаг гаргаад хариулсан, яг энэ сэдвээр ярилцсан ажлын хэсгийнхэнд, Ж.Чинбүрэн сайдад баярлалаа. Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Эхний асуудал хэлэлцэж дууслаа. /алх цохив/ Дараагийн асуудалд орёё.

**Хоёр.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон
Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн
тайлан**

Дараагийн асуудал. Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Улсын Их Хурлын гишүүн, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд Н.Учрал танилцуулна.

Н.Учрал сайдыг урьж байна.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9, 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт болон Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн 19.4-д заасныг үндэслэн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журмын 3.7-д заасан аргачлалыг баримтлан Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнг танилцуулж байна.

Нэг.Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим систем <https://loginnew.unelgee.gov.mn>-д –

► Монгол Улсын 79 хуулийн 263 заалт,

- Улсын Их Хурлын 90 тогтоолын 491 заалт,
- Байнгын хорооны 69 тогтоолын 290 заалт,
- Нийт 238 шийдвэрийн 1044 заалт бүртгэлтэй байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар хууль, Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилт дунджаар 46 хувьтай байна.

Тухайлбал, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим системд бүртгэлтэй байгаа Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын харьяа агентлаг, аймаг, нийслэлийн төр, захиргааны төв байгууллагаар нь авч үзэхэд 1044 заалтаас –

- 40.6 хувь буюу 424 нь хэрэгжсэн,
- 47.7 хувь буюу 498 нь хэрэгжээгүй,
- 11.7 хувь буюу 122 нь хэрэгжилтийг тооцох хугацаа нь болоогүй гэж үнэлэгдлээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд нь авч үзвэл хуулийн хэрэгжилтийн талаар тайлант оны эхний хагас жилийн байдлаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 21 хуулийн 94 заалтыг төрийн захиргааны төв 8 байгууллага дунджаар 35.2 хувьтай хэрэгжүүлсэн байна. Үүнээс:

- 33 хувь буюу 31 заалт хэрэгжсэн,
- 60.6 хувь буюу 57 заалт хэрэгжээгүй,
- 6.4 хувь буюу 6 заалтыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй гэж тус тус дүгнэлээ.

Монгол Улсын 15 хуулийн 57 заалт хэрэгжээгүй байгаа бөгөөд уг заалтаар төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас захиргааны акт, дүрэм, журам, жагсаалт, стандарт зэргийг батлан хэрэгжүүлэх эрхийг олгосон байна.

Хэрэгжээгүй 57 заалтын 47 нь дүрэм журам, жагсаалт, заавар, аргачлал, зөвлөмж батлан хэрэгжүүлэхээр байна.

Тухайлбал, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 2014 оны шинэчилсэн найруулгаар соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, соёлын биет өвийн үнэлгээ хийх журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлан хэрэгжүүлэхээр тус тус заасан байна.

Мөн 2016 оны Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхдийн амралт, чөлөөт цагийг хөгжүүлэх чиглэлийн бодлогыг дэмжиж, хүүхдийн зусланд хэрэгжүүлэх

хөгжлийн хөтөлбөр, төслийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр санхүүжүүлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар Монгол Улсын дохионы хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг боловсролын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, клиник, түргэн тусламжийн төвөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх.

Энэ хуулийн 18.1-д заасан улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сонгон шалгаруулах гэрээ, гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг Засгийн газар, ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 2019 оны хуулиар сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналтын журмыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батлан хэрэгжүүлэхээр тус тус заасан байна.

Энэ нь захиргааны акт батлуулах үе шатны ажил болох хэрэгцээ, шаардлагыг урьдчилан судлах, төсөл боловсруулах, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийх, холбогдох байгууллагуудаас санал авах, хэлэлцүүлэг хийх гэх мэт удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байгаатай шууд холбоотой гэж тайлбарлаж болно.

Хоёр. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим системд бүртгэгдсэн 11 тогтоолын 48 заалтын хэрэгжилт төрийн захиргааны төв байгууллагын 8 яамдад дунджаар 47.7 хувьтай байна. Үүнээс:

- ▶ 48.3 хувь буюу 21 заалт хэрэгжсэн,
- ▶ 47.9 буюу 23 заалт хэрэгжээгүй,
- ▶ 8.3 хувь буюу 4 заалтыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй гэж үнэлэгдлээ.

Улсын Их Хурлын хэрэгжээгүй 6 тогтоолын 23 заалтыг нь авч үзвэл Улсын Их Хурлын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017 оны 46 дугаар тогтоолын 1.9 дэх заалтаар Засгийн газарт даалгасан хөгжлийн бэрхшээлийг тогтоох олон улсын ангиллыг нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчныг бүрдүүлж, нийгмийн бүхий л үйлчилгээнд хамруулах үүргийн хэрэгжилт үр дүнгүй гэж үнэлэгдлээ.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024-2025 оны тайлангаас авч үзэхэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг Засгийн газрын 2024 оны 138 дугаар тогтоолоор байгуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ авах иргэдийн хөдөлмөр эрхлэх ур чадвар, хэрэгцээг үнэлэх аргачлалыг үйл ажиллагааны олон улсын ангилал ICF[International Classification of Functioning, Disability and Health]-ийг ашиглан боловсруулж туршиж эхлээд байгаа талаар дурдсан бөгөөд төвөөс хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлэх сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүртгэл, судалгааг зохион байгуулж, мэдээллийн сан байгуулахаар ажиллаж байна гэсэн нь тухайн үүргийг бүрэн хэрэгжүүлсэн гэж үзэхээргүй байна.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос Эмийн үнийн өсөлт, шалтгаан нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2024 оны 38 дугаар тогтоолын 1.1.в дэх заалтаар зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орох эмийн сонгон шалгаруулалтыг тодорхой болгож, зах зээлийн бодит үнэд тулгуурлан үнэлдэг болох, эмийн үнийг хянах, борлуулалтын үнийн дээд хязгаарын зохицуулалтыг нарийвчлан тусгах, заалтын хэрэгжилтийг Эрүүл мэндийн яамны тайлан тооны эхний хагас жилийн тайланд журмын төсөл боловсруулж байна гэж тайлагнасан нь тус үүргийг хэрэгжүүлээгүй байна гэж үзэхээр байна.

Гурав.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн талаар.

Тайлант оны эхний хагас жилийн байдлаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан 20 тогтоолын 83 заалтын хэрэгжилт төрийн захиргааны төв 18 байгууллагад дунджаар 60.6 хувьтай байна. Үүнээс:

- 56.6 хувь буюу 47 заалт хэрэгжсэн,
- 37.4 хувь буюу 31 заалт хэрэгжээгүй,
- 6 хувь буюу 5 заалтыг хэрэгжүүлэх хэрэгжүүлэх хугацаа болоогүй гэж тус тус үнэлсэн байна.

Тус Байнгын хорооны

- 2017 оны 5,
- 2018 оны 2,
- 2021 оны 1,
- 2022 оны 4,
- 2023 оны 1 дүгээр тогтоолын

■ нийт 13 тогтоолын 31 заалтын хэрэгжилт үр дүн гараагүй гэж үнэлж байна.

Тухайлбал, Их Хурлын Байнгын хорооны 2020 дол 2017 оны 25 дугаар тогтоолын 1.4 улсын хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй болсон

цэцэрлэгийг буулгаж, газрын байршил, зориулалтыг өөрчлөхгүйгээр шинээр барих, Боловсролын яамны тайланд дурдагдсанаар 2024 онд 12 барилга байгууламж ашиглалтад орсон. Барилга угсралтын ажил дуусаагүй нэмэлт санхүүжилт шаардлагатай 24 төсөл, арга хэмжээ байна гэсэн нь тухайн ажлыг бүрэн биелүүлээгүй, үр дүн гараагүй гэж үзэхээр байна.

Улсын Их Хурлын Байнгын хорооны 13 тогтоолын 31 заалтын хэрэгжилт нь тухайн чиг үүргийг хүлээсэн байгууллагууд тайлагнах хугацаандаа хэрэгжүүлсэн ажил нь үнэлэгдэхүйц ахиц гараагүй, зарим тохиолдолд тогтоолын нэг заалтаар өгсөн хэд хэдэн үүргийн зарим хэсгийг гүйцэтгээгүй, тухайн заалтын хэрэгжилтийг зарим байгууллага ирүүлээгүй байх тул хэрэгжээгүй гэж үнэллээ.

Хууль, Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоолын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнгийн тайланг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт үүрэг, чиглэл өгч биелэлтийг тооцон ажиллаж байна.

Эдгээрээс дүгнэн үзэхэд Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд бүртгэлтэйтэй –

- Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудал хүрээнд хамаарах 21 хуулийн 94,
- Улсын Их Хурлын 11 тогтоолын 48,
- Байнгын хорооны 20 тогтоолын 83,
- нийт 52 шийдвэрийн 225 заалт бүртгэлтэй байгаагаас
 - 44 хувь буюу 99 нь хэрэгжсэн,
 - 49.3 хувь буюу 111 нь хэрэгжээгүй,
 - 6.7 хувь буюу 15 нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэж тус тус үнэлэгдлээ.

Монгол Улсын хууль, Улсын Их Хурал болон Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилтийг дунджаар 47.7 хувьтай байна гэж дүгнэж байна.

Тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Монгол Улсын хуулийн 47 заалтаар төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд захиргааны акт, дүрэм, журам, жагсаалт, заавар, аргачлал, зөвлөмж зэргийг батлан хэрэгжүүлэх эрх олгосон батлах чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна гэж дүгнэлээ.

Энэ нь захиргааны акт батлуулах үе шатын ажил болох –

- хэрэгцээ, шаардлагыг урьдчилан судлах,
- төсөл боловсруулах,
- үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийх,
- холбогдох байгууллагуудаас санал авах,
- хэлэлцүүлэг хийх

гэх мэт удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байгаатай шууд холбоотой хэмээн тайлбарлаж болно.

Та бүхэнд Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх, дүгнэх журмын дагуу хийсэн хяналт шинжилгээний дүнг танилцууллаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Танилцуулга хийсэн Н.Учрал сайдад баярлалаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал,
Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг,
Үнэлгээ, мониторингийн хэлтсийн дарга Б.Баярсүх,
Үнэлгээ, мониторингийн хэлтсийн референт Д.Даваасамбуу,
Ахлах шинжээч Ш.Бумаажав.

Боловсролын яамнаас:

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга П.Төгсбаяр,

Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал хүрэлцэн ирсэн байна.
Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн,
Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа,

Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Бадамжав,
Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч Ч.Баярмаа,
Дээд мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газрын шинжээч Я.Номинцэцэг,

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Ц.Нямсүрэн,

Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Н.Буянтогтох,
Боловсролын зээлийн сангийн Ажлын албаны дарга О.Сийлэгмаа.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас:

Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг,
Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр,
Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга
В.Рэнцэнханд,

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
Д.Ренчиндорж,

Гэр бүлийн бодлогын газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн
хэлтсийн дарга А.Хишигбаяр,

Гэр бүлийн бодлогын газрын Гэр бүлийн хууль тогтоомж хариуцсан ахлах
шинжээч М.Цогтбаатар,

Нийгмийн даатгалын ерөнхий газраас:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал,
Дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуяг.

Соёл, спорт, аялал жуучлал, залуучуудын яамнаас

Хяналтын газрын дарга Ч.Энх-Амгалан.

Эрүүл мэндийн яамнаас:

Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Туяа,

Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга
Б.Цэцэгсайхан,

Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар,
Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг,
Төрийн захиргааны удирдлагын газрын дарга С.Эрдэнэтуяа,
Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
Б.Янжмаа,

Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын ахлах шинжээч
Ш.Энхтуяа,

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах
шинжээч С.Энхжин,

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас:

Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах,
Эдийн засаг, судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Батхуяг нар
оролцож байна.

Хийсэн танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Д.Рэгдэл гишүүнээр тасаллаа. М.Энхцэцэг гишүүний нэр ороогүй байна.
Нэмээрэй. Л.Энхнасан гишүүнийг асуулт асуухыг урьж байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Өнгөрсөн жил энэ Их Хурлын шийдвэрийн биелэлтийг гаргаж байсан. Тэгж
гаргаж байхад дүн шинжилгээ хийхэд бас л дунджаар 30 хувийн биелэлттэй
байсан.

Өнгөрсөн жилээс ямар нэгэн ахиц гарсан уу? Биелсэн заалтууд байна уу?
Яг л нэг ийм заалтууд гарсан харагдаж байсан.

Ингээд зарим тогтоолуудын биелэлтүүдээс юм асуумаар байна. Сая Эрүүл
мэндийн даатгалын сангийн талаар ярьсан учраас Засгийн газарт чиглэл өгөх
тухай 2021 оны 10 дугаар сарын 19-ний 05 дугаар шийдвэр байна.

Энэ дээр Эрүүл мэндийн даатгалын сан төр хариуцан төлөх Эрүүл
мэндийн даатгалын шимтгэлийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, Эрүүл мэндийн
даатгалын сангийн зарцуулалтыг оновчтой болгох, төлөлтийг сайжруулах, санг
болзошгүй эрсдэлээс хамгаалах гээд. Энэ дээр хангалтгүй. Хамрагдах чиглэлд
хийгдсэн ажил үр дүн тодорхойгүй байна гэсэн байна.

Ер нь энэ дээр яам ямар бодлого баримталж байгаа вэ? Яагаад гэвэл
Эрүүл мэндийн даатгалын талаар эрүүл мэндийн асуудлыг ярихад 2024 оны
байдлаар ажил олгогчдын орлогоос шимтгэл төлж байгаа даатгуулагч нийт
даатгуулагчийн 23 хувийг эзэлж байгаа.

Гэвч даатгалын сангийн орлогын 70 хувийг бүрдүүлж байна. Тэгсэн мөртөө
сангаас зөвхөн 12 хувийг хүртсэн байна.

Гэтэл төр хариуцах иргэд нийт даатгуулагчийн 70 хувийг эзэлж байгаа.
Тэгсэн мөртөө даатгалын сангийн орлогын 27 хувийг бүрдүүлж байна. Сангийн
зарцуулалтын 70 хувийг хэрэглэж байна.

Хэдийгээр яах вэ, төр хариуцаж байгаа, энэ шимтгэлийг төлж байгаа
хариуцагчид нь хүүхдүүд байгаа, тэтгэврийн насны хүмүүс байгаа.

Гэтэл хувиараа хөдөлмөр эрхлэгч, мөн малчид, их дээд сургуулийн
сурагчид аягүй бага шимтгэл төлж байна. Энэ дээр ер нь Эрүүл мэндийн яам ер нь

даатгалын шимтгэлийг үе шаттайгаар нэмэгдүүлэх ямар ажил, бодлого бодож байгаа юм бэ? Ер нь энэ дээр хийсэн ажил байна уу?

Б.Найдалаа: Хариултыг Эрүүл мэндийн яамнаас. Н.Учрал сайд хариулах уу? Н.Учрал сайдын микрофон.

Н.Учрал: Л.Энхнасан гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх хууль байгаа.

Тэгэхээр энэ удаагийн тайланг өнгөрсөн жилээс нэг зүйлээр их ялгаатай орж ирж байна гэж хэлж болно. Яг ингээд харахад үнэлгээ 24.7 хувиар буурсан харагдаж байгаа юм. Яагаад гэхээр өмнө жил бид процессыг үнэлдэг байсан. Нэг ёсондоо хийсэн ажлуудыг, нөгөө явцыг нь, янз бүрийн хэлэлцүүлэг юу байдаг юм. Тэр болгоныг бүгдийг нь үнэлдэг байсан. Гэхдээ үр дүнг шууд үнэлдэггүй байсан.

Тэгэхээр шинэ журмаар анх удаа бид үнэлж байгаа юм. Нэг ёсондоо үр дүн гарсан уу, үгүй юу л гэж. Үр дүн гарсан уу, үгүй юу. Үр дүнд хүрэхэд явж байгаа процесс болгон дээр оноо тавихгүй.

Тэгэхээр 24.7 хувь буурсан харагдаж байгаа.

Тэгэхээр бас ахиц гарч байна уу гэвэл гарч байна гэж хэлж болно.

Тэгэхээр өмнө нь нөгөө үр дүн гараагүй ажлыг чинь бид Та бүхэн өмнө жил шүүмжилж байсан. Яагаад үр дүн гараагүй байхад энэ чинь үнэлгээ нь 60, 70 хувиар үнэлэгддэг юм бэ.

Тэгэхээр үйл ажиллагаа, процесс болгоныг нь үнэлээд эхлэхээр 30-аас 70 хувийн үнэлгээ аваад явдаг байсан. Тэр үнэлгээнүүд одоо байхгүй болсон. Одоо бол гүйцэтгэл 85-аас дээш гараагүй бол шууд “тэг” болж байгаа.

Тэгэхээр өмнө жилээсээ 24.7 хувиар буурсан гэсэн үг.

Ингээд мөн бид Их Хурлын Байнгын хорооны тогтоол буюу тогтоолоор Засгийн газарт өгч байгаа үүргүүд. 1400 орчим заалт –

→ Их Хурлын тогтоолоор өгч байгаа үүргүүд.

→ Дээрээс нь Засгийн газраас гаргаж байгаа захиргааны хэм хэмжээний актууд.

Засгийн газар үнэлгээнийхээ хэрэгцээ шаардлагыг, үр нөлөөг, зардлын тооцооллуудыг гаргаад захиргааны хэм хэмжээний актуудыг олон нийтээр хэлэлцүүлээд оролцогч талуудыг хамруулж байгаад хэм хэмжээний актыг гаргадаг.

Ингээд гаргасан актаа Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлдэг. Хууль зүй, дотоод хэргийн яам бүртгэхэд –

- ✓ хэм хэмжээний акт нь өөрөө хууль давсан хэм хэмжээ тогтоож байна уу,
- ✓ зардлын тооцоо нь байна уу,
- ✓ үр нөлөө нь байна уу,
- ✓ нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна уу

гээд энэ нөлөөллийг нь харж байгаад бүртгэж авдаг. Ингэснээрээ тэр акт хүчин төгөлдөр мөрдөгддөг.

Гэтэл Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Их Хурлын өгч байгаа тогтоолууд нөгөө үр нөлөөний тооцоо, тэр зардлын тооцоо, хэрэгцээ шаардлага үнэлэгдэхгүйгээр шууд Их Хурлын гишүүд өөрсдөө гаргаад л ирдэг юм шүү дээ. Явдаг юм шүү дээ.

Тэгэхээр хэмжиж болдоггүй. Ерөнхий үүрэг өгөхөөр хангалттай хангалтгүй, хүрсэн хүрээгүй гээд томъёолъё гэхээр энэ ажил хийгдсэн үү, хийгдээгүй юу гэдгийг үнэлэхэд бэрхшээлтэй байгаа учраас шууд 24.7-гоор буураад ороод ирсэн.

Дээрээс нь кодификац огт хийхгүй байна. Хуулийн үр дагаврын үнэлгээг бид огт хийхгүй байна.

Тэгэхээр бид <https://unelgee.gov.mn/> гээд вэбсайт байгаа. Нийт хэм хэмжээний актууд байгаа.

Хэм хэмжээ тогтоосон актуудад үнэлгээ хийж байгаа үнэлгээнийхээ систем дээр –

- ▶ Их Хурлаас гарч байгаа бодлого, шийдвэрүүдийг,
- ▶ Байнгын хорооны тогтоол шийдвэрүүдийг,
- ▶ Их Хурлын тогтоол шийдвэрүүдийг нэгтгээд нэг системд хийхээр даалгавар боловсруулаад ажиллаж эхэлсэн.

Миний хувьд мэдээж шинэ Засгийн газар байгуулагдсанаас хойш төлөвлөөд, төсөвлөөд, хянаад мониторинг хийж байгаа чиг үүрэг Эдийн засаг, хөгжлийн яаман дээр ирсэнтэй холбогдуулаад

- ➔ **Нэгд**, энэ системүүдийг нэгтгэхээс ажлаа эхэлж байна.
- ➔ **Хоёрт**, энэ шинэ үнэлгээний журам руугаа явж байна.

Ингээд эхлэхээр нөгөө төлөвлөлт маань өөрөө тэр смарт буюу –

- ▶ хэмжиж болохуйц,
 - ▶ тодорхой үр дүнтэй,
-

➤ цаг хугацаатай байлгах хэрэг үүсэж байна

буюу индикаторууд зөв байх шаардлага үүсэж байна.

Тийм учраас эхний ажил 5 жилийн үндсэн чиглэлийг сая Их Хуралд өргөн мэдүүлсэн.

5 жилийн үндсэн чиглэл бол үндэсний 10, салбарын 40 гаруй үзүүлэлтүүд, төсвийн ерөнхийлөн захирагч нарын үр дүнгийн үзүүлэлтүүд нь дандаа индикатортай болоод эхлэхээр үнэлгээ тодорхой болно гэж зорьж байгаа.

Б.Найдалаа: Эрүүл Эрүүл мэндийн яамнаас түрүүний асуултад. Ж.Чинбүрэн сайд байгаа юм байна. Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Си сая хоцорч орж ирлээ. Асуултыг зөв сонссон бол Эрүүл мэндийн даатгалын хураамжийг нэмэгдүүлэх чиглэлээр ямар ажлууд хийсэн бэ гэж асуух шиг болсон байна.

Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны нэг том гажуудал нь

➤ төрөөс шимтгэлийг нь дааж байгаа иргэдийн хураамж,
➤ ажил эрхэлж байгаа иргэдийн хураамж хоёр хоорондоо уялдахгүй зөрүүтэй байдаг.

Тэгээд санхүүжилтийн даатгалыг нь болохоор нөгөө төрөөс даатгаж байгаа иргэдийн санхүүжилт нэлээн ахиу хувийг авдаг.

Тэгээд үүнтэй холбоотой бид төсвийн төсөөлөл өргөн барихдаа ер нь 3 хувьд хүргэе гэсэн юм тавьсан боловч эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор буцаагаад 2 хувьдаа буусан.

Мөн төрөөс тусламж, үйлчилгээ хариуцаж байгаа тэр төсөв яг зарцуулагдсан төсөв хоёр хоорондоо уялддаг байх зорилгоор 200 тэрбум төгрөгийн зөрүү байдаг. Үүнийг тэнцүүлье гээд одоогийн нөхцөл байдал чадаагүй.

Б.Найдалаа: Тодруулах уу? Л.Энхнасан гишүүн тодруулна.

Л.Энхнасан: Үзүүлэлтүүд нь тодорхой болж байгаа юм байна. Тэгвэл хэрэгжээгүй олон заалтууд байна шүү дээ. Эрүүл мэндийн тухай хуульд, Боловсролын ерөнхий хууль, Соёлын тухай хууль.

Хариуцлагыг яаж тооцох юм?

Б.Найдалаа: Н.Учрал сайд хариулах уу?

Н.Учрал: Тийм. Ер нь Байнгын хорооны тогтоол бол Их Хурлаас баталж байгаа хуультай л адилхан хүчин төгөлдөр мөрдөх акт шүү дээ. Их Хурлын тогтоол ч тэр.

Тэгэхээр Их Хурлын тогтоол өөрөө хэмжигдэхүйц болсон цагт бид үнэлгээгээ, тайлангаа оруулж ирээд энэ тогтоолыг хэрэгжүүлээгүй гэдэг нь хяналтын тайлан дээр тогтоогдох юм бол хариуцлага тооцох л ёстой.

Ер нь цаашдаа ч гэсэн гүйцэтгэх засаглалд хариуцлага тооцохдоо Их Хурлын баталсан хууль журмыг хэрэгжүүлээгүй, тогтоолыг биелүүлээгүй, Байнгын хорооны тогтоолыг биелүүлээгүй бол Засгийн газартайгаа ч гэсэн хариуцлага тооцдог эрүүл механизм руу явахын тулд анхнаасаа зөв индикаторуудаа тавиад л, тайлангаа биелсэн, биелээгүй гээд л яг энэ зарчмаа бариад л 50-иас доош хангалтгүй байх юм бол гүйцэтгэх засаглал муу ажиллаж байна л гэж дүгнэнэ.

Б.Найдалаа: Баярлалаа. Хариулт болсон. Тийм ээ?

А.Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Төрийн байгуулалтын байнгын хороон дээр яг адилхан асуултыг тавьсан.

Яагаад хэрэгжилт 30-хан хувьтай байгаад хэрэгжээгүй нь 50, 60 хувьтай байгаад ийм үнэлгээ гарч байгаа учир шалтгааныг нь бид ярихгүй бол жилээс жилд дахин дахин яг л ийм асуудал орж ирээд байгаа байхгүй юу.

Агуулга талаас нь бид үнэлгээ хийх ёстой юм гэдгийг хэлээд байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бид дорвитой шийдэл гаргахгүй бол ерөөсөө болохгүй.

Тэгээд яг энэ үнэлгээг аваад үзэхээр 2017, 2018 оны өгсөн чиглэлийн биелэлтийг одоо яриад байгаа байхгүй юу. 7, 8 жилийн дараах асуудал. Тэгээд одоо хүртэл хэрэгжээгүй.

Тэгээд учир шалтгаан нь юундаа байна вэ гэдгийг бас ярих цаг байна. Үнэхээрийн биелэх боломжгүй чиглэл өгсөн юм уу гэдгийг ярих хэрэгтэй гэхээр Н.Учрал сайд надад Төрийн байгуулалтын байнгын хороон дээр Засгийн газар өгсөн бүхий л мөрөөдлийн даалгавар байсан ч бид биелүүлэхийн төлөө явна гэдэг ийм хариултыг хэлж байгаа юм.

Тэгэхээр үндсэндээ би энд юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр Байнгын хорооноос гаргасан чиглэл, тогтоолыг Байнгын хороо л авч хэлэлцэх юм байна.

Хэдүүлээ энэ үнэлгээ өгөөд байгаа 2017, 2018 оноос хойш өгөгдсөн үүрэг даалгавруудыг 49 шийдвэр гэж байна шүү дээ. Нэг бүрчлэн авч үзье. Боломжтой юм уу, боломжгүй юм уу, юун дээр байсан байна.

Удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалсан хэрэгжээгүй 24 хувь байгаа байхгүй юу. 24 заалт юм уу, 24 хувь юм уу. Удирдлага, зохион байгуулалттай холбоотой ч асуудлууд байгаад байна.

Тэгэхээр энэ дээр хууль тогтоомж, бидний гаргаж байгаа тогтоол өөрөө хэрэгждэг байх нь бидний үүрэг учраас бид ажлын хэсэг тусгайлж гаргаж үүн дээрээ ажиллаж, өөрсдөө үнэлгээ дүгнэлт хийхгүй бол Засгийн газраас дорвитой шийдэл, дорвитой хариулт өгөхгүй юм байна гэдэг итгэл үнэмшилтэй байна.

Төрийн байгуулалтын байнгын хороон дээр бас нэг яригдсан асуудал өөрөө юу юм бэ гэхээр өгөгдсөн үүрэг даалгаврууд нь биелэх боломжтой асуудлуудыг биелүүлэхгүй байгаа дээр ямар дүгнэлт өгөх вэ гэж.

Сая 2025 оны 3 сард Боловсролын байнгын хорооноос өгөгдсөн Боловсролын зээлийн сантай холбоотой үүрэг даалгаврууд сүүлийн үед цахим сүлжээн дээр ч гэсэн яригдаад байна лээ. Хүүхдүүд очоод зээлээ цаг хугацаанд нь тухайн төлбөр нь орохгүй байгаагаас улбаалж байрнаасаа хөөгдөх хүртэл асуудал үүсэж байна гээд.

Тэгэхээр яг энэ өгөгдсөн даалгаврын хувьд зээлийн эргэн төлөлтийг сайжруулах хүрээнд яг ямар ажил хийгдсэн юм бол гэдэг асуултыг Боловсролын яамнаас тавимаар байна. Тэгээд хариултыг сонсмоор байна. Тэгээд үүн дээрээ суурилад тодруулга хийе.

Б.Найдалаа: Хариулт Н.Учрал сайд. Дараа нь Боловсролын яам.

Н.Учрал: Тийм. А.Ариунзаяа сайд бид хоёрын яриад байгаа агуулга нэг зүг рүү л хараад байгаа юм л даа. Тийм.

Тэгэхээр зарчмын хувьд би дэмжээд л байгаа юм. Ажил аваад 4 сар болж байна. Өөрчлөх гэж хичээж байна. Гэхдээ асуудал байна уу гэвэл байна.

Жишээ нь, төрийн эрх мэдлийн хуваарилалтыг –

- хууль тогтоох,
- гүйцэтгэх,
- шүүх эрх мэдэл гэж хуваарилдаг.

Ерөөсөө гол зарчим нь юу юм бэ гэхээр “гүйцэтгэх засаглал” “хууль тогтоох” энэ эрх мэдэл рүү халдаж болохгүй шүү дээ.

Тийм учраас Б.Найдалаа дарга аа, танай Байнгын хорооноос надад өгөөд байгаа үүрэг даалгавар чинь буруу байна гэж би хэлэх эрх надад байхгүй. Засгийн газрын гишүүний хувиар.

Өөрөө ямар даалгавар авахаа хүсээд авдаг Засгийн газрын гишүүн гэж байхгүй шүү дээ. Надад ийм л даалгавар өгвөл би ерөөсөө хэрэгжүүлээд өгье гэж.

Тэгэхээр 2017 оноос хойш явсан Байнгын хорооны тогтоол, Түр хорооны тогтоол, Их Хурлын тогтоолууд байгаа байхгүй юу.

Гэтэл 1400 заалт чинь агуулгаараа нийцэж байгаа заалтууд байна. Энэ чинь ер нь хэрэгжсэн гэхээр кодификац хийхгүй байгаа байхгүй юу.

Тэгээд шууд “тэг”-лээд ороод ирж байгаа юм. Тайлан дээр. Тэгэхээр ойлгохоос аргагүй.

Өмнө жилээс нэг ялгаатай нь. Түрүүн миний хэлсэн ямар ялгаа байна гэхээр “үр дүнг үнэлдэг болсон” нь дэвшил байхгүй юу. Харахад ч гэсэн 24.7 хувь. Багассан юм шиг харагдаад байгаа мөртөө энэ чинь **процесс үнэлээгүй, үр дүнг үнэлсэн** учраас бага харагдаад байгаа юм. Энэ нь зөв өө. Цаашдаа ингээд л явъя.

▷ **Хоёрт**, яамд журмаа батлахгүй байна. Бид үүнийг Засгийн газар дээр байнга шахаж байгаа.

Дээрээс нь Их Хурал дээр. Сая Их Хурлын дарга Д.Амарбаясгаланг дэвшүүлээд байсан. Ерөөсөө тэр хууль давсан журмыг цэгцлэе гээд. Энэ ажил маш зөв.

Яагаад гэхээр хууль баталдаг. Тэгээд нэг хууль чинь 17 журамтай гарч ирж байна шүү дээ. Анх 2016 онд Их Хурлын гишүүн болоод л Инновацийн хууль дээр яг нэг ийм шалгах ажлын хэсэг байгуулсан. 17 журам.

Тэгээд тэр журмыг батлах гээд Боловсролын яамтай хөөцөлдсөөр байгаад дуусаж байгаа юм. Нэг ёсондоо журмаа огт баталдаггүй. Тэгэхээр хууль нэг мөр хэрэгждэггүй.

Тийм журмыг Засгийн газар батална гэдэг. Баталдаггүй.

▷ **Гуравт**, хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй үүрэг өгөгдөөд байна.

Тэддүгээр улиралд ч гэдэг юм уу хатуу хугацааг заахгүй бол 2017 оны тогтоолууд чинь одоо хугацаа нь дуусаагүй учраас яваад байгаа юм. Үүнийг хугацаатай болгох шаардлага байгаа юм.

▷ **Дөрөвт**, санхүүжилтийн асуудал.

Санхүүжилт шаардаж байгаа үүрэг, даалгавар өгөхөр нөгөө төсөв мөнгө нь дийлдэггүй. Ингээд юу болоод байна гэхээр ерөөсөө л үр дүн байхгүй, байхгүй гээд тайлагнаад байгаа байхгүй юу.

Өмнөх жилээсээ ямар ч байсан үүгээрээ ялгагджээ. Үнэлгээнүүдийгээ Их Хурал бай, Засгийн газар бай бүх захиргааны хэм хэмжээ тогтоосон актуудыг нэг системд нийлүүлбэ гэдэг асуудлыг бид оруулж ирээд өөрчлөх гээд үзэж байгаа.

5 жилийн чиглэл ирэх 7 хоногоос хэлэлцэж эхлэхэд нэг зүйлд итгэлтэй байгаа нь яг энэ индикаторуудыг шууд тоотой нь, хугацаатай нь тавьсан. Тоогоор хэмжинэ. QUANTITATIVE⁵ арга зүй ашигласан.

Түүнээс бид зөвхөн чанарт суурилна гэж яриад байдаг. Яг үнэндээ чанарт суурилна гэдэг чинь зүгээр бие биеэ илж байгаа хэрэг байхгүй юу.

Яг эдийн засгийн эрх чөлөөний индексээр дэлхийн улсуудын эхний 60-д орно л гэвэл орох л ёстой. Ирэх жил 3 байр урагшлах л ёстой. Урагшлаагүй бол тэр юмаар Монголын эдийн засгийн форум 10 хийгээд ч нэмэргүй байхгүй юу. Өмнөх үнэлгээний журмаар 10 хийснийг нь үнэлээд л 60 хувь гээд тавьдаг байсан.

Тэгээд та нар юу ч хийгээгүй байж юуны чинь 60 хувь гээд өмнө жил яг энэ Төрийн байгуулалт дээр намайг Хэрэг эрхлэхийн сайд байхад тэгээд шүүмжлээд байсан байхгүй юу.

Тэгэхээр ер нь цаашдаа үнэнээ яриад л, муу бол муу, сайн бол сайн. Засгийн газар эргээд Их Хурлынхаа өмнө хариуцлага хүлээдэг зарчим руу явах нь зөв юм байна гэж би А.Ариунзаяа сайдтай санал нэг. /минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Х.Батжаргал дарга. Микрофон 1.

Х.Батжаргал: Боловсролын зээлийн сантай холбоотой үйл ажиллагааг нь сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний тухай Боловсрол, шинжлэх ухааны байнгын хорооны тогтоол гарч, хэрэгжүүлэх журмыг шинэчлэн баталсан байдаг. Засгийн газраар.

⁵ Квантитив арга зүй нь:

- Тоон мэдээлэл цуглуулах;
- Хэмжигдэх боломжтой үзүүлэлтүүдийг ашиглах;
- Статистик анализ хийх;
- Харьцуулалт, корреляци, регресс зэрэг тооцоо гаргах;
- Дүн шинжилгээ нь объектив, дахин шалгаж баталгаажуулах боломжтой.

Үүний хүрээнд зээлийн эргэн төлөлтийг сайжруулах, төсвийг төлөвлөхдөө хүртэл эргэн төлөлтөөс нь дараагийн зээлийг санхүүжүүлэх төлөвлөлтүүд хууль болоод Төсвийн тухай хуульд орсон ийм үүрэг хүлээгээд явж байгаа.

2025 оны эхний 10 сарын байдлаар 15 тэрбум төгрөгийн эргэн төлөлт зээлийн сан дээр хийгдээд явж байгаа.

Тэгэхээр авах арга хэмжээний хүрээнд юу хийсэн бэ гэхээр энэ ер нь зээлийн мэдээллийн санд хэрвээ зээл авсан бол бүртгэгдэх ёстой. Тэгээд энэ ажил хийгдээгүйгээс нэлээн хугацаа, бүртгэлээс болоод эргэн төлөлт удааширч байсан. /минут дуусав/

Б.Найдалаа: А.Ариунзаяа гишүүн тодруулах уу? Тодруулаад тэгээд хариулаарай.

А.Ариунзаяа: Би сая Төрийн байгуулалтын байнгын хороон дээр гишүүдтэй холбоотой асуудлыг ярьж байхдаа ийм асуудал хэлсэн юм.

Улсын Их Хурлын гишүүний хүүхэд болсноороо тэтгэлэгт хамрагдах эрхгүй боллоо гэж. Яагаад гэвэл тухайн хүүхэд ээж, аав нь хэн байхаас үл хамаараад өөрөө шалгалтаа өгөөд, өөрөө мэдлэг дээрээ тэнцсэн бол эрх нь уг нь нээлттэй байх ёстой юм гэж.

Гэтэл яг одоогийн байдлаар ёстой жинхэнэ эрх мэдэл албан тушаалаа, танил талаа ашиглаж зээл авсан хүмүүстээ эсрэгээрээ хариуцлагыг нь хүлээлгээгүй л байгаа байхгүй юу даа. Сонгуулиас өмнө энэ асуудлыг яриад тэгээд чимээгүй болсон.

Жинхэнэ хариуцлага хүлээлгэх ёстой, эрх мэдэл албан тушаалаа ашиглаж зээл авчхаад эрх, үүргээ хүлээлгээгүй тэр хүмүүстэй хариуцлагаа ярихгүй байгаад чинь зэвүүцэл хүрээд байгаа байхгүй юу.

Тэгээд энэ асуудлыг Байнгын хороо уг нь ярьсан юм, чиглэл өгсөн юм. Тэр юу болж байна вэ гэдгийг л хариул.

Б.Найдалаа: Микрофон 1. Асуулт тодорхой. Товч тодорхой хариулаарай. Х.Батжаргал дарга аа.

Х.Батжаргал: Зээлийн эргэн төлөлт, мөн түүн дотроо чөлөөлөлтийн асуудал яригддаг.

Тэгээд энэ хүрээнд Засгийн газраас танилцуулга, тогтоолын төсөл, мэдээлэл оруулаад авч хэрэгжүүлэх арга хэмжээний асуудлыг оруулсан, танилцуулсан.

Хуулийн байгууллагууд шалгагдаад явж байгаа асуудал байгаа.

Тэгэхээр хуулийн байгууллагын процессыг бид харгалзаж үзэж явж байгаа. Дөрөвдүгээр улиралд эргэж танилцуулж тайлагнах үүрэг хүлээгээд явж байгаа.

Б.Найдалаа: А.Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Тэгэхээр бид өөрсдөө бас яг энэ Боловсролын зээлийн сантай холбоотой ч гэсэн зүгээр хаяж болохгүй. Байнгын хороо энэ тогтоолынхоо араас явах ёстой юм байна гэдэг ийм л саналыг хэлээд байгаа юм.

Тэгэхээр тодорхой асуудлууд яригдах үедээ яригдаад, улс төржөөд ингээд дарагддаг байж болохгүй шүү дээ. Тэгээд шударга ёсыг ярьж байгаа бол үнэхээрийн жинхэнэ л шударга ёсыг бий болгохын төлөө л ажиллана уу гэхээс биш тэгээд л нэг ярих үедээ ярьчихаад л, хуйвалдах үедээ хуйвалдаад л дараад сууж бас болохгүй шүү дээ.

Тэгэхээр Үндсэн хууль бол хүн бүр л тэгш эрхтэй байх гэж заасан байдаг. Тэгээд үүнийг ч гэсэн бид төрийн түшээд л юм бол өөрийнхөө энэ гаргаж байгаа тогтоол шийдвэр дээрээ ч гэсэн бас нэг биелэлтийг нь нэхэж явах нь зөв юм байна гэдэг л ийм саналыг хэлээд байгаа юм.

Б.Найдалаа: А.Ариунзаяа гишүүний тэр асуугаад байгаа асуултыг би давтаад тодруулъя. Х.Батжаргал дарга аа.

Тэр нэг чөлөөлснийг, хүчингүй болгосныг Засгийн газар шийдвэр гарсан санагдаад байх юм. Гарсан билүү, гараагүй билүү? Тийм үү. Үгүй юм уу? Яригдаагүй юм уу?

Байнгын хорооноос уг нь нэг чиглэл өгсөн санагдаад байх юм. Микрофон 1.

Х.Батжаргал: Энэ асуудлаар чиглэлийн дагуу Засгийн газарт танилцуулга хийгээд холбогдох тэмдэглэлээр Боловсролын яаманд үүрэг өгсөн байгаа.

Энэ юу вэ гэхээр 2025 оны дөрөвдүгээр улиралд багтааж эргэж авч хэлэлцэж танилцуулах юм. Яагаад гэхээр хуулийн процесс зэрэг яваад байгаа. Авлигатай тэмцэх газар, прокурорын түвшинд яваад байгаа учраас. Авлигатай тэмцэх газар бол үүнийг шууд хүчингүй болго гэдэг асуудлыг тавьдаг. Шууд хүчингүй болгохоор эргээд хуулийн шийдвэр нь эцэслэн гараагүй байгаа учраас энэ яг эцсийн үнэн зөвийг нь хуулийн байгууллага л тогтоох ёстой байгаа.

Б.Найдалаа: Д.Рэгдэл гишүүн асуулт асууна.

Д.Рэгдэл: Ноднин бид хэлэлцсэн. Тэгэхэд Засгийн газрын хяналтыг хэрэгжүүлэх газраас Байнгын хороодоор тань яг адилхан танилцуулга хийгээд яг л

нэг иймэрхүү хэрэгжилттэй тайлан сонсоод, тэгээд ямар нэгэн шийдэл ч гараагүй тэгээд л явсан.

Энэ жилийнх Их Хурлын Тамгын газраас хийсэн дүн шинжилгээгээр тайлангаа их оройтож ирүүлсэн юм байна. Хэрэг эрхлэх газраас тайлан гаргаж ирүүлсэн юм байна.

Хэрэг эрхлэх газраас тайлан ирүүлсэн юм бол энэ тайлангаа Хэрэг эрхлэх газар нь бид нарт танилцуулаад явбал энэ их зөв зүйтэй юм шиг л санагдаад байгаа юм. Тэгээд яагаад ийм байдал Тэргүүн Шадар сайдын тайланг танилцуулах болоод байгаа юм бол? Эсвэл тийм дүрэм журам гарсан юм болов уу гэж нэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт, энэ чинь 30 орчим хувийн хэрэгжилттэйгээ гардаг юм байна. Энэ жил аргачлал нь ч өөр, үнэлгээний аргачлал өөр болсон. Тэгээд манай Байнгын хороонд хамрах асуудал чинь ноднингийн Боловсрол, шинжлэх ухаан, соёл, спортын Байнгын хороо, энэ жилийн хуучин ноднингийн юм даа. Нийгмийн бодлогын байнгын хороо бүгд нийлсэн учраас их олон бодлогын зорилтууд орж ирээд, тэгээд тэр дунд хэрэгжээгүй зорилт их олон болсон юм байна.

Тэгээд бодохоор бид Байнгын хорооны түвшинд ямар нэгэн үнэлгээ өгөх өөр нь боломжгүй ингэж гараад байгаа. Энэ гүйцэтгэлийн дэлгэрэнгүй дээр хараад байхаар хэрэгжсэн хууль тогтоолын хэрэгжилт нь хоёр нүүр орчим юм байна. Хэрэгжээгүй нь 42 нүүр болсон байгаа юм.

Тэгэхээр энэ дээр дүгнэлт хийж үзэх хэрэгтэй. Хэрэгжээгүй хэсэг нь 42. Өөрөөр хэлбэл 21 дахин зузаан юм байна шүү дээ. Хэрэгжээгүй хэсэг чинь.

Хэрэгжээгүй хэсгийг нь аваад үзэхээр –

- тайлагналт хангалтгүй,
- тайлагнаагүй,
- үр дүн тодорхойгүй гэсэн юм байгаа юм.

Гэтэл тайлан гаргаж байгаагийн нэг гол учир шалтгаан нь тэр хариуцсан ажилдаа тэр төрийн албан тушаалтан хэрхэн хандаж байна вэ гэдгийг энэ тайлангаар тодорхойлдог.

- ▷ **Нэгдүгээрт**, Тайлангаа ирүүлээгүй нөхдүүдтэй ямар арга хэмжээ авдаг юм бэ?
 - ▷ **Хоёрдугаарт**, хангалтгүй, үр дүн тодорхойгүй тайлагнаад байгаа удирдах албан тушаалтан гэж хүн байдаг юм уу, эсвэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тодорхой хэсэг, нэгж, албад байдаг юм уу? Нэг ийм асуулт байна. Энэ дээр ямар арга хэмжээ авдаг юм?
-

▷ **Гуравдугаарт**, хэрэгжих боломжгүй болсон юмнууд энэ дотор байгаа. Тэр 2017 оны Их Хурлын тогтоолуудтай холбоотой хууль эрх зүйн орчин шал өөр болоод явсан. Үүнийгээ энэ дотроосоо хасуулдаг тийм эрх зүйн боломж байдаг юм уу?

Б.Найдалаа: Н.Учрал сайд.

Н.Учрал: Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуульд шинэ Засгийн газар байгуулахад өөрчлөлт орсон.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар буюу одоо нөгөө Хяналтын үндэсний хороо бие даасан сайдтай байсан. Ингээд тус сайд Засгийн газрын бүтцээс хасагдсан учраас хяналт хэрэгжүүлэх газар Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэд ирсэн.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх хууль дээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хяналтаа тавина.

Хөгжлийн бодлогын баримт бичгийг Эдийн засаг, хөгжлийн яам –

- төлөвлөөд,
- төсөвлөөд,
- хянаад,
- мониторинг хийх чиг үүргээ хэрэгжүүлнэ гэж заагласан.

Уг нь л их л зөв л замаар явж байгаа юм.

2024 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлахад нөгөө “DME” гээд design хийгээд, monitoring хийгээд, evaluation хийнэ гэдэг. “DME” нэвтрүүлнэ гээд нэг заалт биччихээд бүтэн жил тодорхой үр дүнд хүрээгүй байхгүй юу.

Тэгэхээр хүрээгээ тодорхойлох ёстой. Framework-той болох ёстой гэж тухайн үед оруулж ирсэн юм. Гэтэл тэр нь бас үр дүнд хүрээгүй. Тэгээд бид сая Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх хууль дээр хууль тогтоомжоо салгаад, хөгжлийн бодлогоо салгаад явсан.

Ер нь Эдийн засаг, хөгжлийн яам зөвхөн эдийн засаг гэхээсээ хөгжлийн яам. Хөгжлийн бодлого хариуцаж байгаа яам баталж байгаа хууль дүрэмд, баталж байгаа Их Хурлын тогтоол, шийдвэр, захиргааны хэм хэмжээний акт, Засгийн газраас өргөн мэдүүлж байгаа хууль, Их Хурлын хуулиуд нь өөрөө хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцэж байна уу эсэх дээр л хяналт тавих ёстой. Нэг замаар явах ёстой шүү дээ. Бид чинь.

Тийм учраас 5 жилийн чиглэл гэж гаргаад байгаа юм.

- Тэгэхээр 5 жилийн чиглэлтэй
- хууль нийцэж байна уу,
- захиргааны акт нийцэж байна уу.

Тэгээд 5 жилийн чиглэлд нийцсэн “улсын жилийн төлөвлөгөө” Их хурлаар баталдаг.

Ингээд жил болгон төсөв батлуулахад төсөв дээр Эдийн засаг, хөгжлийн яам зөвшөөрөл өгдөг. Энэ нь улсын төсөв, улсын жилийн төлөвлөгөөнд нийцэж байна гэж. Нийцэхгүй бол буцаах ийм л чиг үүргийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиар анх 2019 онд хийсэн.

Яг энэ ажлаа хийж чадвал цаашаа Монголын Улсын хөгжлийн бодлого тогтвортой байна. Нөгөө хэнбугай ч сайд болохоос үл хамаараад.

Тэгэхээр үүнийгээ бид төсөв барьдаг шигээ хатуу барих ёстой. Тэгээд үүнийгээ л хэрэгжүүлэх гээд зориод явж байгаа.

Тэгэхээр Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийнхоо хэрэгжилтэд чиг үүргээрээ хяналтаа тавих ёстой гэдгийг хэлье. Зүгээр Засгийн газрын төлөөллүүд миний бие өнөөдөр энэ тайланг Та бүхэнд танилцуулж байна. Яах вэ мэдээж энэ чинь хяналтыг хариуцаж байгаа Засгийн газрын гишүүний хувиар.

Тайлан, мэдээллээ ирүүлээгүй байгууллагуудад Хяналт хэрэгжүүлэх газраас сануулах бичгүүдийг явуулсан. Бид тайлан, мэдээлэл ирүүлээгүй албан тушаалтнууд, төрийн захиргааны байгууллагуудыг Засгийн газар дээр танилцуулж хариуцлага тооцно. Тэгээд тооцоод л явъя.

Ер нь зарчмаа барьж явж байгаа тохиолдолд буруудахгүй. Зарчмаа алдаад, дабль стандарт үйлчлээд, заримд нь тэр нь үйлчилдэггүй, заримд нь үйлчилдэг болоод эхлэхээр л төрдөө итгэх итгэл үнэмшил алдагдаад байна л даа.

Тийм учраас үнэхээр тэр тогтоол шийдвэр хэрэгжүүлээгүй, тайлангаа цаг хугацаанд нь өгөхгүй байгаа нөхдүүдэд хариуцлагыг хэн нэгний хамаатан садан, ах дүү, царай төрх ялгахгүйгээр хариуцлага тооцдог байх юм бол төрд ч гэсэн хүмүүс итгэлтэй ажиллана шүү дээ. Зарим нь хамгаалалттай, зарим нь хамгаалалтгүй. Тэгээд хамгаалалтгүй нь хэлмэгдэж байдаг. Хэмнэлт хийгээд 9 хувь оруулж ирэхээр хөөрхий ажлаа сайн хийж байгаа хүмүүс нь хэлмэгддэг тохиолдлууд байна шүү дээ. Тэгээд төрд тогтвортой ажиллах нөхцөл бүрдэхгүй.

Тийм учраас энэ дээр хариуцлагын асуудлыг заавал ярина гэдгийг хэлье. Энэ дээр хариуцлага тооцсон асуудлаар нэмэлт мэдээлэл ажлын хэсэг өгөх байх.

Б.Найдалаа: Ажлын хэсэг микрофон 4.

Б.Батцэцэг: Гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар. Б.Батцэцэг.

Өмнө нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх үнэлсэн үнэлгээний дагуу Засгийн газар дээр танилцуулагдаад тэмдэглэл, тогтоолоор үүрэг болгосон байдаг.

Энэ хүрээнд 3 аймгийн Засаг дарга, 3 Төрийн нарийн бичгийн дарга нарт арга хэмжээ тооцох асуудал хийгдэж байсан юм билээ.

Энэ удаагийн хувьд хагас жилээр орж ирж байгаа.

Тэгэхээр хагас жилээр гэдэг маань хууль тогтоомжийн хэрэгжилт 6 сарын 31-ний байдлаар гэсэн үг. Үүнээс хойш хэрэгжээд үр дүн нь гарсан зарим нэг хууль тогтоомж, журам баталсан заалтууд байгаа.

Тэгэхээр 2025 оны 12 сарын 31-ний байдлаар тасалбар болгоод жилийн эцсийн тайлан орж ирэхдээ хариуцлага тооцсон асуудал цугтаа танилцуулагдаад явах байх.

Б.Найдалаа: Баярлалаа. Д.Рэгдэл гишүүн тодруулах юм байхгүй. Болсон. Тийм ээ? Баярлалаа. О.Саранчулуун гишүүн байхгүй байна. Д.Ганмаа гишүүн.

Д.Ганмаа: Бид уг нь маш чухал юм харж байна. Тийм ээ. Хүний хөгжил нийгмийн бодлогын асуудлын хүрээнд Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг хэлэлцээд асуух асуулт, тэгээд санхүүжилт, үр нөлөө, уялдаа холбоо эдгээрийг харах боломж гарч байна л даа.

Тэгээд бид хараад сууж байна. Биелэлт аягүй бага байна ойлгомжтой. Яагаад гэдгийг ч гэсэн тодорхой хэмжээгээр тайлбарлалаа.

Хүснэгт болгоныг харахаар ард талд нь ер нь тайлан ирүүлээгүй, үр дүн тодорхойгүй, хангалтгүй, ойлгомжгүй, танилцуулаагүй, ач холбогдолгүй, журам хэрэгжүүлээгүй, аргачлалыг батлаагүй, шалгуур байхгүй. Дандаа үгүй, үгүй гэдэг ийм санаанууд гараад байна.

Зүгээр товчхон хоёр, гуравхан асуулт хэрвээ асууя гэвэл. Одоо жишээлбэл зөвхөн эрүүл мэндийг цөмөөрөө харъя л даа. Энд сүрьеэ өвчлөл гэж байсан. Тийм ээ. Жишээлбэл, энэ хүснэгт 5 дээр байна.

Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусийн тархалт. Ирүүлсэн заалт 1, хэрэгжээгүй заалт 1.

Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирус мөн адилхан заалт 2. Бас л хэрэгжээгүй заалт нь адилхан 2.

Эрүүл мэндийн салбар бодлого, Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох гээд тайлан ирүүлсэн заалт нь 1, хэрэгжээгүй нь ахиад 1 гээд л уншаад л байвал ерөөсөө хэрэгжээгүй дээрээ дандаа яваад байх юм.

Энэ гол учир шалтгаан нь юу байдаг юм бол? Юу ч гэсэн эхлээд энэ асуултад хариулт авъя.

Б.Найдалаа: Хариулт Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Ер нь чухал заалтууд байгаа. Ялангуяа эрүүл мэндийн салбарт тулгамдаж байгаа бэлгийн замын халдвар. Дээрээс нь далд сүрьеэ, олон юманд тэсвэртэй сүрьеэ гээд л энэ болгонтой тэмцэх асуудал ерөөсөө манай салбарын нэн тулгамдаж байгаа асуудлууд.

Сүүлийн үед өвчлөлийн байдлыг харсан ч гэсэн ер нь тандалт судалгаа хийхэд ноцтой байгаа. Зүгээр хэрэгжээгүй, яагаад вэ гэдгийг би хариуцаж байсан биш болохоор тухайн үеийн асуудлыг танд тайлбарлаж мэдэхгүй байна.

Ер нь Засгийн газрын хяналт, энэ хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг шалгадаг болсон явдал ер нь Засгийн газрын салбар бүрдээ илүү анхааралтай ажиллах, үүнийгээ биелүүлдэг байх, өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, болоогүй бол санхүүжилтийн ямар бэрхшээлүүд байсан талаараа хүртэл мэдээлдэг байх нь чухал.

Тэгэхээр 6 сарын 17-нд Эрүүл мэндийн сайдаар томилогдсон. Шинэ Засгийн газарт орсон. Үүнээс хойш хэрэгжилттэй холбоотой зүйлүүд дээр онцгой анхаарч, эдгээрийн биелэлтэд анхаарал тавьж ажиллаж байгаа.

Б.Найдалаа: Иодруулах уу? Д.Ганмаа гишүүн. Д.Ганмаа гишүүн тодруулна.

Д.Ганмаа: Тэгвэл эрүүл мэндийн салбараас асуух юм байхгүй болж таарлаа.

Бусад салбаруудаас нь асууя. Ерөнхий том зургаараа харъя.

Хүний хөгжлийн индекс, ядуурлын түвшин, орлогын тэгш бус байдлын үзүүлэлт. Эдгээр дээр бодлогын хэрэгжилтэд ямар нөлөө үзүүлсэн бэ? Энэ

хэрэгжилт нь хэр зэрэг байгаа вэ? Болж байгаа, болохгүй байгаа асуудлууд нь, шалтаг шалтгаанууд нь юу байгаад байдаг юм. Хариулж өгөөч.

Хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настны нийгмийн хамгааллын бодлогын асуудлууд байгаа. Эдгээрийн уялдаа холбоо ямар байгаа юм? Хэрэгжилт дээр ямар асуудлууд гараад, хэрэгжихгүй байгаа шалтаг шалтгаан нь юу байгаа юм?

Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг давхардаагүй байдлаар зорилтот бүлэгт хүрч чадаж байна гэж үзэж байна уу, үгүй гэж үзэж байна уу? Үгүй бол мөн хэрэгжилт дээр ямар саад бэрхшээл тулаад байгаа вэ гэдэг дээр хариулт авъя.

Сургуулийн өмнөх... /минут дуусав/

Б.Найдалаа: Хариулт. Микрофон 4.

Б.Батцэцэг: Д.Ганмаа гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас зөвхөн хууль тогтоомжийн хэрэгжилт биш таван жилийн үндсэн чиглэлийн бүтэн тайланг бас оруулж ирсэн.

Түүнд хүний хөгжлийн индекс, нийгмийн бодлогын хөгжилтэй холбоотой суурь түвшиндээ хүрсэн үү, хүрэх түвшиндээ хүрсэн үү, суурь түвшинтэйгээ харьцуулахад ямар байв гэдэг тайлангууд явж байгаа.

Хөтөлбөрүүдийг үнэлэхэд яах аргагүй байгууллагуудын ирүүлсэн тайланг үнэлэхээр бид хэчнээн шинэ журмаараа процесс үнэлэхгүй ээ, үр дүн үнэлнэ ээ гэсэн чиг процесс маш их ирсэн. Тэр процессыг бид бүгдийг нь дандаа “тэг”, “тэг” гээд аваад явсан болохоор харьцангуй үзүүлэлт доошоо бууж орж ирж байгаа.

Энэ журам дээр нэг шинэлэг зохицуулалт орж ирсэн. Бодлого хөтөлбөрүүд хэрэгжихгүй байгаа шалтгааныг нь газар дээр нь ажиллах боломж Засгийн газрын шинэ тогтоол, одоо энэ үнэлж байгаа журмаар орж ирсэн. Тэр дагуу бид хууль тогтоомжийн хэрэгжилтийг Засгийн газар дээр танилцуулаад, одоо ажлын... /минут дуусав/

Б.Найдалаа: Юу яая. 4 минутаар гүйцээлгэе. Хариулт 1 минут микрофон 4-т.

Б.Батцэцэг: Ажлын хэсэг гараад удирдамжаа баталсан байгаа. Бид хөтөлбөрүүдийн яагаад хэрэгжихгүй байгаа шалтгааныг газар дээрх үнэлгээ гэдэг үнэлгээ хийхээр ажлын хэсэг дараагийн 7 хоногоос ажиллах гэж байна.

Тэгэхээр энэ тайлан жилийн эцсийн тайлан дээр цугтаа орж ирэх байх. Урьд нь дандаа ирүүлсэн тайланг л үнэлээд яваад байдаг байсан юм билээ.

Яамдаас, агентлагуудаас, орон нутгаас ямар тайлан ирнэ тэрийг үнэлээд яваад байсан.

Тэгэхээр Их Хурал дээр яригддаг шиг хэдэн төгрөгийн төсөв зарцуулав, ямар ямар арга хэмжээ авав гээд байдаг. Ерөөсөө бодит үр дүнг бид тайлагнаж чадаагүй байсан.

Б.Найдалаа: Нэг юм тодруулаадахъя. Тайлан дээр байна. Биелэлт гээд үг байна шүү дээ. Биелэлт, үр дүн хоёр ялгаатай юу? Микрофон 4.

Б.Батцэцэг: Яах вэ, үнэлгээ мониторинг, хяналт шинжилгээний асуудал одоо хүртэл яг энэ үнэлгээчдийн хувьд журам дээр, эсвэл хуульд хэрэглэгдэж байгаа агуулга, нэр, томьёо, концепцын хувьд зөв үү, буруу юу гэдэг маргаантай асуудал байгаад байна.

Бид үр үнэлгээ, үр дүн хоёрыг юу гэж хараад байна гэхээр үнэлгээ гэдэг маань үр дүнгээ үнэлсэн тодорхой бид аргачлалын дагуу үнэлээд байгаа тэр хувь коэффициентоо хэлж байгаа гэж ойлгож үнэлгээг хийж байгаа.

Б.Найдалаа: Түрүүн тайлбар дээр жоохон ойлгомжгүй байгаад байсан.

Одоо жишээлбэл нэг тогтоол гарсан байна. Түүнийхээ дагуу шийдвэр гаргасан. Журам баталсан байна. Биелэлт 100 хувь гээд л гарч байгаа байхгүй юу. Үр дүнтэй эсэх нь юу болсон юм. Тэр нь тусдаа юу? Хамтдаа юу? Одоогийн яг энэ тайлан дээр. Микрофон 4.

Б.Батцэцэг: Хууль тогтоомжийн хяналт шинжилгээ дээр яах аргагүй энэ асуудал орж ирээд байгаа.

Бид сайдын яриад байгаа тэр 5 жил дээр “Кей Пи Ай” тавиад үнэлнэ гэхээр хууль тогтоомж дээр ер нь юу байх юм бэ? Бид хууль тогтоомжийг хагас бүтэн жилээр үнэлээд байгаа маань өөрөө зөв үү, буруу юу. Ялангуяа хууль дээр.

Энэ асуудлыг бид Их Хурлын Тамгын газартай ярилцаж байна. Бид нарт энэ үнэлгээ маань нэгдүгээрт шинэ тутам. Ажил сайжруулах шаардлагатай, үр дүнг нь гаргах шаардлагатай учраас энэ асуудлыг бид ярилцаад явж байна л даа.

Нэгдсэн шийдэлд хүрч чадаагүй. Гэхдээ тал талууд ямар ойлголцолд хүрсэн гэхээр бид энэ хууль тогтоомжийг үнэлж байгаа арга аргачлалыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа.

Б.Найдалаа: Ойлголоо. Баярлалаа. Тэгвэл одоо ярихдаа, тайлбарлахдаа ялгаж ярихгүй бол үр дүнг үнэлсэн, эсвэл биелэлт гээд холилдоод яваад байна шүү.

Ж.Галбадрах гишүүн асуулт асууна.

Ж.Галбадрах: Оройн мэнд хүргэе Та бүхэнд.

Бид жилд хоёр удаа хэрэгжилтийн талаар ярьж байгаа. Тэгээд өнгөрсөн жилийн сүүлийн хагас дээр тэр 63 хувийн биелэлттэй гэж гарч ирээд. Тэр нь тэгээд зөвхөн тэр тайлагнасан үзүүлэлтүүдийг авлаа гэдгээр шүүмж дагуулж байсан. Одоо бид 2025 оны эхний хагасынхыг ярьж байна.

Тэгэхээр энэ бас тийм тайлагнасан заалтуудыг авч үзсэн үү гэдгийг нэгдүгээрт асууя. Тэгээд үр дүн маш хангалтгүй гарсан байна. Тэрний шалтгаан нь шалгуур үзүүлэлтүүдийг их тооцож, үр дүнг нь харсан гэсэн тайлбарыг сонслоо.

- ▶ Хуулийн хэрэгжилт 22.8 хувьтай,
- ▶ Их Хурлын тогтоолын хэрэгжилт 31.9 хувьтай,
- ▶ Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт 36.3 хувьтай гэж гарсан байна.

Тэгээд дундаж нь 30.3-тай. Энэ чинь маш их хангалтгүй л үр дүн байна.

Үүний учир шалтгааныг Та бүхэн нэг тайлбарлаж хэлж өгөөч. Юунаас болоод ийм их доогуур гараад байдаг юм? Үүнийг дээшлүүлж болохгүй юу?

Их Хурлаас гаргаж байгаа хууль тогтоолууд нь амьдралд хэрэгжих боломжгүй юмнуудыг гаргаад байгаа юм уу? Эсвэл өөр учир шалтгаан байна уу гэдгийг хэлж өгөөч гэдгийг хүсэж байна.

Дүгнэлтэд журам батлагдаагүй гэдэг үзүүлэлтүүд маш их байна. Тэгээд батлагдах ёстой журам, дүрэм батлагдахгүй бол түүний цаана иргэн, аж ахуйн нэгжүүд байж байгаа. Маш их хүлээлт байгаа. Олон асуудал ужгирдаг.

Тэгэхээр энэ дүрэм журмыг баталж, хурдан болох тал дээр. Одоо энд сайдын манлайллаар л хийх ёстой зүйл гэж бодож байна л даа.

Соёлын өвийг хамгаалах тухай аль 2014 онд батлагдсан байхад дүрэм, журам нь батлагдаагүй. Дүрэм, журам нь батлагдаагүй гээд гарсан байна лээ.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 онд батлагдсан байхад дүрэм, журам нь батлагдаагүй. Дүрэм, журам гарах ёстой байсан.

Тэгэхээр энд сайд нартаа гэдэг юм уу, энэ батлах ёстой хүмүүс дээр ямар арга хэмжээ авдаг вэ?

Тэгээд энд бас их ноцтой юм байна лээ. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг баталсан. Тэгээд үүнтэй

холбогдуулаад 53 дугаар тогтоол гэж Засгийн газарт тогтоолоор 8 заалт бүхий үүрэг, чиглэл өгсөн байсан.

Тэгээд Засгийн газраас өгсөн тайландаа 5 заалт хэрэгжсэн, 1 заалт хэрэгжээгүй гээд ирсэн байсныг харин манай хяналтынхан үзээд 2 заалт нь л хэрэгжсэн юм байна. 4 заалт нь бодит үр дүн гараагүй учраас хэрэгжсэн гэж үзэх боломж алга гэсэн.

Ийм зөрчлүүд хэр их гардаг юм бэ? Энэ бол их ноцтой гэж бодож байна.

Тэгээд энэ заалтыг үзэхээр 53 дугаар тогтоолд 5.1.1-д зааснаар өдрийн хоолны үйлчилгээ –

- бага ангийн сурагчдыг 2021-2022 оны хичээлийн жилд,
- дунд ангийг 2022-2023,
- ахлах ангийг 2023-2024-т хэрэгжүүлнэ гэсэн чиглэл өгсөн байгаа юм.

Тэгэхээр 1 минутаа авчих уу?

Б.Найдалаа: Ж.Галбадрах гишүүнд 1 минутыг нэмж өгье.

Ж.Галбадрах: Яг одоо өнөөдөр бол ерөөсөө л зөвхөн бага ангийн сурагчид маань л үдийн хоолны хөтөлбөрт хамрагдсан байж байгаа шүү дээ.

Тэгэхээр эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлүүд байж байгаа үед тэр дунд анги, ахлах ангийг хамруулах санхүүжилт маань цаашдаа хэзээ тусах юм бэ? Энэ ер нь. Тэгээд хугацааг нь хойшлуулж заахгүй бол одоо энэ чинь тайлан болгон дээр биелэгдээгүй нөхцөл гээд яригдаад явах юм биш үү.

Тэгэхээр энэ дээр Их Хурлын тогтоолыг тодорхой цаг хугацаатай, хүрэх үр дүнд хүргэх дээр Байнгын хороо санаачлан Их Хурлын тогтоолд бас өөрчлөлт оруулж болох уу гэдгийг асуух гэсэн юм.

Тэгээд дараа нь 39.2 гэж нэг заалт байсан. Боловсролын ерөнхий хуулийн. Сургалтын байгууллагын норм, нормативын талаарх журмыг Сангийн яам, Эрүүл мэндийн яамтай хамтарч баталсан гээд. Тэгээд үүнийгээ биелсэн гээд үзсэн байгаа.

Үнэхээр суралцагчдын онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй төсөл гарсан уу? Тэгээд энэ шинэчлэл дээр... /минут дуусав/

Б.Найдалаа: Микрофон 4 хариулна.

Б.Батцэцэг: Ж.Галбадрах гишүүний асуултад үнэлгээтэй холбоотой эсэхийг нь хариулъя. Бусдыг нь яам нэмэх байх гэж бодож байна.

Яах аргагүй хууль тогтоомжийн хэрэгжилтээр журам батлаагүй гэдэг тайлангууд их байгаа. Хэрэгжилт байхгүй гээд.

Тэгэхээр хуулийг нийтлэг байдлаараа дандаа журам батлахаар Засгийн газарт, эсвэл Засгийн газрын гишүүнд үүрэг болгосон заалтууд ихэнхдээ хяналтад авагдаж явж байгаа.

Тэгэхээр яг таны ярьсан шиг тухайн салбарын сайдын манлайлал, эсвэл тухайн захиргааны хэм хэмжээний актыг батлах ёстой төрийн захиргааны байгууллагуудын дарга нарын манлайлал энэ дээр асар чухал гэдгийг бид ганцхан жишээн дээр харж болно.

→ Соёлын өвийг хамгаалах тухай хууль 2014 онд батлагдахдаа 5 журам нь батлагдаагүй байна.

→ Цахим хөгжлийг дэмжих 5 багц хууль батлагдахдаа нийт 5 хуульд 24 журам батлах ёстой байсан. 2022-2023 оны хооронд тухайн салбарын яам нь бүх журмаа Засгийн газраар өөрсдөө батлах зохицуулалтуудаа хийсэн байгаа байхгүй юу.

Одоо энд яагаад байна вэ гээд тайлбар сонсохоор 2014 оноос хойш хэрэгжсэн хууль маань нөгөө чиг үүрэг солигдохдоо яамд хуваагдаж нийлдэг. Тэгэнгүүт энэ манай асуудал биш болсон, тэдний асуудал болсон гээд Засгийн газрын байгууллага хооронд ажил хаягдсан юм байгаа.

Үүнийг бид Засгийн газрын хуралдаан дээр танилцуулсан. Үнэлгээний үр дүн, хувьчлаад байгаа үр дүнд чинь журмаа батлахгүй байгаа асуудлууд ихэнхийг нь эзлээд байна.

Тэгэхээр үүнийгээ салбарын сайдууд анхаараач ээ гэдэг асуудал Засгийн газрын хуралдаан дээр яригдсан. Надад байгаа мэдээллээр Хэрэг эрхлэх газраас сайд нарт, орон нутагт чиглэл өгсөн байгаа. 11 сарын 15-ны дотор буцаж ямар арга хэмжээ авсан талаараа мэдэгдэх ёстой.

Тэгэхээр журам батлагдаад үр дүнд хүрсэн үү гэдэг бас дараагийн асуудал болчхож байгаа юм. Яагаад гэвэл бид журам батлах ёстой зохицуулалтыг л хяналтад авсан. Тэгээд тэрний үр дүнг үнэлэхдээ журам батлагдсан бол 100 хувь, журам батлагдаагүй бол нөгөө 85 хүртлээ хэрэгжээгүй л гэж үзээд байгаа байхгүй юу.

Гэтэл бодит үр дүн Та саяхан яриад байна. Яг үнэхээр тэр шалгуур үзүүлэлт, нөгөө хэрэгцээ шаардлагын гаргасан юунууд нь журам өөрөө тэр зохицуулах ёстой харилцаагаа бүрэн зохицуулж чадаж байгаа юм уу гэдэг дээр бид үнэлгээ өгөхдөө бодит газар дээр нь очих үнэлгээ гэдгээрээ л өгөх гэж хичээж

байгаа юм л даа. Яах аргагүй энэ үр дүнг нь үнэлэх үнэлгээ үгүйлэгдэж байгаа нь үнэн. Түүнтэй би санал нэг байгаа. Үүнийгээ бид сайжруулах гээд ажиллаж байгаа.

Б.Найдалаа: Түрүүн Ж.Галбадрах гишүүний дурддаг Их Хурлын хууль юм байна шүү дээ. Хууль. Хүүхдийн хооллолттой холбоотой хууль дээр Х.Батжаргал дарга тодруулж хариулах байх. Тэр дээр ямар өөрчлөлт хийх гэж байгаа талаар. Микрофон 1.

Х.Батжаргал: Гишүүний асуултад нэмж хариулъя. Х.Батжаргал. Боловсролын яам.

Сая гишүүний асуусан асуулт дээр дурдсанчлан тогтоолын яг тухайн зүйл, заалтын голлох хэрэгжилт хангалтгүй байгаа голлох заалтууд бол яг энэ хүүхдийн хоол, ялангуяа дунд ангид, ахлах ангид тэр тусмаа ингээд нэмэгдүүлж хүүхдийн хоол, үдийн хоолоор хөтөлбөрт хамруулах чиглэл байсан.

Тэгэхээр энэ өөрөө шууд эдийн засаг, санхүүтэй холбоотой. 2026 оны улсын төсвийн төсөл дээр ер нь 240.5 тэрбум төгрөгийг зөвхөн 6-аас 9 дүгээр ангид нэмж оруулъя гэвэл ийм эдийн засгийн эх үүсвэр шаардлагатай болсон. Тэгээд нөхцөл байдлын улмаас бид бодлогын хүрээнд эцэг, эхээс хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын мянган төгрөгийг нэмэлт дэмжлэг байдлаар Улаанбаатар нийслэлд туршилтын журмаар хэрэгжүүлээд амжилттай хэрэгжиж байна. Энэ өөрөө эргээд ирцэд, хүүхдийн хоолныхоо хэрэгжилтэд нэлээн... /минут дуусав/

Б.Найдалаа: Ж.Галбадрах гишүүн тодруулна.

Ж.Галбадрах: Харин тийм. Тэгэхээр энэ журам чинь цаашдаа дунд анги, ахлах ангид хэрэгжүүлэх боломж байхгүй байна шүү дээ. Энэ чинь эдийн засгийн ялангуяа энэ бэрхшээлтэй үед.

Тэгэхээр энэ дээр өөрчлөлт оруулна гэдэг ийм юм байж болох уу гэж асуугаад байгаа юм.

Тэгээд түрүүний тэр 4 номер хариулсан шиг яг журам гарах бол нэг өөр хэрэг. Тэгээд журам яг бодит үр дүн өгч байна уу гэдгийг би тэр сургалтын байгууллагын тэр норм, нормативын журмыг үзээд байна. Тэгээд тэнд 100 хувь биелсэн гээд ороод яваад байна. Тэгтэл үнэхээр тэр норм журам чинь үнэхээр яг тэр суралцагчдынхаа онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй энэ байдлаараа батлагдаад хэчнээн шинээр баригдсан сургуульд ч юм уу, энэ ингээд оров. Одоо норм норматив, сурагчдын тооны даац хэтэрснээс болоод нөгөө биеийн тамирын заал, нөгөө номын сан, нөгөө цайны газар чинь ерөөсөө ашиглалтгүй өөр зориулалтаар ашиглагдаад байгаа. Энэ талаар нэг тайлбар авъя.

Б.Найдалаа: Микрофон 1.

Х.Батжаргал: Хүүхдийн хоолны тухайд нэмэгдүүлээд бид эцэг, эхчүүдээс авах нэмэлт дэмжлэгийг бодлогод тусгаж оруулж явахаас өөр аргагүй ийм шаардлага үүссэн байгаа.

Ер нь нийслэлд өнгөрсөн жил мянган төгрөгийн дэмжлэгээр яваад хэрэгжүүлээд бодитой үр дүн гарсан байгаа. Юу гэхээр зэрэг яг энэ хүүхдийн хоолны хэрэгжилт дээр хэрэгжиж байгаа хяналт илүү сайжраад, эцсийн тайлан дээр 22 тэрбум төгрөгийн хэмнэлтийн бодитой үр дүн гарсан байгаа. Яг ингээд хяналтыг нь өдөр тутам ирцээр нь дүгнэвэл.

Сангийн сайд болон холбогдох салбарын сайд нарын хамтран баталсан норм, норматив дээр гарч байгаа өөрчлөлт бол дахин өөрчлөх хэрэгцээ шаардлага үүссэн байгаа. Тухайлах юм бол энэ жилийн шинэчилсэн норм, нормативаар шинэ барилга, байгууламжийг, сургалтын байгууллагын барилга, байгууламжийг төсөвлөөд явахад нэг хүүхдэд ногдох талбарын хэмжээ тодорхой хэмжээгээр нэмэгдсэнээс болоод түүнийг дагаад... /минут дуусав/

Б.Найдалаа: Микрофон 1. Нэмэлт минут өгье.

Х.Батжаргал: Түүнийг даган гарах хөрөнгө оруулалт нь үндсэндээ хоёр дахин илүү төсөв, эх үүсвэр шаардлагатай болох жишээний.

Тэгэхээр өнөөдөр Боловсролын яаман дээр салбар дундын хамтарсан ажлын хэсэг гаргаад барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Барилга хөгжлийн төв, холбогдох бүхий л байгууллагууд ороод норм, нормативыг эргэж харахаар, тавигддаг нөгөө тусгай шаардлагыг эргэж харахаар. Харьцангуй энэ өөрөө нэгдсэн байдлаар аваад үзэхээр орон нутгийнх нэг өөр байх шаардлагатай болдог. Тухайлах юм бол орон нутгийн газрын нөөц боломж нь арай өөр байдаг. Нийслэл Улаанбаатар хотод зарим тохиолдолд давхарлахаас өөр аргагүй байдаг. Давхарлаж барилгаа барих гэхээр норм, норматив зөрчигдөх ийм эрсдэл асуудал үүсдэг.

Тэгэхээр үүнийг цогцоор нь эргэж харж эргэж өөрчлөх энэ ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Тухайн тайлант хугацааны үр дүнг тодорхой тоо хэмжээгээр илэрхийлээд оны эцэст нэгдсэн байдлаар гаргаж хүргүүлэх бололцоотой байгаа.

Б.Найдалаа: Микрофон 1-ийг нээлттэй байлгаж байгаарай. Х.Батжаргал даргаас асууя, тодруулъя. Сая гишүүдийн асуугаад байгаа юм тэр байна л даа.

Энэ Хоол, хүнсний тухай хууль байна шүү дээ. Дунд ангид хэзээнээс өгөх ёстой байлаа? Микрофон 1-ийг нээлттэй байлгаж байгаарай. Дунд ангид хэзээнээс байсан бэ? Хуулиараа.

Х.Батжаргал: Тухайн тогтоолоор 2025 оноос оруулаад үе шаттайгаар явах ёстой.

Б.Найдалаа: Ахлах анги. Тогтоол юм уу? Хууль гэж ойлголоо. Хууль шүү дээ. Дунд ангид өгөөгүй байгаа юм байна.

Х.Батжаргал: 2023 онд батлагдсан хуулиар.

Б.Найдалаа: Дунд ангид өгөөгүй байгаа юм байна. Ахлах ангид өгнө.

Монгол Улсын хууль байгаа. Тийм ээ. Ээгээд энэ яагаад хэрэгжихгүй байгаа юм? Хэрэгжихгүй байгаа бол энэ чинь болохгүй байна гээд засах талаар яамнаас яагаад, Засгаас ямар ажил хийхгүй байгаа юм? Нэг бол хэрэгжүүлэх ёстой. Нэг бол энэ чинь болохгүй байна гэж хэлэх ёстой байхгүй юу. Үүнийг гишүүд асуугаад байна шүү дээ.

Ийм болохоор хууль баталдаг. Бөөн юм болж байгаад. Хэрэгждэггүй. Тэгээд хэдүүлээ бөөрөнхийлөөд суугаад байгаа байхгүй юу. Та нэг тодорхой хариул даа.

Х.Батжаргал: Тухайн хуулийн заалт маш дэвшилттэй. Хүүхдийн хоол сурах, сурлагын чанарт хүртэл нөлөөлөх гол чухал заалт.

Тэгэхээр бид Боловсролын яам хариуцсан асуудлынхаа хүрээнд үүнийг байхгүй болгох бодлого баримтлах нь бидний хувьд зарчмын хувьд нийцэхгүй гэж үзэж байгаа.

Харин улсын төсвийн бодлоготой уялдуулаад бодлогын арга хэмжээ авч үүнийг илүү хэрэгжүүлэх талаас нь л ажиллах ёстой гэж үзэж байгаа. Зүгээр зарим нэгэн зүйл, заалтыг үе шаттайгаар гэдэг цаг хугацааны хувьд өөрчлөлт оруулах шаардлага байгаа.

Б.Найдалаа: Яг иймэрхүү л жишээнүүд байгаад байна л даа. Хуулиа баталсан байгаа. Бодлого нь зөв. Хууль нь зөв гэж байна. Бүгдээрээ тэгдэг.

Тэгээд яг хэрэгжээд явахаар энэ чинь хууль шүү дээ. Хэрэгжих ёстой. Төсөв байхгүй ч юм уу, цаг нь болоогүй, арай амжсангүй гэдэг шалтгаанаар мэдэхгүй. Яагаад ч юм мэдэхгүй. Эс үйлдэхүй юу, үйлдэхүй юу мэдэхгүй. Гэхдээ ингээд хэрэгжихгүй яваар сүүлд нь хууль нь хэрэгжихгүй. Тэгээд явж явж монгол төрийн нэр хүнд байхгүй, хуулийн нэр хүнд байхгүй болж байгаа юм л даа.

Тэгэхээр энэ дээр гишүүд албан болон албан бусаар ярьдаг. Хэрвээ хууль байгаа бол хэрэгжүүлмээр байгаа юм. Хэрэгжүүлэхгүй бол энэ буруу байна гээд нэмэлт, өөрчлөлтийг нь оруулмаар, засмаар байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг өнөөдрийн ярьж байгаа бид нарын асуудал дандаа энэ л байгаад байна л даа. Тогтоол байна уу, хууль байна уу. Тэгсхийгээд л дундаа хаясан байна. Баярлалаа.

М.Энхцэцэг гишүүн асуулт асууна.

М.Энхцэцэг: Танилцуулга хийсэн Н.Учрал сайддаа баярлалаа. Тэгээд Н.Учрал сайд асуултад хариулах боломжгүй гараад явсан байна л даа.

Тэгээд дээрээс нь Засгийн газрын сайдуудаас ерөөсөө ганцхан Ж.Чинбүрэн сайд л сууж байна. Бусад сайдуудын хувьд энэ хууль тогтоомжийн хэрэгжилт хамаагүй юм байна гэдэг нь харагдаж байна л даа.

Тэгэхээр Монголд мянган сайхан хууль гаргаад хэрэгждэггүй, хуулийн дагуу хийх ёстой ажлаа хийдэггүй гээд олон асуудлууд ярьдаг.

Тэгэхээр өнөөдөр яг үүнийг баталсан тийм үзүүлэлтүүдийг хэдүүлээ сонсоод сууж байна л даа. Хүний хөгжил, нийгмийн бодлоготой холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт 31 хувьтай байна гэдэг маш харамсалтай. Хэдүүлээ ер нь хууль тогтоомж, дүрэм журамгүй нэг ийм ширэнгийн хуулиар амьдраад байгаа юм биш үү. Сая хэд хоногт болж байгаа үйл явдлууд бүгд л яг тийм байдалтай харагдаад байна л даа.

Тэгэхээр үнэлгээ хийж байгаагийн үндсэн зорилго чинь юу юм бэ? Энэ зорилго чинь, энэ хуулиуд яагаад хэрэгжихгүй байгаа юм бэ гэдэг шалтгааныг тогтоох ёстой юм биш үү?

Тэгэхээр энэ шалтгааныг энэ тайлан дээр ерөөсөө тогтоогоогүй. Тэгээд бүх гишүүдийн асууж байгаа асуулт нь ерөөсөө л шалтгаан нь юу юм бэ? Яагаад хуулийн хэрэгжилт ийм бага хувьтай байгаа юм бэ? Үнэхээр Засгийн газрын тэр сайдууд нь хуулиа хэрэгжүүлэхгүй том толгойлоод байгаа юм уу? Эсвэл үнэхээр Улсын Их Хурлаас баталж байгаа тэр хууль нь практик амьдралд хэрэгжихгүй, эсвэл төсөв дээр ачаалал үүсгэсэн, эсвэл сонгогчийнхоо сэтгэлыг татах гэсэн ийм поп хуулиуд батлагдаад байгаа юм уу? Эсвэл энэ хуулийг хэрэгжүүлэх ёстой тэр журмууд нь батлагдахгүй байгаа юм уу?

Үнэхээр Улсын Их Хурлаас батлахдаа маш ерөнхий гуравхан хуудастай хууль батлаад түүнийг дагалдуулаад хар мянган журам гарга гээд залхуу хууль хийдэг. Тэр журмууд нь гардаггүйгээс болоод энэ хуулиуд батлагддаггүй, хэрэгждэггүй. Эсвэл хуулийн хамгийн чухал юм ерөөсөө хуулийн хариуцлагын асуудал.

Үнэхээр тэр хууль дээр байгаа зохицуулалтыг хэрэгжүүлэхгүй бол тухайн сайд, тухайн албан тушаалд ямар хариуцлага хүлээх юм бэ гэдэг нь өнөөдөр хууль дээр ямар байгаа юм бэ?

- Тэр 2017 онд Зөрчлийн тухай хууль батлагдаад манай Монгол Улсын хуулийн бүтцийг алдагдуулсан юм байна гэж харж байгаа.

Бусад улсын бүх хууль дээр хуулийн хариуцлагын хэсэг гээд бүхэл бүтэн бүлэг байдаг. Манайх дээр тэр нь бараг байхгүй болсон. Ерөөсөө л Зөрчлийн тухай хууль.

Тийм ч учраас мянган сайхан хууль батлаад хэрэгждэггүй. Өө.., хээв нэг сайхан гэдгийгээд явж байдаг. Тэр хууль чинь надад ямар хамаатай юм гээд явж байдаг.

Тэгэхээр энэ бүхний шалтгааныг тогтоогоод, энэ бүхнийг байхгүй болгох тэр саналуудыг боловсруулах чинь өнөөдрийн Та бүхний хийж байгаа үнэлгээний ажлын гол зорилго юм биш үү.

Гэтэл энэ үнэлгээний хамгийн эцсийн байдал дээр тэр санал дүгнэлт гээд ганцхан өгүүлбэр. Яах гэж энэ үнэлгээг хийж байгаа гэдэг зорилгоо бид олж харах ёстой байхгүй юу? Шалтгааныг тогтоох ёстой. Тэр шалтгааныг байхгүй болгох саналуудыг дэвшүүлэх ёстой. Хамтдаа хэрэгжүүлэх ёстой. Тэгж байж өнөөдөр магадгүй 31 хувьтай байгаа хуулийн хэрэгжилт ирэх онуудад тэр 50, 60 луугаа очдог юм уу? Үнэхээр... /минут дуусав/

Б.Найдалаа: М.Энхцэцэг гишүүнд 1 минутыг нэмж өгье.

М.Энхцэцэг: Бид цаашдаа процессын шинж чанартай, одоо Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгаланг нь дэвшүүлээд байсан иж бүрэн зохицуулалттай хуультай больё. Тэгж байж тэр хуулиас давсан журмуудын тоог цөөлье, тэгж байж хууль хэрэгждэг болох юм байна гээд дэвшүүлээд байсан зорилго магадгүй энэ дүгнэлтийн нэг хэсэг байх магадлалтай байхгүй юу.

Тэгээд магадгүй тэр хуулийн хариуцлага нь, тэр Зөрчлийн тухай хууль бол буруу байсан юм гэж олон хүн ярьдаг юм билээ. Үнэхээр хариуцлагын хэсэг гэдэг бүлэг байхгүй болсон. Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ. Бол оо. Өөрөөр хэлбэл энэ заалтыг Та хэрэгжүүлэхгүй бол албан тушаалтан Та ийм хариуцлага хүлээнэ гэдэг юм хууль дээр цагаанаар хараар бичсэн байж байж л тэр хууль хэрэгждэг.

Бусад улсын хууль болгон “хариуцлага” гэсэн том бүлэгтэй. Манайх байхгүй болсон юм билээ.

Тэгэхээр энэ шалтгаануудыг тогтоох нь л та бүхний хийгээд байгаа үнэлгээний ажлын чинь гол зорилго юм биш үү? Тэгэхгүй бол бид ирэх онд дахиад л энэ асуудлыг яриад л сууж байна. Яах вэ, 20 хувьтай байна уу, 10 хувьтай байна гээд л амаа ангайгаад л хэлээд сууж байх нь байна шүү дээ.

Б.Найдалаа: М.Энхцэцэг гишүүн нэмж авах юм уу? Үг хэлж байна гэж ойлголоо. Зөв үү? Асуулт биш. Тодруулах юм уу? Дараа нь. Хариулт авъя. Микрофон 4.

Б.Батцэцэг: М.Энхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар. Б.Батцэцэг.

Засгийн газар дахь хяналтын тухай хуулийг батлахдаа анх яг л энэ нөгөө үндсэн концепц нь үр дүнгээ үнэлдэг байя. Одоо хуулиар журам батлах ёстой гэдэг зохицуулалт чинь өөрөө журам баталснаар 100 хувь биелэгдээд байгаа юм уу, эсвэл болохгүй байгаагийнхаа шалтгааныг нээж олж. Шалтгаанаа нээж олчихоод ингэж хэрэгжүүлж ингэж ажлыг сайжруулъя гэдэг үндсэн концепцтойгоор энэ хууль батлагдаж, үүний дагуу Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар байгуулагдаж 2 жилийн хугацаанд. 3 жил хүрэх гэж байна даа. Хугацаанд үйл ажиллагаа явууллаа.

Тэгээд энэ хугацаанд яг үнэлгээтэй холбоотой гарсан ахиц үр дүн гэвэл бас байна. Бид процесс үнэлдэг байж байгаад үр дүн үнэлдэг боллоо. Үр дүн үнэлээд ирсэн чинь бид ерөөсөө бодит үр дүнг биш зүгээр л процесс үнэлж бие биедээ өндөр дүн тавьж явдаг байсан асуудлуудаа засъя гээд нэлээн хэдэн үр дүн гарч байна.

Гэхдээ сайжруулах юм бид бидэнд бий. Нөгөө үнэлгээ хийгээд яваад байсан чинь яг бодитоороо хууль тогтоомж, зорилго зорилтоо гарах болсон шалтгаан нөхцөлөө бүрэн биелүүлж байна уу, үгүй юу гэдэг дээр бид үнэлгээ хийхдээ үнэлгээний арга аргачлалаа сайжруулах зайлшгүй шаардлага шат шат ахиад ирэх тутам тавигдаад эхэлж байгаа. Яагаад ер нь хууль тогтоомж хэрэгжихгүй байна вэ гэдэг дээр. Бид ирүүлсэн тайлан, шалтгаан нөхцөлийг аваад төрийн захиргааны төв байгууллагууд, агентлагуудтай ажиллаад үзэхээр үндсэндээ нийтлэг байдлаар 4, 5 шалтгаанууд л нийтлэгээр дурдагдаад байгаа байхгүй юу.

Нэгдүгээрт, нөгөө тайлагнаж байгаа байгууллага талаасаа төсөв, мөнгө байгаагүй гэдэг шалтгаан хамгийн их дурдагдаж байгаа. Үнэлгээ хийж байгаа байгууллага талаасаа харахаар байгууллага хоорондын дотоодын зохион байгуулалт, удирдлагын менежментийн уялдаа холбоогүй байдал зайлшгүй энэ дээр гарч ирж байгаа.

Хууль хэрэгжих бас нэг үндэс суурь нь яах аргагүй түүнийг дагаж байгаа дүрэм журмууд бүрэн батлагдаж байж бүрэн дүүрэн хуулийнхаа зорилго, зорилтод заасан агуулгаараа хэрэгжих үндэс болдог. Гэтэл одоо Та бүхэнд өгч байгаа тайлан дээр байгаачлан хуулийн журмууд ерөөсөө батлагдахгүй яваад байгаа.

Тэгэхээр үүнийг зохицуулсан нарийвчилсан харилцаа журмаар зохицуулагдана гэдэг маань батлагдахгүй яваад байгаа болохоор тэр хууль дээр хийдэл, тэр хууль дээр зөрчил үүсэх үндэслэл болоод байгаа гэдэг энэ асуудлыг бид Засгийн газрын хуралдаан дээр гаргаж тавьсан.

Тэгээд хууль тогтоомж ч бай, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд ч бай ер нь монгол хүний сайн сайхан амьдрах нөхцөл, боломжийг бүрдүүлж байна уу гэдэгтэй хамаарах учраас бид бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг бодит газар дээр нь очиж үнэлгээ хийе. Энэ бодлого хөтөлбөр санхүүжилтээс болоод гацав уу. Энэ асуудал нь зохицуулалтаас болоод гацав уу, эсвэл ажлаа хийгээгүй төрийн албан хаагчдаас болоод гацав уу гэдэг дээр бид анх удаа үнэлгээ хийх гээд дараагийн 7 хоногт ажлын хэсэг гарах гээд ажиллаж байна.

Хариуцлагын хувьд ажилдаа хайнга хандсан асуудал бол Төрийн албаны тухай хуулиар сахилгын шийтгэл оногдуулах асуудал бас яригдана л даа. Магадгүй энэ дээр Засгийн газрын гишүүд ч юм уу, арай өөр хүмүүс хариулт өгөх ёстой болов уу л гэж бодоод байна.

Б.Найдалаа: Баярлалаа. М.Энхцэцэг гишүүн тодруулна. Нэг удаагийн тодруулга байгаа.

М.Энхцэцэг: Тэгэхээр үнэлгээ хийж байгаа аргачлалаа цаашид сайжруулаад, дараагийн танилцуулга дээр үнэхээр энэ хууль тогтоомжийн хэрэгжилт маш бага байгаа үндсэн шалтгаануудыг маш сайн тодорхойлоод гаргаж ирэх юм байна гэж ойлголоо.

Хоёрдугаарт, тэр шалтгаануудыг байхгүй болгохын тулд бид ямар ажлуудыг хийх нь зүйтэй юм бэ гэдэг саналыг бас боловсруулж орж ирэх юм байна гэж ойлгож байна.

Тэгээд яг үнэхээр үнэн. Улсын Их Хурлын гишүүд ард түмнээ бодсон маш сайхан хууль баталдаг. Гэтэл тэр ерөөсөө хэрэгждэггүй. Тухайлбал Г.Тэмүүлэн гишүүн бусад гишүүдтэй хамтраад өнгөрсөн парламентын үед малчдын нийгмийн асуудлыг шийдэх зорилгоор Малчны тухай хууль баталсан гээд л ярьдаг юм. Тэгээд л түүний дагуу холбогдох журмыг батлахгүй байна. Энэ хууль батлагдахгүй байна. Тэгээд бид чинь хөдөө орон нутгаар яваад ард иргэддээ худлаа хэлсэн болоод байна. Нөгөө хөдөө орон нутгаар явахаар гишүүдээс малчид таны нөгөө яриад байсан сайхан юм чинь хаана байна л гэдэг. Хэлэх үггүй болдог.

Тэгэхээр энэ асуудлыг... /минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүн байна уу? Нэрээ оруулаарай. А.Ариунзаяа гишүүнээр тасаллаа. А.Ариунзаяа гишүүний микрофоныг нээе. Үг хэлнэ.

А.Ариунзаяа: Тийм. Би яагаад үг авч байна вэ гэхээр дахиад Байнгын хороо маань өгсөн үүрэг даалгавраа нэг эргэж харах, тогтоолуудаа дүгнэх ажлын хэсэг хэрэгтэй юм байна гэдгийгээ нотолгоо болгож дахин үг авч хэлж байна. Ийм хүсэлт гаргаж байна гэж ойлгоорой.

Би хугацаа болоогүй гэж дүгнэгдсэн нэг жишээ л Та бүхэнд уншиж танилцуулах гэсэн юм. Тэр нь юу вэ гэхээр жишээлбэл Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль 2021 оны 12 сарын 21-нд батлагдсан. Би сайд байхдаа үүнийг батлуулж байсан юм.

Тэгээд түүнийгээ цахим систем ашиглаж хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрлийг нь олгох, төлбөрийн 50 хувь бууруулах зэрэг тухайн үеийн бодлогуудыг гаргаж байсан. Гэвчиг би яах вэ 2022 оны 7 сард ажлаа өгч байсан. Түүнээс хойш уг нь Засгийн газар нэг журам батлах ёстой байсан. Одоо хүртэл тэр журам нь яг батлагдаагүй байгаа юм байна гэдгийг одоо яг энэ үнэлгээ дээрээс харж байна.

2024 оны 12 сарын 20-нд Улсын Их Хуралд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн барьсан. Тэгээд одоохондоо хэлэлцүүлэхээр хүлээгдэж байгаа учраас хугацаа болоогүй ээ гэсэн ангилалд оруулсан байгаа байхгүй юу. Гэтэл бид эргээд санах юм бол Л.Энх-Амгалан сайд тухайн үед ажиллаж байсан. Яг энэ цахим платформыг ашиглах тухай, системийг сайжруулах тухай хуулийн өөрчлөлт нь танилцуулагдаагүй, явагдаагүй л байхгүй юу. Тухайн үед нийгэмд юу гэж, ярьж юу гэж шуугиан дуулиан боллоо.

Гадаад иргэдийг зөвшөөрөл өгдөггүй болъё, хэмжээ хязгааргүй оруулдаг байя. Үнэ төлбөргүй. Одоо төлбөр ч авдаггүй байя гэж нийгмээр нэг шуугиан биз дээ. Н.Батсүмбэрэл, П.Сайнзориг хэдэн гишүүн тусад нь нэг өргөн бариад л. Араас нь дахиад Л.Энх-Амгалан сайдынх яг адилхан орж ирээд л. Тийм л юм болоод тэр хууль чинь П.Сайнзориг гишүүд нар хуулиа эргэн татсан. Засгийн газар эргүүлэн татаагүй. Одоо ингээд бүтэн жилийн хугацаанд хүлээлтийн байдалтай болчихож байгаа байхгүй юу.

Тэгээд энэ нь хүртэл үнэлгээн дээрээ хугацаа болоогүй ээ гээд дүгнэгдээд, хүлээгдээд байж байгаа. Ийм байдлаараа бид ажил хийсэн болоод, ийм байдлаараа үнэлгээгээ гаргах юм бол яаж манай хууль тогтоомжууд биелэх вэ дээ. Ойлгомжтой шүү дээ.

Тийм учраас хэдүүлээ гол агуулга руу үндсээр нь орж үнэхээрийн тэр ажиллах хүчний тухай хуульд цахим зөвшөөрөлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай хуулийн өөрчлөлт байгаа юм бол Л.Энх-Амгалан сайдын тухайн үед өргөн барьж байсан хуулийг авч үзье. Доторхыг нь харъя.

Үнэхээрийн тийм үг үсэгтэй юм байна уу, үгүй юу? Эс бөгөөс Засгийн газар тэр нэг дуулиан шуугиан болсон хуулиа эргүүлэн тат. Тэгээд яг энэ үүрэг даалгавраараа хүлээсэн үүргээ биелүүлэх хуулийн төслөө оруулж ир. Эсвэл гишүүд бид өргөн барья.

Тэгээд яг зөв тайлбарлаад, зөв агуулгаар нь яваад энэ ажлуудаа гүйцэлдүүлэхгүй бол одоо хүртэл гадаад ажиллах хүчийг оруулж ирэх тэр зөвшөөрөл авахад дахиад л нөгөө цаасан дээрээ нөгөө BUREAUCRACY_[захиргаадалтын тогтолцоо] дээрээ яваад байгаа юм.

Бидний нөгөө хуулиар бий болгосон <https://licence.mn> зөвшөөрлийн цахим хуудсыг хүртэл бий болгосон шүү дээ. 50 хувийг нь хөнгөлсөн. Энэ бодлогууд чинь батлагдсан гэж бодож явж байгаа хүмүүс чинь одоо хүртэл биелэхгүй байгаа юм уу гэдэг том асуултын тэмдэг гарч байна шүү дээ.

Тэгэхээр чинь бидний хуулиудын чанар, биелэлт муу байх нь аргагүй байхгүй юу. Засгийн газар журмаа ч батлаагүй хэвээрээ. 2022 оноос хойш. Ийм л байна. Тэгэхээр хэдүүлээ энэ дээрээ өөрсдөө асуудлуудаа гартаа авъя гэсэн ийм саналтай байна.

Б.Найдалаа: Баярлалаа. А.Ариунзаяа гишүүнд баярлалаа. Би нэг товчхон үг хэлье.

Өнөөдөр яг энэ асуудлыг анх удаа хэлэлцэж байгаа нь маш чухал гэж бодож байна.

Улсын Их Хурлын, ер нь Монгол төрийн гаргаж байгаа шийдвэрүүд тогтоол нь байна уу, хууль нь байна уу хаана очоод яаж гацаж байгаа, хэдэн хувийн биелэлттэй байгаа гээд. Үүнийг хэлэлцэж байгаа нь онцгой чухал гэж бодож байна.

Жишээлбэл, манай Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хүрээнд гаргасан тогтоолынх нь биелэлт гуравны нэг буюу 36 хувь байна. Өөрөөр хэлбэл бөөн юм болоод тогтоол хэлэлцээд, ярилцаад, батлаад, хэрэгжилт нь гуравны нэг. Цаана нь үр дүн нь дахиад хэд байгааг би бүр мэдэхгүй. Бүр бага байж магадгүй байхгүй юу.

Тэгэхээр энэ талаар бид А.Ариунзаяа гишүүний саяын гаргаж байгаа саналыг би дэмжиж байна. Манай гишүүд өмнө нь ярилцаж байхад энэ сэдвийг мөн ярилцдаг.

Тэгээд дараагийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хурлаар Байнгын хорооноос гаргасан тогтоолын хэрэгжилтийг дахиж үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсгийг байгуулна.

Энэ дээр гишүүд ярилцаж байгаад ажлын хэсгийг томилоод маш хурдан хугацаанд бид дүгнэлт өгөх хэрэгтэй байна.

Энэ тогтоолууд нь –

- > дааж давшгүй, биелшгүй тэнгэрийн юм бид батлаад өгсөн юм уу,
- > эсвэл хэрэгжүүлэхгүй байгаа юм уу,
- > эс үйлдэхүй хийгээд байгаа юм уу,
- > эсвэл төсөвгүй болохоор явахгүй байгаа юм уу,
- > эсвэл зүгээр биелүүлэх, хэрэгжүүлэх чадавх нь дутаад байгаа юм уу,
- > эсвэл зүгээр санаатай сөрөөд байгаа юм уу

гэдэг дээр бид дүгнэлт хийх хэрэгтэй.

Тэгэх юм бол дараа дараагийн тогтоол гаргах, ер нь Их Хурлаас Байнгын хорооны ажлыг илүү бодитой, үр дүнтэй болгоход онцгой чухал гэж бодож байна.

Тэгээд энэ бол зөвхөн Их Хурлын ч юм уу, Байнгын хорооны ажлыг хэрэгжүүлэхдээ биш, одоо үүнийг хэрэгжүүлж байгаа Засгийн газар, яамд, төрийн албан хаагчдын ажилд тус нэмэртэй. Хэрэгтэй хэрэггүй ч юм уу, юунаас болсон нь мэдэгдэхгүй, хэрэгжүүлэхэд хэцүү тийм тогтоол шийдвэр, эрхийг багасгах, тал талаас ярьж байгаад Улсын Их Хурлын Байнгын хорооны, ер нь Монгол төрийн гаргаж байгаа шийдвэрүүдийг үр дүнтэй болгох талаас нь тал талаас ажиллах ёстой юм байна. Энэ дээр ямар ч байсан дараагийн хурлаар ирэх 7 хоног гэж бодож байна. Байнгын хорооноос нэг ажлын хэсэг томилж ажиллана.

Ингээд өнөөдрийн хурлын хоёр дахь асуудал буюу хууль тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Танилцуулга хийсэн сайд нар болон ажлын хэсэгт баярлалаа. Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Өнөөдрийн хурал хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 38 минут үргэлжилж, 18 цаг 00 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД